

## Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Нийгэмлэг

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Нийгэмлэг нь Олон улсын тувшинд Эрүү шүүлтээс хамгаалах Европын Тунхаглал болон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколын суурийг тавьсан байгууллага юм. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколд "хорих, цагдан хорих газруудын үйл ажиллагаанд олон улсын болон үндэсний арга хэрэгслийг хослуулан хяналт тавьж болно" гэж дурьсаныг үндэслэн ЭШУСНийгээ нь үндэсний тувшинд **Омбудсмен** ба бусад мэргэшлийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөгчдийг энэ ажилд оролцуулахад түлхэц үзүүлэх, нелвэлх явдалд хувь нэмрээ оруулдаг.

P.O.Box 2267-1211 Geneva 2 – Switzerland  
Tel. +41 (0)22 919 21 70 – Fax +41 (0)22 919 21 80  
Email: apt@apt.ch  
Website: www.apt.ch




## Эмнести Интернэшил

Эмнести Интернэшил нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрхийг дэлхий даяар дагаж мөрдөхийг дэмжин баталгаажуулахын төлөө ЗГ-дыг хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орохыг шаардах, шахалт үзүүлэх, кампанит ажил явуулах, хүний эрхийн боловсрол олгох зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг даян дэлхийн, бие даасан, сайн дурын хеделгээн юм.

Эмнести Интернэшил нь Засгийн газрын зүгээс хүний иргэний болон улсторийн эрхүүдийг зөрчихийн эсрэг тэмцдэг. Гишүүд нь бухий л үзэл санааны хоригдлуудыг суллуулахын төлөө ажилладаг ба улс төрийн хоригдлуудыг түргэн шуурхай, шударга шүүхээр шүүлгэхийн төлөө, цаазаар авах ялыг устгахын төлөө, эрүү шүүлт болон бусад хүнлэг бус хэрцгийн харьцааж шийтгэхийн эсрэг, улс төрийн аллага, "сурагтуй алга болох"-ын эсрэг ажилладаг бөгөөд улс төрийн зэвсэгт бүлэглэлүүдийг хүний эрхийг хүндэтгэхэд, хууль бус аллага, эрүү шүүлт зэрэг хүний эрхийн зөрчлүүдийг гаргахгүй байхад уриалан дууддаг.

Монголын Эмнести  
Интернашион  
email: apt@apt.mn  
www.apt.mn  
Утс/Факс: 324785

ISBN 2-940337-05-5



ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ ХИЙХ МОНИТОРИНГ: ТББ-уудад зориулсан аргачилсан удирдамж



## ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ ХИЙХ МОНИТОРИНГ:

ТББ-уудад зориулсан  
аргачилсан удирдамж

# **ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ ХИЙХ МОНИТОРИНГ:**

---

**ТББ-УУДАД  
ЗОРИУЛСАН  
АРГАЧИЛСАН  
УДИРДАМЖ**



## МОНГОЛ ХЭВЛЭЛИЙН ҮГ

Энэ чухал гарын авлагыг монголын уншигчдад хүргэх гэсэн Монголын Эмнести Интернэшилийн зорилт биелж байгаад нэн баяртай байна.

Эл номыг монгол хэл дээр буулгахад юуны өмнө зохиогчийн санаа, нэр томъёо, хэллэгийг ончтой зөв орчуулах гарцаагүй шаардлага үүдсэн бөгөөд шаардлагад нийцсэн орчуулга хийх, түүнийг хянах хүнийг нэлээд эрэлхийлсний эцэст Хууль зүйн нэр томъёо, хэллэгийн англи-монгол хэд хэдэн толь зохиож, тэрчлэн шорон судлалын анхны номыг монгол бичсэн академич, Монголын Эмнести Интернэшилийн удирдах зөвлөлийн дарга С.Нарангэрэл, гавьяат хуульч, докторант, Монголын эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга хурандаа Р.Оюунбадам нарт бид хандсан билээ. Тэд хэдийгээр ажлын их ачаалалтай байдаг ч гэсэн хүний эрхийг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулах сэтгэл өвөрлөн эл номыг орчуулахаа илэрхийлсэн юм. Ийнхүү академич С.Нарангэрэл, түүний шавь нарын хөдөлмөрийн үр дүнд эл ном та бүхний гар дээр очиж байна.

Удирдамжийн шинжтэй эл гарын авлага Монгол улс дахь албадан саатуулах ба хорих газруудад хүний эрхийг хамгаалах, энэ үйлсэд иргэний нийгмийн төлөөллийг идэвхтэй оролцуулахад үнэлж баршгүй тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Б.Алтантуяа  
Гүйцэтгэх захирал  
Монголын Эмнести Интернэшил

©Анхны хэвлэл 2004 он  
Женев хот  
ISBN 2-940337-05-5  
Монгол хэвлэл 2006 он  
Улаанбаатар хот

---

Орчуулсан: Б.Амарбаясгалан,  
Г.Эрдэнэбат  
Б.Алтантуяа

Хянасан: Академич С.Нарангэрэл  
Гавьяат хуульч Р.Оюунбадам

## ХЭВЛЭН НИЙТЛЭГЧЭЭС

---

Жан Жак Готьеийн үүсгэн байгуулсан Эрүү Шүүлтээс Урьдчилан Сэргийлэх Нийгэмлэг 25 жил гаруй үүсгэн байгуулагчийнхаа санаачилсан энгийн боловч шинэлэг санааг хэрэгжүүлж байна. Энэ нь хүмүүсийг хамгаалахын тулд хүний эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарласан хорих, цагдан хорих газруудын үйл ажиллагаанд хяналт тавих явдал бөгөөд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг хамгийн үр дүнтэй арга хэмжээ болж байгаа билээ. ЭШУС Нийгэмлэг нь Эрүү шүүлт, хүнлэг бус хэрцгий, хүний нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх тухай Европын Конвенц (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай Европын Конвенц)-ийн эхлэлийг тавьсан билээ. Энэ Конвенц батлагдсаны дараа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо байгуулгадж, ямар ч үед Конвенцид оролцогч улсуудын нутаг дэвсгэрт байрлах хорих, цагдан хорих газруудыг шалгаж үзэх эрх, үүргийг хэрэгжүүлдэг болжээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколын эхлэлийг тавьсан бөгөөд түүнээс хойш тухайн Протоколыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Энэхүү нэмэлт Протоколыг 2002 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталсан юм. Эдгээр олон улсын байгууллагууд нь эрүүдэн шүүхийн эсрэг тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч хангалттай гэж үзэх боломжгүй байна.

Хорих, цагдан хорих газруудыг шалгаж үзэх өдгээр олон улсын байгууллагуудын ажлыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Үндэсний түвшинд хараат бус дотоод мониторинг хийх ажил маш чухал болохыг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Протоколоор оролцогч улсуудад “хорих, цагдан хорих газруудыг шалгах эрх бүхий нэг болон хэд хэдэн байгууллага байгуулах, томилох” үүрэг оноогдсон билээ. Үүний дагуу Омбудсмен, парламентийн комиссууд, мэргэшлийн байгууллагууд зэрэг хараат бус янз бүрийн байгууллага, хүний эрхийн зүтгэлтнүүд урьдчилан мэдэгдэлгүйгээр хорих, цагдан хорих газрыг шалгах эрхтэй болсон. Гэвч энэ үйл хэрэгт иргэдийн нийгмийн төлөөлөгчид болон ТББ-үүд хяналтын үнэлж баршгүй хувь нэмэр оруулж болохыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

Төв Европын зарим улс орнуудад ТББ-үүд хорих, цагдан хорих газрыг шалгах хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. ЭШУС Нийгэмлэг болон Европын Зөвлөлийн Хүний эрх ба ардчиллыг хөгжүүлэх товчоо нь тухайн ТББ-үүдүүн туршлагаас үндэслэн бусад байгууллагууд ч ийм хөтөлбөр

боловсруулан хэрэгжүүлж болох юм гэдэг дүгнэлтэд хүрчээ. Үүнтэй уялдуулан эдгээр байгууллагууд төсөл боловсруулж хорих, цагдан хорих газрыг шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа ТББ-уудыг дэмжихээр шийдвэрлэсэн байна. Төслийн эхний шатанд Төв болон Дорнот Европын орнуудад дээрх газрыг шалгах мониторинг хэрэгжүүлж байгаа үндэсний арван ТББ-ын төлөөлөгчдийг урьж Молдавын Кишинев хотод 2000 оны 7 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд семинар зохион байгуулжээ. (Семинаарт оролцогчдын жагсаалтыг 3 дугаар хавсралтын “Үндэсний ТББ-ууд” гэсэн хэсэгт үзнэ үү). Төслийн 2 дугаар шатанд Кишиневт болсон семинарын шийдвэрийг үндэслэн энэхүү аргачилсан удирдамжийг боловсруулан хэвлүүлсэн билээ.

Аргачилсан удирдамжийг ЭШУС Нийгэмлэгийн зөвлөх хатагтай Аннетт Корбаз боловсруулсан бөгөөд тэрээр Олон Улсын Улаан Загалмай Хорооны ажлын хэсэгт багтан хорих, цагдан хорих газруудад мониторинг хийсэн 10 жилийн туршлагатай хүн билээ. Энэхүү удирдамжийг та бидний гар дээр боловсруулан тавьсан зохиогчдод талархал илэрхийлэхийн зэрэгцээ түүнийг англи хэл дээр гайхамшигтай сайн орчуулсан хатагтай Джкулия Бассам де ля Баррерад ч гүн талархал илэрхийлж байна. Мөн Хүний эрх ба ардчиллыг хамгаалах товчооны Хууль дээдлэх асуудал эрхэлсэн ажилтан, ноён Геральд Стаберокод энэхүү төслийг хэрэгжүүлэхэд тусалсанд нь, түүнчлэн Болгарын Хельсинкийн хорооны ноён Крассимир Каневт энэхүү бүтээлийн эхний хэвлэлд нэн хэрэгтэй санаануудыг өгсөнд нь тус тус чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Энэхүү Аргачилсан удирдамж нь Кишиневын семинаарт оролцсон үндэсний ТББ-уудын явуулж буй ажлыг нэг ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг учраас энэ эрхэм чухал ажлаа цаашид үргэлжүүлэхэд нь урам зориг өгч, хөшүүрэг болно гэдэгт найдаж байгаагаа илэрхийлье. Мөн түүнчлэн бусад ТББ-ууд өөрийн улс орондоо мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхэд нь урам зориг өгөх байх гэж найдаж байна. Ингэснээр хорих, цагдан хорих газруудын хаалттай хаалгыг нээж “үл нэвтрэх үзэл санааг гэрэлтэх үзэл санаа” болгох үйл хэрэгт хувь нэмрээ оруулж болох юм.

## БАРБАРА БЕРНАТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгийн Европт зориулсан хөтөлбөрийн зохицуулагч

## ӨМНӨХ ҮГ

---

Хүний эрх ба ардчиллыг хөгжүүлэх товчоо нь Европын Зөвлөлийн бүс нутагт ардчилал, хүний эрхийг хөгжүүлэх чиглэлээр ажилласан 10 гаруй жилийн туршлагатай байгууллага юм. Энэ бүх хугацаанд Товчоо үндсэн зорилгоо хэрэгжүүлэх үүднээс хорих, цагдан хорих, баривчлах гэх мэт газруудыг өөрчлөн шинэчлэх ажлыг хийжээ.

Хүний эрхийн үүднээс авч үзвэл хорих, цагдан хорих газар бол хүний эрхийг зөрчих ноцтой аюул оршиж байдаг нилээд хүндрэлтэй байгууллага юм. Ардчилсан нийгэмд дээрх газруудыг өөрчлөн шинэчлэх нь тухайн чиглэлээр ажилладаг мэргэжлийн хумүүс төдийгүй иргэний нийгмийн сэргэлийг бүхэлд нь зовоосон асуудал байдаг. Тиймээс энэ нь Хүний эрх ба ардчиллыг хөгжүүлэх товчооны үндсэн чиг үүрэг бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Нийгэмлэгээс эрхлэн гаргасан гарын авлага хорих, цагдан хорих газрыг шалгах мониторингийн үйл ажиллагаанд бүрэн чиглэгджээ.

Сүүлийн арваад жилийн хугацаанд бүх төрлийн хорих газруудад хамааралтай хүний эрхийн олон улсын стандартыг хянан үзэж, улам тодорхой болгосон байдаг. Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн нэмэлт Протокол гэх мэт олон тооны баримт бичгээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцаж, шийтгэхээс урьдчилан сэргийлэх талаар үүрэг хариуцлага оноодог. Эдгээр баримт бичигт олон улсын хэм, хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажилд гарч байсан олон цоорхойг нөхөх асуудалд тулхүү анхаарал хандуулсан байдаг.

Мониторингийн олон нийтийн хороод, хүний эрхийн зөвлөгөө өгөх зөвлөлүүд, эсхүл иргэний нийгмийн мэргэжлийн мониторинг нь ажиглалт хийх, баримт материал цуглуулах арга хэрэгсэл болж болох учраас олон улсын стандартыг чанд мөрдөхөд нөлөөлөх юм. Иргэний нийгмийн зүгээс мониторинг хийх нь хүний эрхийг хангах баталгаа болоод зогсохгүй, төрийн бүх шатны байгууллага нээлттэй байх, олон нийтийн өмнө тайллагнахыг шаарддагаараа ардчиллыг бэхжүүлж байдаг гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Энэхүү гарын авлага нь өөрсдийн арга зүйг боловсруулахад удирдамж болох бөгөөд эцсийн дүндээ хорих, цагдан хорих газрын нөхцлийг сайжруулахад тус дөхөм болно гэдэгт бид найдаж байна.

## ХУРААНГУЙЛАЛ

ACHPR	African Charter on Human and Peoples Rights	Хүний ба улс түмний эрхийн тухай Африкийн тунхаглал	ХУТЭАТ
APT	Association for the Prevention of Torture	Эрүү шүүглээс урьдчилан сэргийлэх Нийтэмлэг	ЭШУСН
BPP	Body Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment	Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хумуусийг хамгаалах зарчмууд	ХХЗ
BPTD	Basic Principles for the Treatment of Detainees	Хоригдлуудтай харьцах үндсэн зарчим	ХХҮЗ
CAT	Committee against Torture	Эрүүдэн шүүхийн эсрэг хороо	ЭШЭХ
CPT	European Committee for the Prevention of Torture	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хороо	ЭШУСЕХ
ECPT	European Convention for the Prevention of Torture	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Конвенц	ЭШУСЕК
EPR	European Prison Rules	Европын шоронгийн дүрэм	ЕШД
ICCPR	United Nations International Covenant on Civil and Political Rights	НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт	ИУТЭОУП
ICPR	Inter-American Convention to Prevent and Punish Torture	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэгт ял, шийтгэл оноох тухай Америкийн улсуудын Конвенц	ЭШЭАУК
ICRC	International Committee of the Red Cross	Улаан загалмайн олон улсын хороо	УЗОУХ
NGO	Non-governmental organisation	Төрийн бус байгууллага	ТББ
ODHIR	Office for Democratic Institutions Human Rights	Хүний эрх ба Ардчлалыг Хөгжүүлэх Төвчоо	ХЭАХТ
OHCHR	Office for UN High Commissioner Human Rights	НҮБ-ын хүний эрхийн дээд Комиссарын газар	НҮБДКГ
OPCAT	Optional Protocol to the UN Convention against Torture	НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт протокол	Нэмэлт Протокол
OSCE	Organisation for Security and Co-operation in Europe	Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага	ЕАБХАБ
UN	United Nations	Нэгдсэн Үндэстний Байгууллага	НҮБ
UNCAT	UN Convention against Torture	НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц	ЭШЭК

## ГАРЧИГ

---

Монгол хэвлэлийн уг .....	2
Хэвлэн нийтлэгчээс .....	3
Өмнөх уг .....	5
Хураангуй .....	6
Удиртгал .....	11

### **I БҮЛЭГ: ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН ХОРИХ НӨХЦӨЛД ХИЙХ МОНИТОРИНГ**

1. Удиртгал	
Хоригдож буй этгээдийг хамгаалах.....	15
2. Хорих ял ба хорих нөхцөл.....	16
2.1 “Хорих ял” гэдэг ойлголт юуг илэрхийлдэг вэ?.....	16
2.2 “Хорих” гэдэгт юуг ойлгох вэ? .....	16
2.3 “Хорих нөхцөл ба түүний мониторинг” гэж юу вэ? .....	17
3. Хорих, цагдан хорих газар мониторинг хийх зайлшгүй шаардлага .....	20
3.1 Хорих, цагдан хорих нөхцөлд хийх мониторингийн үндсэн хэрэгсэл нь хохирогчтой уулзах явдал .....	21
3.2 Хорих, цагдан хорих газарт очих асуудлыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга зам .....	22
3.3 Олон улсын түвшинд хорих нөхцөлд хийх мониторинг.....	23
4. Хорих, цагдан хорих нөхцөлд хийх мониторингийн ажиллагаанд үндэсний төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах зайлшгүй шаардлага .....	24
4.1 Үндэсний ТББ-ын давуу тал .....	24
4.2 Олон улсын байгууллагуудын зөвлөмж .....	25

### **II БҮЛЭГ: ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ МОНИТОРИНГ ХИЙХ ХӨТӨЛБӨРИЙН БОЛОВСРУУЛАЛТ**

#### I-Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг бэлтгэх

1. ТББ-ын сонголт хийх урьдчилсан нөхцөл.....	29
1.1 ТББ-ын тухай мэдээ сэлт.....	29
1.2 ТББ-д байгаа нөөц бололцоо.....	30

1.3 ТББ-аас нэн тэргүүнд авах арга хэмжээ.....	30
2. Сүлжээгээр ажиллах: ажлын үр өгөөжийг дээшлүүлэх стратеги.....	32
Хорих газарт нэвтрэх.....	32
1. Зөвшөөрөл авах, хоригдож буй этгээдтэй очиж уулзах.....	34
2. Нэвтрэх зөвшөөрлийн хэлбэр.....	36
3. Зөвшөөрлийн агуулга.....	36
 III – Хөтөлбөр боловсруулах	
1. Уулзалтын хөтөлбөр боловсруулах.....	38
1.1 Газраа сонгох.....	38
1.2 Уулзалт үргэлжлэх хугацаа.....	38
1.3 Уулзалт хийх давтамж.....	39
2. Очиж уулзах баг	
2.1 Бүрэлдэхүүн.....	40
2.2 Багийн хэмжээ.....	40
2.3 Сургалт.....	40
 <b>III БҮЛЭГ: ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН ХОРИХ НӨХЦӨЛД ХИЙХ МОНИТОРИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>	
Удиртгал	
Харьцуулсан стандарт.....	45
I – Хорих, цагдан хорих газарт очих бэлтгэх ажил.....	48
II – Хорих, цагдан хорих газарт очиж ажиллах аргачилал.....	50
1. ТББ-аас хорих, цагдан хорих газарт очиж ажиллахдаа заавал баримтлах зарчим.....	50
1.1 Хоёрдмол санаагүй зан үйл (үг ажил хоёр зөрөх ёсгүй).....	50
1.2 Цагдан хорих үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтанд хүндэтгэлтэй хандах.....	51
1.3 Хоригдож буй этгээдэд хүндэтгэлтэй хандах.....	52
1.4 Мэдээллийг шалгах.....	52
2. Хорих, цагдан хорих газрын даргатай урьдчилан уулзах.....	53
3. Бүртгэлийн тэмдэглэгээг шалгах.....	54
4. Хоригдогсдын байраар очиж үзэх.....	55

<b>5. Хоригдогсодтой ярилцах.....</b>	<b>56</b>
5.1 Нийт дунд нь хийх ярилцлага.....	56
5.2 Ганцаарчилсан ярилцлага.....	56
<b>6. Хорих, цагдах хорих, баривчлах байрны ажилтантай хийх ярилцлага.....</b>	<b>58</b>
<b>7. Уулзалтыг дуусгах.....</b>	<b>59</b>
8. Хоригдсон, албадан саатуулагдсан хүний гэр бүлийнхэнтэй уулзах.....	59
<b>III-Уулзалтын дараах үйл ажиллагаа.....</b>	<b>60</b>
1. Уулзалтын явцад олж авсан мэдээлэл дээр ажиллах.....	60
2. Зайлшгүй хийх ёстой алхам.....	60
2.1 Хорих газарт авсан мэдээллийн баяжуулалт.....	60
2.2 Удирдлагад мэдээлэх.....	61
3. Хорих нөхцөлд хийсэн мониторингийн тайланг боловсруулах.....	61
3.1 Тайлангийн агуулга.....	61
3.2 Тайлан хэнд зориулагдах вэ?.....	62
4. Үйл ажиллагааны бусад боломж.....	63
<b>IV бүлэг: Хорих нөхцөлд хийх ёстой шалгалт</b>	
Хоригдогсодтой харилцах.....	69
Эрүү шүүлт ба хүнлэг бусаар харьцах хандлага.....	70
Ганцаарчлан хорих.....	74
Тусгай хэрэгсэл.....	76
Хамгаалах арга хэмжээ.....	79
Хоригдогсодыг мэдээллээр хангах.....	80
Хяналт шалгалт.....	82
Сахилгын арга хэмжээ.....	84
Гомдол гаргах журам.....	87
Хоригдож байгаа этгээдүүдийг бүртгэх.....	90
Хоригдож байгаа этгээдүүдийг ангилах.....	92
Материаллаг нөхцөл.....	95
Хоол хүнс.....	96

Гэрэлтүүлэг ба агааржуулалт.....	98
Ариун цэврийн нөхцөл.....	100
Хувийн эрүүл ахуй.....	101
Хувцас ба цагаан хэрэгсэл.....	103
Шоронгийн дүүргэлт ба цагдан хоригдож буй этгээдийг байршуулах... ..	105
Дэглэм ба арга хэмжээ.....	109
Гадаад ертөнцтэй холбоо тогтоох.....	110
Боловсрол.....	113
Нарлуулах арга хэмжээ.....	116
Чөлөөт цаг.....	118
Шашин шүтлэг.....	120
Ашигтай хөдөлмөр.....	122
Эрүүл мэндийн үйлчилгээ.....	125
Эмнэлгийн үйлчилгээ авах боломж.....	126
Эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусгай үйлчилгээ.....	129
Боловсон хүчин.....	131
Ажилтан, албан хаагчид.....	135
Нийтлаг үндэслэл.....	136
Шоронгийн ажилтны бэлтгэл, сургалт.....	139
Цагдаагийн байгууллагад саатуулах.....	141
Аюулгүй байдлын үндсэн баталгаа.....	142
Баримтжуулалт.....	145
Байцаалт.....	147
Мэдээлэл.....	149
Материаллаг нөхцөл.....	150
Хавсралт	
Хавсралт 1: Асуултын жагсаалт.....	155
Хавсралт 2: Хорих, цагдан хорих газарт ажилласан тухай тайлан гаргах загвар.....	159
Хавсралт 3: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буую хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол.....	161
Хавсралт 4: Хэрэгцээтэй хаягууд.....	177
Хавсралт 5: Нэмж унших материал.....	182
Хавсралт 6: Олон улсын хэм хэмжээний жагсаалт.....	185

## УДИРТГАЛ

---

“Тусгай илтгэгч би хүний эрхийг хязгаарлан хорих тухай дэлхий нийтийн нийтлэг ойлголтыг үндсээр нь өөрчлөх шаардлагатай гэдэгт бүрэн итгэлтэй байна. Багаар бодоход сүүлийн 100 жилийн турш хүн төрөлхтөн, шорон, цагдаагийн хэсэг, тэдгээртэй адилтгах бусад төрлийн хорих байрууд нь хаалттай, нууц газар байдаг бөгөөд тэнд болж байгаа үйл явдал нийгмээс далд байх ёстой гэж үзсээр ирсэн.... Нэвтрэшгүй нууцлагдмал байх ёстой гэсэн энэ үзлийг нийтэд нээлттэй байх ёстой гэсэн үзлээр солих цаг болжээ. Бүх төрлийн хорих байруудыг нээлттэй болгох, түүнд чөлөөтэй нэвтрэх нөхцлийг хангах явдал нь энэ үзэл санаанаас урган гарч байгаа юм.

**Ноён Найджел Родли**

HYБ-ын Эрүүдэн шүүхийн асуудлаарх

Тусгай Илтгэгч

2001 оны 7 дугаар сарын 3.,

A/56/156, § 35

Аливаа системийн байгууллага олон нийтэд нээлттэй байх, захиргаа, удирдлагад тавих олон нийтийн хяналттай байх гэдэг бол ардчилсан зарчим, хууль дээдлэх ёсонд үндэслэсэн зайлшгүй зүйл билээ. Ялангуяа төрөөс хүний эрхийг хязгаарлан хорих асуудалд төрийн эрх мэдлийг хянах явдал зайлшгүй байх ёстой. Хорих, цагдан хорих газрын нөхцөлд үндэсний түвшинд мониторинг хийх, ялангуяа урьдчилан мэдэгдэлгүйгээр тэнд тогтмол очих нь эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга хэмжээнүүдийн нэг юм. Ийм мониторингийг хараат бус байгууллагууд хийх ёстой бөгөөд ТББ-ууд хорих, цагдан хорих газарт нэвтрэх эрхтэй болох ёстой юм.

Нэвтрэх эрх авах нь мониторингийн хөтөлбөр хэрэгжүүлэхийг хүссэн ТББ-ын анхны зорилт бөгөөд энэхүү хөтөлбөр хэрхэн явагддаг, ямар цар хүрээтэй болохыг зайлшгүй мэдэх нь чухал. Энэ зорилгоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хороо ба Хүний эрх ба ардчиллыг хөгжүүлэх товчоонаос ТББ-уудад мониторингийн хөтөлбөр боловсруулахад нь удирдамж болгох зорилгоор энэхүү номыг бүтээх шийдвэр гаргасан юм.

Энэ удирдамжид мониторингийн хөтөлбөрийг боловсруулах бүх шатанд шаардлагатай зөвлөмж, тодорхой зөвлөгөөнүүдийг багтаасан болно.

**Эхний хэсэгт:** Хорих, цагдан хорих газарт мониторинг хийх зайлшгүй шаардлагын талаар ерөнхий тайлбар өгсөн.

**Хоёр ба гуравдугаар хэсэгт:** Хорих, цагдан хорих газарт хийх мониторингийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг дэлгэрэнгүй тусгасан.

**Төгсгөлийн хэсэгт:** Хорих, цагдан хорих газар очиж ажиллах үед анхаарвал зохих бүх асуудлыг хамарсан олон улсын стандартыг сэдвийн дарааллаар тайлбартай нь оруулж өглөө. Эдгээр стандартын жагсаалтыг Хавсралт 1-д үзүүлсэн.

Таны гарпт өгч буй энэ гарын авлага нь ТББ-ууд хорих, цагдан хорих газарт хийх мониторингийн талаар зөвхөн ерөнхий мэдээллийг өгч байгаа бөгөөд хэрхэвч эцсийн хувилбар биш юм. Энэ нь зөвлөгөө өгч, асуудал дэвшүүлсэн, мөн олон улсын стандартыг заасан практикийн гарын авлага билээ. Энэ гарын авлагыг урьд нь дээрх газрууд дээр мониторинг хийж үзээгүй байгууллагуудад зориулсан боловч мониторинг хийж байгаа байгууллагуудад ч ашигтай байж болно.

## I бүлэг

**ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ  
ГАЗРЫН ХОРИХ НӨХЦӨЛД  
ХИЙХ МОНИТОРИНГ**



## 1. УДИРТГАЛ

### ХОРИГДОЖ БУЙ ЭТГЭЭДИЙГ ХАМГААЛАХ

Хорих, цагдан хорих газарт мониторинг хийх нь хоригдож буй этгээдийг хамгаалах тогтолцооны салшгүй хэсэг юм. Энэ салбарт хүний эрхийг хангах үүрэгтэй төрийн зүгээс хүний эрхийг хамгаалах тогтолцоог бий болгох ёстой.

Хоригдож буй этгээдийн хамгаалалт дараахь байдлаар хангагдсан байна:

---

**1. Үндэсний эрх зүйн бүтцээр;** энэ бүтэц нь хүний эрхийг хамгаалах олон улсын стандартад нийцсэн байх ёстой бөгөөд өөрөөр хэлбэл холбогдох хууль, тогтоомжийг баталж, түүний үндсэн дээр засгийн газар нь бодлогоо тодорхойлж захирамж шийдвэрээ гаргах ёстой.

---

---

**2. Эрх зүйн бүтцийг үр дүнтэй ашиглахаар;** эрхээ хасуулсан хүмүүстэй харилцахдаа хууль болон хэв журмыг сахин биелүүлэх ёстой. Энэ нь дор дурьдсан хүчин зүйлүүдийг хамарна. Үүнд:

- Эрх зүйн бүтцийг олон улсын стандартад хэрхэн нийцүүлэх талаар төрийн бодлогоо нарийн тодорхойлж олон түмэнд өргөнөөр түгзэх
  - Мэргэжлийн ёс зүйг зохих ёсоор эзэмшсэн боловсон хүчинтэй байх
  - Санхүүгийн болон материаллаг нөөцтэй байх
-

3. Эрх зүйн бүтцийг үр дүнтэй хэрэгжүүлэх мониторингийг дараах этгээдүүд хэрэгжүүлнэ. Үүнд:

- хяналтын дотоод алба
- шүүхийн хяналт (шүүгч, прокурор)
- засгийн эрх баригчдаас хараат бус, хяналтын албан ёсны байгууллагууд
- ТББ-ууд
- мэдээллийн хэрэгслүүд

Энэхүү хяналт нь төрийн байгууллагуудын зүгээс зохион байгуулж байгаа ажлын талаар ерөнхий ойлголтыг авах, цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тодорхойлоход нөлөөлнэ.

Дээр дурдсанаар мониторинг явуулах нь хоригдож буй хүмүүсийг хамгаалах тогтолцоог боловсруулж, дэмжих үйл явцын үндсэн арга хэрэгсэл юм.

## 2. ХОРИХ ЯЛ БА ХОРИХ НӨХЦӨЛ

### 2.1. “Хорих ял” гэдэг ойлголт юуг илэрхийлдэг вэ?

Тухайн этгээдийн эрхийг шүүхийн болон захиргааны журмаар, мөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний үр дүнд хасч болно. Шүүхийн журмаар хүний эрхийг хасахдаа мөрдөн байцаалт явуулах шатанд тухайн этгээдэд ноогдох гэм буруугин хариуцлагын байдал, үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөнөөш шалтгаалан хорих ялын дэглэмийг тогтоож хорих анги руу явуулна.

Нэгдүгээр хүснэгтэд хорих ялын төрөл, тэдгээрийн онцлог, хорих ял эдлүүлдэг байгууллага ба түүний төрлийг тодорхой харууллаа.

Гэвч энд дурдсан ялгаа нь бүх тогтолцоонуудад харилцан адилгүй байдаг.

### 2.2. “Хорих” гэдэгт юуг ойлгох вэ?

Тухайн этгээдийг шүүхийн, захиргааны, эмнэлгийн албадлагын арга хэмжээний журмаар хорьж болно.

Шүүхийн арга хэмжээ болгон хэрэглэсэн тохиолдолд дэглэмийн ялгааг гаргаж, ялгамжтай хорино.

“Хорих, цагдан хорих нөхцөл” гэж юуг хэлэх вэ?

Хорих, цагдан хорих нөхцөлд хоригдож байгаа этгээдийн амьдралын бүхий л хүрээг хамруулж ойлгоно. Эдгээр хүрээ нь өөр хоорондоо харилцан уялдаатай бөгөөд харьцангуй авч үзэх ёстай.

- Хоригдож байгаа этгээдийг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа эрх зүйн болон захиргааны арга хэмжээнүүд нь хоригдогчийн амьдрах эрхийг тогтоон баталгаажуулсан, түүнчлэн бие бялдрын хувьд болон сэтгэл зүйн хувьд халдашгүй дархан байх нөхцлийг бүрдүүлсэн байна.
- Давж заалдахтай холбогдсон эрх зүйн болон захиргааны арга хэмжээнүүд нь хоригдогчид өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, өөрийнхөө хувь заяаг шийдвэрлэхэд оролцох боломжийг бүрдүүлсэн байна.
- Хорих ял эдлэх бүх хугацаанд амьдрах нөхцөл.
- Хоригдох журам (хичээлд хамрагдах, гадаад ертөнцтэй холбоо тогтоох)
- Эмнэлгийн тусламж авах
- Хорих ял эдлүүлэх байгууллага, албан хаагчдын зүгээс хоригдлуудтай харилцах харилцаа зэргийг хамааруулж ойлгоно.

### **2.3. “Хорих нөхцөл ба түүний мониторинг” гэж юу вэ?**

Мониторингийн зорилго нь Цагдан хорих, хорих газарт хоригдогчийн амьдрах нөхцлийг буюу дээр дурдсан амьдралын бүх талуудтай холбоотой асуудлыг тогтмол шалгаж байхад оршино.

Мониторингод хийсэн шалгалтын үр дүнгийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд, зарим тохиолдолд хоригдож байгаа этгээдийг хамгаалах ажлыг олон улсын болон үндэсний түвшинд гүйцэтгэдэг бусад байгууллагад, түүнчлэн мэдээллийн хэрэгсэлд амаар болон бичгээр дамжуулах ажиллагаа орно.

## ХҮСНЭГТ 1: ХОРИХ ТӨРӨЛ

Хорих төрөл	Хорих байгууллага	Хорих байр	Шинж чанар
Сэжигтнийг хорих	Цагдаагийн ба агуулгүй байдлыг хангах байгууллагууд	Цагдаагийн хасэг, агуулгүй байдлыг хангах байгууллага дахь хорих байрнууд	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгычны дараа хорих байр</li> <li>• Хорих хугацаа болино, 24-48 цаг байх ёстой</li> <li>• Хоригдсод гадаад өртөнцийг хягаарлагдмал түвшинд харьцаана.</li> <li>• Ижвичтан энд бийцаалт явагддаг.</li> <li>• Хорих нэхцэлөр өрдийн</li> <li>• Сэтгэл хедлэх шамтгаан ихтэй байдгас энэ шатанд хоригдсод их хүнд байдалд байна!</li> <li>• Хамгаалалтын тогтолцоо хэнтэлгүй бол эргүү шүүлт, хэрций, хүнгэг бус, хүний нэр төрийн доромжийн харьцах зэрэг хувь бус харьцаанд, эртэх эрэдэл энэ шатанд маш өнчөр байдаг.</li> </ul>
Яллагддажийг хорих	Хорих системийн бүх байгууллагууд ихэнх тохиолдолд хууль зүйн яаманд, хөвөр тохиолдолд. Дотоод харгийн яаманд, харьяалагддаг.	-Улс бүр яллагдажийг хорих байраа яз бүрээр нарзадэл. -Шоронгийн болгино хугацаагр хорих, урьдилан хорих тасар.	<ul style="list-style-type: none"> <li>• Энд хоригдсод шүүхийн хэлэлцүүлэг, яланы дүгнэлт хүлээж байдгас сэлтэл зүйн хувьд хүнд үе байдаг. Торорхой бус байдгас гадна мөрдөн байцаатын явцын татаар тэдэнд тэр бүр мэдээлдэгтүй уураас хүндрээлэй.</li> <li>• Хорих нэхцэл нь (гадаад өртөнцийг халбоотой байх, ажилжжак сурх г.м.) хорих ангид ялтыг хориос илүү хүнд байдаг.</li> <li>• Энэ хорих, цагдан хорих газарууд нь ижевчирэн дүүрэн байдаг.</li> </ul>

<p><b>Ялтныг хорих</b></p> <p>Хорих анги болон түүний удирдах дээд байгууллага нь Хууль зүйн яаманд харьзалацдааг болон чөлөөт байж болно.</p>	<p>-Улс бүр хорих антия яна бүрээр нэрлэдэг.</p> <p>-Урдчилан хорих төвийн болино хугацаагаар хорих тасаг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хорих нэхцэлийг зохион байгуулж хангахын тулд гэмт хэрэг, зөрчлийн халбэр, хүнд хөнгөний байдал зэрэг олон хүчин зүйлээс шантгаалан дэглэмийг тогтоно.</li> <li>• Дэглэмийг дараахь ангиллаар авч унаа:</li> <ul style="list-style-type: none"> <li>-чанга дэлгэм</li> <li>-“дэвшинтэй”</li> <li>-хагас нээлттэй дэлгэм</li> <li>-нээлттэй дэлгэм</li> </ul> <li>• Дэглэмийг тогтоох нь дараахь хүчин зүйлсээс шалгаална:</li> <ul style="list-style-type: none"> <li>-хорих тухай хувь тогтоомжид тодорхойлох ба түүний хэрэгжүүлэх</li> <li>-албан хаагчдын тоо, тэдний мэргэжлийн бэлтгээ -байгууллагын хэмжээ г.м.</li> </ul> </ul>
<p><b>Захиргааны журмаар саатуулах</b></p> <p>Дотоодд хэргийн яам болон бусад саатуулах</p>	<p></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Захиргааны журмаар саатуулагдсан этгээдэд:</li> <ul style="list-style-type: none"> <li>-шүүхийн шийдвэрлэгүйгээр хоригдсон улс төрийн хоригдгосод хууль бусаар улсын хил зөрчсөн гадаадын иргэд захирагааны шийдвэр болон еөрийнх нь улсад шилжүүлэх шийдвэр гартаа, эсхүгл эрх зүйн байдлыг нь тогтоох хүртэл</li> <li>• Хорих хугацаа тодорхойгүй.</li> </ul> </ul>
<p><b>Сэтгэцийн эмчилэгт хорьж эмчилэх</b></p> <p>Эрүүл мэндийн яам</p>	<p></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сэтгэцийн эмчил судалтын эмчилгүйд Мэргэжлийн институтууд Хорих антид байдал сэтгэцийн эмчилгүйгээ госпиталууд</li> </ul>

### 3. ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ МОНИТОРИНГ ХИЙХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА

Дор дурдсан үндсэн шалтгааны улмаас хорих, цагдан хорих газарт мониторинг хийх шаардлагатай болдог. Үүнд:

- Хорих нь шийтгэлийн хүнд хэлбэр мөн.
- Эрх чөлөөгөө хасуулсан этгээд өөрийнх нь эрхийг хангах, амьдрах, оршин тогтох нөхцлөөр хангуулах асуудлаар түүнийг хамгаалах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бүрэн хамааралтай байдаг.
- Хоригдож байгаа этгээдийн эрхийн зарим хязгаарлалт нь түүний хувь зананд нөлөөлсөн байдаг.
- Хуулинд тодорхойлсноор хорих, цагдан хорих газар нь хаалттай бүс юм. Тиймээс хоригдогч нийгмээс бүрэн тусгаарлагдаж нийгмийн нөлөөллийн гадна үлддэг.

Хорих ял эдлэгсэд нь хоригдож буй газраа ямар ч цаг үед ширүүн догшин харьцаа амсаж, тэр ч бүү хэл эрүү шүүлтэнд өртөж болзошгүй байдаг. Үүнээс үндэслээд хоригдож байгаа этгээдийн хорих нөхцөлд нь мониторинг аргаар тэднийг хамгаалах ёстой.

Гэвч энэ нь хорих, цагдан хорих газруудад заавал хүнд хэцүү асуудлууд байдаг гэх юмуу олон нийт хорих ял эдлүүлэх байгууллагуудад итгэх итгэлээ алдахаар тийм байдал үүсдэг гэсэн үг биш гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Хорих, цагдан хорих газрын ажилтан ба хоригдогч этгээд эрхийн хувьд тэгш бус учраас ажилтан эрхээ хэтрүүлсэн тохиолдолд тэдгээрийн харилцааг хөндлөнгөөс зохицуулах эрх бүхий байгууллагын байнгын хяналтанд байлгах нь зүйтэй. Энэ хяналтын арга хэрэгслийн үр дүнд хэрцгийг догшин харьцах магадлалын түвшин буурч, хоригдогчид авах бүх төрлийн онцгой арга хэмжээг хэрэглэх явдлыг зохицуулахад оршино.

### 3.1. Хорих, цагдан хорих нөхцөлд хийх мониторингийн үндсэн хэрэгсэл нь хоригдогчтой уулзах явдал

Хорих, цагдан хорих нөхцөлд хийх мониторингийн үндсэн арга нь хорих газарт очиж үзэх замаар хэрэгжинэ. Ингэснээр дор дурьдсан чиг үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд

- **Үрьдчилан сэргийлэх чиг үүрэг:** Хөндлөнгийн этгээд хорих газарт тогтмол очиж үзэх нь хоригдогчийг хамгаалахад ихээхэн тус дэм болно. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл хорих, цагдан хорих эрх бүхий байгууллага, түүний удирдлагууд хөндлөнгийн хяналтыг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ. Ингэснээр тухайн хамгаалалтын механизм нь нэн чухал болохыг илтгэнэ.
- **Шууд хамгаалалт:** Хорих орчин руу мониторинг орох нь хоригдлуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чухал боломж юм.
- **Баримтжуулалт:** Олж авсан мэдээ сэлтийг баримтжуулах бөгөөд энэ нь зайлшгүй арга хэмжээ авах дүгнэлт гаргах үндэс болно.
- **Хоригдсон этгээдэд дэмжлэг үзүүлэх:** Тэдэнтэй шууд харилцах харилцаа нь аяндаа тэдэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлнэ. Хоригдогчтой хорих газарт очиж биечлэн уулзсанаар хорих газрын удирдлагуудын зүгээс тэдэнд хангаж чадаагүй материалыг хэрэгцээг илрүүлэн хангах боломж нээгдэх ба түүнчлэн эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжтой.
- **Хорих, цагдан хорих байгууллагын удирдлагатай ярилцлага хийх үндэслэл:** Хорих, цагдан хорих газарт очсоноор түүний удирдлага болон албан хаагчидтай шууд уулзах боломж олддог. Хоёр тал бие биенээ харилцан хүндэтгэж байгаа тохиолдолд ийм харилцаа тогтоох нь тохиолдож байгаа бэрхшээл, түүнийг даван туулахтай холбоотой асуудлаар санал бодлоо солилцоход тус дэмтэй.

### **3.2. Хорих, цагдан хорих газарт очих асуудлыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга зам**

Хоригдогсдын хоригдох нөхцөлд хийх мониторинг нь юуны түрүүнд хоригдогчийн төлөө хариуцлага хүлээдэг үндэсний удирдлагуудын үүрэг юм. Ийм байдлаар НҮБ-аас батлан гаргасан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон этгээдийг хамгаалах тухай үндсэн зарчим”-ын 29-ийн 1-д дурьдсан: “Аливаа нэг хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгээ энэрэнгүй харьцах, хүний хувьд заясан нэр хүндээ хүндэтгүүлэх эрх эдлэх ёстой” гэсэн зарчим хэрэгжинэ.

Ихэнх улс орнууд хорих газруудыг хянах өөрийн гэсэн арга хэрэгсэлтэй болж, түүнийгээ хууль тогтоомж, захирагааны журам заавруудад суулгаж өгчээ. Эдгээр нь ихэвчлэн дотоодын хяналт байдаг. Түүнчлэн дэлхийн олон улс оронд энэхүү дотоод хяналтын арга хэрэгслийг өөрчлөх биш харин гадаад нэмэлт арга хэрэгслүүдийг ашиглан хяналтын үйл ажиллагаагаа өргөжүүлдэг байна.

Үндэсний түвшинд хорих газруудад хараат бус байгууллагуудаар мониторинг хийх зайлшгүй шаардлага нь мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколоор нөхцөлддөг билээ. Энэхүү баримт бичигт дурдахдаа: Оролцогч улс орнууд “үндэсний хэмжээнд эрүүдэн шүүх явдлыг устгах ажлыг үндсэн чиг үүргээ болгосон хараат бус байгууллагуудыг байгуулсан ажиллуулах үүрэгтэй” /17 дугаар зүйл/ гэжээ. Энэ баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2002 оны 12 дугаар сард баталсан бөгөөд 20 улс орон нэгдэн орсноор хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр тогтоожээ.

#### **ХҮСНЭГТ 2: МОНИТОРИНГ ХИЙХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМУУД**

### **3.3. Олон улсын түвшинд хорих нөхцөлд хийх мониторинг**

Олон улсын байгууллагууд саяхнаас хорих газруудад очиж ажилдаг дэвшилттэй арга барилыг нэвтрүүлсэн билээ. Улаан Загалмай Нийгэмлэгийн Олон улсын хороо зэвсэгт мөргөлдөөн болж байгаа газруудын хорих газарт хоригдож байгаа цэргийн олзлогдыг очиж үзсэнээр мониторингийн анхны мандатыг авчээ. НҮБ-ын хүрээнд тогтоосон олон улсын мониторингийн арга хэрэгслийн үр дүнд эрүүдэн шүүх болон хүнлэг бус хэрцгийгээр хандаж байгаа байдлыг орон нутагт нь тодорхойлдог болжээ. Хорих газарт нэвтрэх зөвшөөрлийг тухайн улс олгодог. Өнөө үед Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хороо нь зөвхөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Конвенцийн оролцогч улсуудын нутаг дэвсгэрт буй хорих газруудыг ямар ч үед очиж үзэх бүрэн эрхтэй болсон билээ.

НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг Конвенцийн нэмэлт Протокол батлагдснаар эрүү шүүлтийн эсрэг Хороонд тусгай дэд хороо байгуулагдсан юм. Энэ нь оролцогч улс орнуудын нутаг дэвсгэрт буй хорих газруудыг очиж үзэх бүрэн эрхтэй байх болно. (5 дахь ишлэлийг үз)

## **4. ХОРИХ НӨХЦӨЛД ХИЙХ МОНИТОРИНГИЙН АЖИЛЛАГААНД ҮНДЭСНИЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА**

Үндэсний түвшинд хяналт тавих төрөл бүрийн байгууллагууд байгуулгдаж, онолын хувьд үйл ажиллагаагаа явуулсаар байгаа ч ТББ-уудыг энэ ажилд заавал татан оролцуулах шаардлагатай юм. Учир юу вэ гэвэл үндсэн шалтгаан нь дараах зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

- Төрөөс төрийн байгууллагуудаа хянаж шалгаж байх зайлшгүй шаардлагатай боловч энэ нь хараат байж чаддаггүй.
- Төрийн хяналтын гадаад тогтолцоо нь тэр бүр үр дүнтэй байж чаддаггүй, тэгээд ч тогтмол хийгддэггүй учраас зохицуулах үндсэн үүргээ байнга хэрэгжүүлээд байж чаддаггүй.
- Заримдаа шалгалтыг өнгөцхөн, ёс төдий хийж, хүнд суртлын аппаратыг илүү чухалчилж, захиргааны асуудлыг голчлоод хоригдож байгаа хүмүүстэй харилцах харилцаа, түүний зохион байгуулалт зэрэг хянаж шийдвэрлэхэд түвэгтэй асуудлуудыг хайхрахгүй орхидог.
- Олон улсын байгууллагуудын хийж буй хяналт шалгалт зайлшгүй шаардлагатай байгаа боловч тогтмол байж чаддаггүй.

### **4.1. Үндэсний ТББ-дын давуу тал**

ТББ-дын үйл ажиллагаа хараат бус, эрх мэдэлтэй, ёс зүйг чанд сахих зарчим дээр үндэслэгдсэн, төрөөс эдгээр байгууллагуудад бага ч гэсэн хүлээж авах нөхцөлөөр үйл ажиллагаагаа явуулах баталгаа олговол, энэ үед ТББ-ууд давуу талаа ашиглаж хоригдогчийг хамгаалах үйлсэд бүтцийн томоохон хувь нэмэр оруулах боломжтой юм.

- Тэдгээрийн үндсэн давуу тал нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд
- Хоригдсон этгээдийг хамгаалах ажлыг тухайн улс орныхоо улс төрийн болон нийгмийн байдал ямар ч байсан тасралтгүй гүйцэтгэх боломжтой.
- Үндэсний ТББ-ууд тогтмол үйл ажиллагаа явуулах таатай нөхцлөөр хангагддаг.
- Хорих, цагдан хорих газруудад ноцтой зөрчил гарсан тохиолдолд ТББ-ууд шуурхай мэдэж, зохих арга хэмжээ авах өргөн боломжтой.

### **Нөхцөл байдлыг мэдэх:**

- ТББ-ууд хорих, цагдан хорих газарт хяналт хийх хөтөлбөрийг боловсруулах ба хэрэгжүүлэх нийгэм, улс төр, эрх зүйн ноу-хауг эзэмших нь нээлттэй байдаг.
- Хорих, цагдан хорих газруудтай холбоотой асуудлууд хэрхэн өрнөж байгааг ТББ-ууд нүд салгалгүй ажиглаж байхын тулд олон нийтийн хөгжингүй сүлжээ байгуулж ажиллах чадвартай.
- Хорихтой холбогдон үүссэн асуудлын талаар эрх баригчид, үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ба олон нийтэд мэдэгдэх ашигтай стратегийг тодорхойлох чадвартай.

Ийнхүү үндэсний ТББ-ууд хоёр талт үүрэг гүйцэтгэдэг. Олон нийтийн төлөөлөл гэдэг утгаараа тэд төрийн байгууллагуудын үйл ажиллагаага нүд салгалгүй ажиглаж хянаж байдаг. Түүнчлэн хүний эрхийг хангасан, хүмүүнлэг нөхцөлд хорих асуудалд идэвхтэй нөлөөлж дэмжлэг үзүүлэх чадвартай.

Эцэст нь хэлэхэд үндэсний ТББ-ууд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын болон улс хоорондын байгууллагуудын явуулж буй үйл ажиллагааг хүн амд таниулан өрнүүлэх кампанит ажлыг орон нутгийн түвшинд дэмжих өргөн боломжтой.

### **4.2. Олон улсын байгууллагуудын зөвлөмж**

Тухайн салбарт ажиллаж байгаа олон улсын байгууллагууд: Хорих, цагдан хорих газарт мониторинг хэрэгжүүлэх ажилд ТББ-дыг татан оролцуулах нь маш чухал асуудал гэж үздэг. Олон улсын зарим байгууллагууд ойрын жилүүдээс үндэсний ТББ-дыг хорих, цагдан хорих газарт нэвтрүүлэхийг дэмжиж эхэлжээ.

*Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллага 2000 оны 3 дугаар сарын 27-нд хүнлэг бусаар харьцах асуудлаар Венад хийсэн Нэмэлт зөвлөгөөний материалыаас:*

“Хорих, цагдан хорих газар, тэр дундаа урьдчилан хорих, цагдан хорих газарт хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудлаар ТББ-уудыг бэлтгэж, тэдний үйл ажиллагааг тал бүрээр дэмжиж, зөвшөөрөл олгох нь зүйтэй”.

*НҮБ-ын Ерөнхий Ассамблейн эрүүдэн шүүхийн асуудлаархи тусгай илтгэлээс: A/56/156 2001 оны 7 дугаар сарын 3., 39/e/:*

“Хорих, цагдан хорих газарт явуулж буй байнгын шалгалт, тэр дундаа хорих, цагдан хорих газарт тогтмол очих нь эрүүдэн шүүхийн эсрэг хийж байгаа тэмцлийн хамгийн үр дүнтэй арга хэмжээнүүдийн нэг билээ. Хэнээс ч хараат бус ТББ-уудад ямар нэгэн хязгаарлалт тогтоолгүйгээр хорих, цагдан хорих газрууд, цагдаагийн хэсэг, урьдчилан хорих, цагдан хорих газар, захирагааны баривчлах байр, шоронгуудад нэвтрэх эрх олгож, хорих ял эдлэгсэдтэй хэрхэн харилцаж байгаад болон хоригдож буй нөхцөл байдалд хяналт тавих хэрэгтэй. Шалгалтын явцад мониторингийн хэсгийн гишүүд хоригдогсодтой ганцаарчлан ярилцах боломжоор хангагдах ёстай. Энэ шалгалтынхаа дүнг бүх нийтэд мэдээлж тайлан тавих ёстай.”

Гуравдагч орнуудад эрүүдэн шүүхийг хориглох ба харгис хэрэгжгээр, хүнлэг бусаар доромжлон харьцах, шийтгэх салбарыг Европын Холбооны улсуудын баримтлах бодлогын асуудлаар 2001 оны 4 дүгээр сарын 9-нд гаргасан Удирдамжаас:

“Эрүүдэн шүүхийн эсрэг тэмцлийг явуулахдаа Европын Холбооны улсууд гуравдагч ертэнцийн улс орнуудыг дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- Хорих, цагдан хорих газруудад нэвтрэх үндэсний механизмын үйл ажиллагааг зөвшөөрөх
- Хорих, цагдан хорих газарт иргэний нийгмийн мэргэшсэн төлөөлөгч очихыг зөвшөөрөх”

Хүнийг хэмжих асуудлаар Европын Аюулгүй байдал ба Хамтын ажиллагааны байгууллагын хийсэн Нэмэлт зөвлөгөөн, “Шоронгийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх”, Вена, 2002 оны 7 дугаар сарын 8-9.

“Европын Аюулгүй байдал ба Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын бүх төрлийн хорих, цагдан хорих газарт иргэдийн нийгмийн оролцоотойгоор хэрэгжүүлж байгаа мониторингийг хөхүүлэн сайшааж байна.”

“Европын Аюулгүй байдал ба Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнууд хорих, цагдан хорих газрууд, урьдчилан хорих газрууд болон цагдаагийн хэсгүүдэд ТББ-уудаар мониторинг хийлгэх эрх зүйн үндсийг бий болгох боломжийг судлах нь зүйтэй. Эрх зүйн тодорхой тогтоосон үндэслэл байхгүй тохиолдолд эрх баригчид өөрийн хууль тогтоох эрхийг хэрэгжүүлж иргэдийн нийгмийн зүгээс мониторинг хийлгэх асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.”

## II бүлэг

**ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ  
ГАЗАРТ ХИЙХ  
МОНИТОРИНГИЙН  
ХӨТӨЛБӨРИЙН  
БОЛОВСРУУЛАЛТ**



## I. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БЭЛТГЭХ

---

### 1. ТББ-уудад сонголт хийх урьдчилсан нөхцөл

Тухайн байгууллага хүний эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлахтай холбоотой асуудлаар арга хэмжээ зохион байгуулдаг эсэхээс үл хамааран хорих, цагдан хорих газарт нэвтрэх боломж олохын тулд хэд хэдэн асуудалд хариулт өгөх нь зайлшгүй чухал.

Таны өмнө одоо дэлгэж байгаа асуудлууд бүрэн биш ч гэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад тусална.

#### 1.1. ТББ-уудын тухай мэдээ сэлт

Юуны өмнө мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл олж авахын тулд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд зорилгоо танилцуулж итгэл олж авахаас ажлаа эхэлнэ. Иймд хэний эрхийг хангахын төлөө юу хийх тухай мэдээлэх учиртай.

---

Мэдээлэлд дараах асуудлуудыг хангалттай тусгаж, баримтжуулан дэлгэрэнгүй тайлбарлах ёстой. Үүнд:

- Тухайн ТББ-ын үндсэн зорилго, зорилт  
Үнэ цэнэ
  - Ажлаа явуулдаг арга ажиллагаа  
Эрх хэмжээний хүрээ
-

## 1.2. Тухайн ТББ-уудад байгаа нөөц бололцоо

Хорих, цагдан хорих нөхцөлд хийх мониторинг тогтмол явагдаж чадвал хоригдсон этгээдийг хамгаалах үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх хэрэгсэл болно. Үүний тулд урт хугацаанд тооцоолсон ажиллах хүчний болон санхүүгийн хангалттай нөөцтэй байх шаардлагатай.

---

Тавьсан зорилгоосоо шалтгаалан ТББ нь хангалттай нөөцтэй байна.

- Ажиллах хүчний нөөц: Хорих, цагдан хорих газарт дахин давтан очиж ажиллах, мөн яаралтай дуудлагаар очиждэг бэлэн байх орон тооны болон түр ажиллагсад хангалттай байх
  - Мэргэжлийн ур чадвар: Хоригдогсодтой холбогдолтой хууль зүй, эмнэлгийн, нийгмийн болон материалын талын асуудлыг шийдвэрлэх чадвартай байх
  - Тухайн ТББ нь тодорхой хугацааны туршид хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц санхүүгийн нөөцтэй байх ёстой.
- 

## 1.3. ТББ-аас нэн тэргүүнд авах арга хэмжээ

Хорих, цагдан хорих нөхцөлд мониторинг хийх асуудлыг үндэсний түвшинд шийдвэрлэх нь зөвхөн эрх баригчдын зүгээс бодлогын хувьд шийдмэг алхам хийхийг шаардаад зогсохгүй ТББ-аас тэр бүр эзэмших боломжгүй их хэмжээний хөрөнгө, хүч шаардаг асуудал юм.

Тиймээс ТББ тэргүүн зэргийн зорилтуудаа тодорхойлж, хийх гэж буй ажлынхаа хүрээ, байгаа нөөц бололцоо, хүний эрхийг хамгаалах салбарт явуулж буй үйл ажиллагаанд нь эрх баригчдын зүгээс хандаж байгаа хандлага болон энэ салбарт бусад байгууллагуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд нийцүүлэн өөрсдийн зарим үйлдлээ хязгаарлах хэрэгтэй.

Хоригдсон, гадаад өртөнцөөс таслагдсан хүмүүс хүчирхийлэлд хамгийн өртөмтгийг байдаг. Иймд тэр орчинд орж ажиллах нь мониторингийн нэн тэргүүний зорилго байх ёстой.

Анхдагч арга хэмжээнүүдийг бүрэн тодорхойлж чадаагүй боловч юуны түрүүнд анхаарал хандуулах асуудлуудад суурилах хэрэгтэй юм. Үүнд:

---

**Хоригдогсдын категори:**

- Нас
  - Хүйс
  - Үндэс угсаа
  - Хорих төрөл Хүснэгт 1-ийг үз
- 

**Хорих, цагдан хорих явдлыг хэрэгжүүлж буй эрх бүхий төрийн байгууллага:**

- Дотоод яам: цагдаа, аюулгүй байдлын алба, цагаачлалын алба
  - Хууль зүйн яам: эрүүгийн мөрдөн байцаах газар, хорих, цагдан хорих газрын удирдлага
  - Батлан хамгаалах яам
- 

**Бусад байгууллагын үйл ажиллагаа:**

- **Хэн?** Хоригдогсодтой холбоотой асуудал дээр ажиллаж байсан бэ?
  - **Хэний төлөө?** Тэд хоригдогсдын ямар төрлийг илүү сонирхож байна вэ?
  - **Яагаад?** Тэдгээрийн зорилго юу вэ?
  - **Яаж?** Тэд ямар арга барилаар ажиллаж байгаа вэ?
  - **Хичнээн?** Тэдний үйл ажиллагааны хүрээ ямар вэ?
  - **Хаана?** Тэдний үйл ажиллагаа явуулж байгаа газар нутгийн хүрээ?  
Тэрхүү ТББ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөт зорилт нь бусад гүйцэтгэгч нарын зорилтыг баяжуулж байна уу, эсхүл ижил үйл ажиллагаа явуулж байна уу гэдгийг тодорхойлж зорилго, зорилтоо өөрчлөх эсэхээ шийдвэрлэнэ.
-

---

### **Нийгэм, газар зүйн шалгуурууд:**

- Асуудалтай байгаа бүс нутаг
  - Гол хот, ба хүн ам төвлөрсөн хэсэг
- 

## **2. СҮЛЖЭЭГЭЭР АЖИЛЛАХ: АЖЛЫН ҮР ӨГӨӨЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИ**

ТББ-ууд хүний эрхийг хамгаалах хөтөлбөрийнхөө үр дүнг дээшлүүлэхийн тулд сүлжээгээр ажиллах аргыг стратегтаа оруулах нь зүйтэй.

Ажлын энэ арга барил нь хоригдогсодтой ямар нэгэн байдлаар холбоотой ажилладаг бусад байгууллага, институт, төрийн бус бусад байгууллагуудтай ажил хэргийн холбоо тогтоохыг шаардана.

---

### **Чадавхи бүхий хамтрагч:**

- Эрх зүйн салбарт ажиллаж буй үндэсний ба олон улсын ТББ
  - Буяны болон шашны байгууллага
  - Бүс нутгийн байгууллага:
  - Европын Зөвлөл /ЭШУСЕХороо/
  - Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллага
  - НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд:
  - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
  - ЮНИСЕФ, аливаа хэлбэрээр хоригдож буй хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудал эрхэлдэг байгууллага
  - НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссар (Дүрвэгсдийг хамгаалах хөтөлбөр)
-

---

**Үйл ажиллагаанд бусад ТББ-ыг ямар нэгэн хэмжээгээр татан оролцуулах ажиллагаа:**

- Ерөнхий мэдээлэл солилцох: танилцах ба өөрийгөө танилцуулах
  - Нийтлэг болон тодорхой асуудлуудаар шийдвэр гаргах зорилгоор хүчээ нэгтгэх
  - Ажилд бие биенээ харилцан нөхөж баяжуулах
    - Ажлынхаа хүрээг хуваарилах
    - Улс төрийн болон практик дэмжлэг үзүүлэхүйц бусад байгууллагуудыг эрж хайх
    - Нийтлэг болон тодорхой асуудлуудаар зохицох: ерөнхий байр суурь, стратеги тодорхойлох
    - Хөтөлбөрүүдээ хамтатгах, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах
-

## II. ХОРИХ ГАЗАРТ НЭВТРЭХ

---

### 1. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ, хоригдож буй этгээдтэй уулзах

Зарим улс орнуудад ТББ болон иргэний нийгмийн төлөөлөгчдөд хорих, цагдан хорих газарт нэвтрэх эрх олгох асуудлыг хууль, тогтоомждоо шийдвэрлэж өгсөн байдаг. Энэ нь зарчмын хувьд ТББ-үүд хорих, цагдан хорих газарт нэвтрэхийн тулд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүйг харуулж байна. Гэвч тэд ямар ч үед хорих, цагдан хорих газарт очиж хоригдгчтой уулзалт хийх явцын талаар хэлэлцэж тохиорох ёстой. Хууль зүйн хувьд ийм таатай нөхцөл бүрдэж байгаа нь эрх баригчдын хандлага ямар байгаагаас үл хамааран тохирсон цагтаа хорих, цагдан хорих газарт нэвтрэх давуу талтай боловч нөгөө талаас нь авч үзвэл ТББ эрх баригчидтай шууд холбогдож эрх авахдаа хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай хугацаа авахаар тохирч болох атал хуулиар хязгаарлагдсан цаг хугацаанд хашигдаж болзошгүй юм.

Зарим тохиолдолд тодорхой бүлэг хоригдогсодтой уулзах зөвшөөрлийг хорих байгууллагын захиргаанаас авч болдог. Албан ёсны бус, хязгаарлагдмал уулзалтууд нь хоригдож буй этгээдэд ашигтай, бас хүнд хэцүү тохиолдолд хэрэгтэй байдаг.

Гэхдээ иймэрхүү уулзалтууд нь мониторингийн арга хэрэгслийг зохих ёсоор тогтоо бүрэн боломжгүй учраас энэ асуудлыг энд хөндөхгүй.

Ихэнх тохиолдолд ТББ хоригдож буй этгээдтэй тогтмол уулзалт хийх зөвшөөрлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих явдал зайлшгүй чухал. Иймэрхүү зөвшөөрлийг дээд шатны байгууллага яамнаас нь авах нь хялбар байдаг. (Хүснэгт 1-ийг үз)

Маш олон хүчин зүйлээс шалтгаалан хамгийн сайн стратегийг сонгож авах ёстой. Эдгээр хүчин зүйлүүд нь: ТББ, өөрийнх нь үйл ажиллагааны шинж чанар, үр бүтээл, цар хүрээ, хорих, цагдан хорих байгууллагын удирдлага зэрэг юм. Тиймээс тэр бүхнийг өгүүлэлгүй ТББ зайлшгүй шаардлагатай зөвшөөрөл авахын тулд эрх баригчидтай уулзах уулзалтад хэрхэн бэлтгэх талаар туслахыг хичээе.

### **Асуулт – хариулт**

ТББ нь хэрэв эрх баригчид мониторинг хийх зөвшөөрлийг ТББ-д олговол хоригдож буй этгээдийн нөхцөлд болоод эрх баригчдад ямар тодорхой ашиг гарах вэ? гэдэгт анхаарлаа хандуулна.

Тухайлбал:

- Хүнд хэцүү, түвэгтэй асуудлыг шийдвэрлэхэд төрд туслах
- Эдгээр байгууллагын ажлыг хөндлөнгөөс ажиглах нь олон нийтийн үл итгэх байдлыг бууруулж, сөрөг цуу яриаг сарниулах
- Хорих, цагдан хорих газарт мониторинг хийх зөвшөөрөл олгосноор хүний эрхийг хүндэтгэх, хууль тогтоомжийг сахин биелүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ болох түүнийг хэрэгжүүлснээр төрийн гадаад, дотоод нэр хүнд дээшлэх

---

### **Хараат бус шинжээчдийн оруулж байгаа хувь нэмэр ТББ-ын байр суурийг бэхжүүлэх үү?**

- Хоригдогсодтой холбоотой асуудлаар мэргэжлийн түвшинд ажиллагсад
  - Нийгэм, улс төрийн хүрээнд зохистой байр суурь эзлэгсэд
  - Эдгээр хүмүүс тухайн ТББ-ын нэрийн өмнөөс эрх баригчидтай уулзаж лобби хийж чадах уу?
- 

### **ТББ-ын нөөц стратеги:**

ТББ-ын хөтөлбөр хэрэгжих газарт нэвтрэх зөвшөөрөл олгоогүй тохиолдолд ТББ-д нөөц стратеги бий юу?

- Эрх баригчдыг байр сууриа өөрчилтэл нь лоббидох
- Хэрэгжүүлэх хөтөлбөрийн нэг буюу хэд хэдэн зүйлийг өөрчлөх
  - Θөр хоригдогчийг сонгох, өөр хорих, цагдан хорих газар сонгох
  - Хөтөлбөрийн хамрах хүрээг хязгаарлах
  - Эрс татгалзал авсан хоригдогчтой уулзах хүсэлтээ хойшлуулах, мониторингийн ажлаа үргэлжлүүлэхийн тулд хоригдогчийн боломжтой хэсэгтэй нь уулзах асуудал тавих

## 2. НЭВТРЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХЭЛБЭР

Хоригдогсодтой уулзах эрх олгох албан ёсны зөвшөөрөл нь аман ба бичгийн хэлбэртэй байж болно.

Бичгийн хэлбэртэй зөвшөөрөл нь хорих газарт очих үед хүндрэл учруулдаггүй сайн талтай. Хорих газрын аль нэг ажилтан хориг саад хийвэл үзүүлэх нотлох баримт болж чадна. Тиймээс бичгийн хэлбэртэй зөвшөөрөл нь зайлшгүй зүйл байдаг.

Ялангуяа зөвшөөрөл олгосон байгууллагаас эхэн үед шийдвэр гаргах эрхтэй төлөөлөгч уулзалт хийхэд нь хүндрэл тохиолдвол ТББ-ыг хорих, цагдан хорих газартай холбож өгдөг сайн талтай.

## 3. ЗӨВШӨӨРЛИЙН АГУУЛГА

Зөвшөөрөл нь ерөнхий ба дэлгэрэнгүй байж болно. Дэлгэрэнгүй зөвшөөрөл нь ТББ-аас хорих, цагдан хорих газарт нэвтрэх, мониторингоо хэрэгжүүлэхэд найдвартай баталгаа болдог. Тиймээс анхнаасаа цаг зав хайрлалгүй хөөцөлдөж дэлгэрэнгүй зөвшөөрөл авах нь дээр. Үүний тулд цаг хугацаа их зарцуулдаг боловч цаашдаа хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг, хүч хэмнэж өгөх ач холбогдолтой.

ТББ нь тодорхой тохиолдолд үүссэн нөхцөл байдалтай уялдан эрх мэдэлтнүүд зөвшөөрөл олгох нь зүйтэй гэж үзсэн үед нэвтрэх зөвшөөрлийг авч болно. Татгалзал ба хязгаарлал нь аливаа хүндрэлийг бий болгодог бөгөөд хорих, цагдан хорих газрын бүрэн эрхт төлөөлөгчөөр дамжуулан газар дээр нь хүндрэл бэрхшээлийг арилгах нь чухал.

**Хорих газарт очих зорилго нь юуны түрүүнд хоригдогсодтой уулзах зөвшөөрлийг авахад оршино. Хорих газрыг дэмий очиж үзэх нь ажилд нэмэр болохгүй.**

**Зөвшөөрөл нь дор дурдсан баталгааг танд олгож байх ёстой.**

---

**Үүнд:**

- ТББ-ын хөтөлбөрт тусгагдсан хорих, цагдан хорих газруудын бүх хоригдогчтой уулзах эрх олгосон байх.
  - Хязгаарлалт тавигдаагүй байх ёстой.
  - Хоригдогчид байдаг бүх газарт орох зөвшөөрөлтэй байх. /амьдрах байр, гол тогоо, бие засах газар гэх мэт/
  - Хоригдож байгаа хүсэлт гаргасан этгээд мониторинг хийж байгаа хүмүүсийн зүгээс сонгож авсан хоригдогчтой ганцаарчлан уулзах боломжтой байх / боломжтой бол хорих, цагдан хорих газрын албан хаагчдаас тусгаарлагдсан орчинд, тэдэнд сонсдохооргүй ярилцах/. Түүнчлэн ярилцлагад оролцсон хоригдож байгаа этгээд ярилцлагын дараа ямар нэгэн байдлаар хорих, цагдан хорих газрын алба хаагчдын зүгээс дарамт, шахалт, сүрдүүлгэнд өртөхгүй байх талаар зөвшөөрөл олгосон эрх баригчид баталгаа гаргасан байвал зохиистой.
  - ТББ дэвшигүүлсэн зорилгоосоо шалтгаалан хорих, цагдан хорих газарт очиж ажиллах хугацааныхаа давтамжийг өөрөө тодорхойлох боломжтой байх.
- 

**Ялангуяа дор дурдсан асуудлаар эрх баригчид онцгой зөвшөөрөл олгох ёстой. Үүнд:**

- Хорих, цагдан хорих газарт очиж ажиллахдаа очих цаг хугацаагаа заавал урьдчилан мэдэгдэх албагүй, ямар ч нөхцөлд богино хугацаанд saatuuulalgүй нэвтрүүлэхийг зөвшөөрөх. Заавал урьдчилан мэдэгдэх шаардлагатай бол урьдчилан мэдэгдэх хугацаа нь хэдхэн өдрөөс хэтрэх ёсгүй.
  - Хоригдогчийн хорих нөхцөлтэй холбоотой хөтлөгддөг бүх төрлийн бичиг баримттай танилцах зөвшөөрөл байх нь зүйтэй.
-

## III. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

---

### 1. УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

Уулзалтын хөтөлбөрт дараах зүйлсийг оруулна. Үүнд:

- Тухайн ТББ-ын зорилтын хүрээнд хамрагдаж байгаа, эрх баригчдын зөвшөөрөл олгосон хоригдогчид болон хорих, цагдан хорих газруудын жагсаалтыг гаргана.
- Хорих, цагдан хорих газарт очиж ажиллах журмыг тогтооно.
- Уулзалт бүрийн хугацааны үргэлжлэл.
- Уулзалтын давтамжийг тодорхойлно.

#### 1.1. Газраа сонгох

---

**Уулзалт хийх газраа дараах шалгууруудын үндсэн дээр сонгоно. Үүнд:**

- Эрсдэлийн түвшин: хоригдож байгаа этгээдэд тохиолдож болзошгүй болон тохиолдож буй аюул бий эсэх
  - Эхний ээлжинд мөрдөн байцаалт явуулж байгаа газрууд
  - Илүү аюултай бус нутаг, хот, дүүрэгт байрлаж буй хорих, цагдан хорих газрууд, хоригдогчдын тоо
- Загвар болохуйц улсын хэмжээний хорих, цагдан хорих газрууд буюу улс орны байдлыг бүхэлд нь хамгийн их тодорхойлж чадах тийм газрыг сонгох

---

#### 1.2. Уулзалт үргэлжлэх хугацаа

Уулзалтын явцад хорих, цагдан хорих газрын удирдах ажилтан, албан хаагчид болон зарим хоригдсон этгээдтэй ярилцаж хорих нөхцлийг үзэж танилцахад боломжтой хангалттай хугацаа байна.

Гэвч энэ уулзалт нь хорих, цагдан хорих газрын албан хаагчийн ажилд саад учруулах, зөрчил үүсгэх боломжтойг мартаж болохгүй. Тиймээс уулзалтын үргэлжлэх хугацаа нь нэг талаас мониторингийг үр дүнтэй явуулахад хангалттай байхаас гадна тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад хийхээргүйгээр тогтоогдсон байвал зохино.

Уулзалтын үргэлжлэх хугацаа дараах хүчин зүйлүүдээс шалтгаална. Үүнд:

- Хорих, цагдан хорих газарт ажиллах багийн гишүүдийн тоо
- Иймэрхүү очиж уулзах явдлыг дагалдсан сэтгэл хөдлөлийн хэр хэмжээнээс;
- ТББ ба эрх баригчдын хооронд байгуулсан зөвшилцэл.
- Энэхүү зөвшилцэл төрөл бүрийн хориг, хязгаарлалт хэр зэрэг байгаагас бас шалтгаална.
- Уулзалт зохион байгуулах гэж байгаа хорих, цагдан хорих газрын тухай мэдээлэл хэр зэрэг байгаа эсэх.
  - Энэ хорих, цагдан хорих газарт урьд нь өөр ТББ ажиллаж байсан эсэх
  - Уулзалт хийх хугацааг тогтоохдоо гуравдагч этгээдээс мэдээлэл авсан эсэх?
- Тухайн хорих, цагдан хорих газрын цар хүрээ, хоригдгчийн тоо.
- Тухайн хорих, цагдан хорих газрын дэглэмийн ялгаа
  - Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ /дэглэм хүнд байх тусмаа хорих ангид ажиллах хугацаа сунана/
  - Нэг хорих ангид олон төрлийн дэглэм бий эсэх?
- Хэрвээ тийм бол өөр өөр нөхцөл байдлыг шалгаж үзэхэд илүү цаг хугацаа шаардагдана.
- Уулзалт дууссаны дараа авсан мэдээллээ маш шахуу хугацаанд боловсруулах ёстой.
- Нилээд өргөн хүрээтэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бол хорих, цагдан хорих газруудын хооронд явах хугацаагаа бас тооцоолох ёстой.

### 1.3. Уулзалт хийх давтамж

**Уулзалт хийх давтамжийг тодорхойлохдоо дараах зүйлсийг тооцож үзнэ. Үүнд:**

- Хорих, цагдан хорих газрын дэглэмийн ялгаа
- Урьдчилан хорих газар, жишээ нь, цагдаагийн хэсэг зэрэг мөрдөн байцаалт явуулдаг газруудад бусад газраас илүү олон удаа очих шаардлагатай.
  - Хоригдогсдын гадаад орчинтой харилцах харилцаа хязгаарлагдмал байдаг.

- Албадан саатуулагдагсдын хувьд хөдөлгөөн нь хурдан явагддаг.
- Хоригдож буй этгээдэд тохиолдож болох эрсдэлийн түвшин өндөр буюу эрсдэл байж болох талтай, эсхүл байгаа нь тодорхой болсон. Хамгаалалт хийх шаардлагатай асуудал байгаа нь мэдрэгдсэн.
- Уулзалт хийх тоог нэг талаас ТББ-ын ашиг сонирхолд нийцүүлэн, нөгөө талаас тухайн хорих, цагдан хорих газрын ажилтнуудын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байхаар бодож тооцоолно. Богино хугацаанд олон удаа очиж, хорих байгууллагын ажилтныг онцгой бус шалтгаанаар ажлаас нь хөндийрүүлснээр сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

---

Очиж уулзах давтамж нь хамгаалах асуудлаар илэрсэн, эсхүл ноцтой зөрчил илэрсэн байдлаас олон талаар шалтгаална. Хэрэв ТББ-ын ярилцлагад орсон хоригдолд цээрлүүлэх арга хэмжээ хэрэглэж болох үндэслэлтэй буюу үндэслэлгүй сэргэлт байгаа бол заримдаа давтан уулзах цаг хугацаа богинохон байх нь зохимжтой байдаг.

## 2. УУЛЗАЛТ ХИЙХ БАГ

### 2.1. Бүтэц

Хорих, цагдан хорих газарт мониторинг хийхийн тулд тодорхой туршлага эзэмшсэн байх ёстой. Жишээ нь эрх зүйн болон эмнэлгийн салбарт олж авсан дадал туршлагатай байх г.м.

Уулзалтын багт хамгийн багаар бodoход:

- 1 эрх зүйч
- 1 эмнэлгийн ажилтан
- 1 эмч шаардлагатай.

Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан байвал илүү хэрэгтэй.

ТББ тодорхой хугацаанд багийн гишүүдээ анхны бүтцээр нь ажиллуулахыг хичээх шаардлагатай. Багийн гишүүд олон удаа солигдоод байвал хоригдсон этгээдүүд болон хорих газрын удирдлагатай тогтоосон харилцаагаа хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэл учруулна.

## 2.2. Багийн хэмжээ

---

Багийн хэмжээ нь жишээлбэл дараах хүчин зүйлсээс шалтгаална. Үүнд:

- Уулзалтын зорилго
  - Хорих, цагдан хорих газарт гарч болох хүндрэлүүдийн тухай мэдээлэл ба үссэн хүндрэл бэрхшээлийн хэмжээ багтаамж
  - Хорих газрын хэмжээ, хоригдогчийн тоо  
Тухайн хорих газраас тогтоосон хориг, хязгаарлалт байгаа эсэх
- 

Уулзалтын бүлэг нь 2 - 8 хүний бүрэлдэхүүнтэй байж болно.

## 2.3. Сургалт

---

Уулзалтын бүлэгт орсон хүмүүсийг дараах асуудлаар сургалтанд хамааруулна. Үүнд:

- Хорих асуудалтай холбоотой асуудлууд
  - Уулзалтын зорилго
  - Мониторингийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж болон бусад шалгуурууд
  - Эрх баригчид, удирдлагууд болон хоригдогчтой харилцах тактикийн сонголт
-

## ҮУЛЗАЛТ ХИЙХ ҮЕ ШАТ

---

ХЭЗЭЭ?

### УУЛЗАЛТ ХИЙХ

ЮУГ?

- Шаардлагатай мэдээллийг цуглуулах
- Уулзалтын зорилгыг тодорхойлох
- Урьдчилсан ярилцлага хийх

### БЭЛТГЭХ, УУЛЗАЛТ ХИЙХ

- Уулзалт хийх
- Бичиг баримттай танилцах
- Нүүр тулах ярилцлага
- Дүгнэлт ярилцлага хийх

### УУЛЗАЛТ ХИЙСНИЙ ДАРААХЬ АЖИЛ

- Уулзалтын талаарх дотоод тайлан бэлтгэх
- Захидлаар харилцах
- Давтан уулзалт хийх
- Тайлан гаргаж дүгнэх

### III бүлэг

**ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ  
ГАЗАРТ ХИЙХ  
МОНИТОРИНГИЙН  
ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ**



## ҮДИРТГАЛ

---

### **Харьцуулсан стандарт**

Хорих нөхцлийн мониторинг хийхдээ: хууль эрх зүй, шинжлэх ухааны (жишээ нь эрүүл ахуйн), нийгмийн болон ёс суртахууны стандартыг хангаж байгаа эсэхийг тогтоо шаардлагатай. Хүний эрхийг хязгаарлан хасахтай холбогдсон нийтлэг стандартууд нь ихэнхдээ олон улсын арга хэрэгслүүд болон үндэсний холбогдох хууль тогтоомжинд тусгагдсан байдаг.

Хоригдогчтой харьцах үндсэн зарчим нь хорих нийтлэг Стандартыг бүрдүүлдэг. Эдгээр зарчмууд нь бүх төрлийн Хорих, цагдан хорих газарт хоригдож байгаа хүмүүст тохирохоор байдаг.

---

#### **Хоригдогсодтой харилцах үндсэн зарчмууд**

*Хоригдогчтой харьцах үндсэн зарчим нь хорих нийтлэг стандартыг бүрдүүлдэг.*

*НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 тоот тогтоол*

- 1)** Бүх хоригдогсодтой хүн гэдэг утгаар нь тэдний нэр хүндийг хүндэтгэн харьцах ёстой.
- 2)** Хэнийг ч яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрөхийн онцлог гэх мэт өөр ямар ч шинж чанараар нь ялгаварлан гадуурхаж болохгүй.
- 3)** Тухайн орон нутгийн нөхцлөөс үүдэн хоригдогсдын соёл, зан заншил, шашин шүтлэг, итгэл үнэмшил ямар ч байлаа гэсэн хүндэтгэн үзэх нь зүйтэй.
- 4)** Аливаа төрийн үндсэн үүрэг нь нийгмийн бүх гишүүдийг амгалан тайван амьдроулж, хөгжүүлэн цэцэглүүлэхэд орших бөгөөд энэ утгаараа хорих, цагдан хорих газрууд хоригдочийг хорьж, нийгмийг аливаа зөрчлөөс хамгаалах үүрэг хүлээдэг.
- 5)** Хорихтой холбогдон бий болдог зайлшгүй хязгаарлалтуудаас гадна Хүний эрхийн түгээмэл Тунхаглал, тухайн улс орон нь гишүүн орон бол Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын Пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, энэхүү Пактын нэмэлт

протокол, түүнчлэн НҮБ-ын бусад пакт, баримт бичгүүдэд дурдсан хүний эрх, суурь эрх чөлөөг эдэлнэ.

**6)** Бүх хоригдогсод хувь хүнийг тал бүрээс нь хөгжүүлэхэд чиглэгдсэн соёлын ба боловсролын арга хэмжээнд оролцох эрх эдэлнэ.

**7)** Ганцаарчлан хорьж шийтгэх явдлыг бүрмэсэн устгах, угүй ядахдаа энэ шийтгэлийг хэрэглэхийг тодорхой хэмжээгээр хязгаарлах, ийнхүү устгах буюу хязгаарласан тохиолдлыг бүрэн дүүрэн дэмжихэд бүх хүчээ дайчилвал зохино.

**8)** Хоригдогчдыг өөрийн орны хөдөлмөрийн талбарт эргэж ажиллахад нь хялбар байх, өөртөө болон ар гэртээ санхүүгийн тусламж үзүүлж болохуйц хөдөлмөр эрхлэх боломж олгохоор тийм нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

**9)** Хоригдож буй этгээд эрх зүйн байдлаасаа үл шалтгаалан тухайн оронд байдаг эмнэлгийн тусламж авах ёстой.

**10)** Хорих ял эдэлсэн хүмүүс олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо, тусламжтайгаар хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцлийг бий болговол зохино.

**11)** Дээр дурдсан зарчмуудыг алагчлалгүйгээр хэрэглэх ёстой.

---

Мониторингийн схемчилсэн үйл явцыг дараах байдлаар дүрслэн харуулж болно.

**1)** ТББ-ууд хорих нөхцөл ямар байгааг аль болох бүрэн дүүрэн, өөрөөр хэлбэл Хорих, цагдан хорих газрын үйл ажиллагааг товчхон бичиж, тодорхойлох шаардлагатай.

Үүнд:

- Хоригдогсдыг хянаж, хамгаалж байдаг удирдах албан тушаалтан, ажилтнууд, бусад албан хаагчдын санал бодол
- Хоригдогсдын санал бодол

Хорих, цагдан хорих газарт ТББ-ын хийсэн ажиглалт

**2)** ТББ тухайн Хорих, цагдан хорих газрын нөхцөл үндэсний болон олон улсын стандартад нийцэж байгаа эсэхийг шалгана.

---

ТББ эрх баригчидтай тогтоосон хамтын ажиллагааны арга барил болон хуримтлуулсан дадлага туршлагаас хамааран мониторингийг ямар давтамжтай хийх нь шалтгаална. Үүнд:

- 1) ТББ судалж олсон зүйлээ мөрдөгдөж байгаа стандартад нийцэж буй эсэхийг харьцуулах замаар ямар байна, ямар байх ёстой юм гэдэг зарчмаар тодорхойлж болно.
- 2) Энэ үндэслэлээр ТББ стандарттай нийцэхгүй байгаа зүйлийг хэсэгчлэн авч шалтгааныг тодруулахыг оролдох ёстой. Стандарт зөрчигдөх нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалж болно. Жишээ нь:
  - Үндэсний хууль тогтоомж, олон улсын стандартад нийцэхгүй байх.
  - Стандартыг хэрэглэдэггүй, эсхүл хэсэгчлэн хэрэглэдэг. Жишээлбэл:
    - Стандарт нь сайн боловсруулагдаагүйгээс, эсхүл хоцрогдсоноос, Хорих, цагдан хорих газрын албан хаагчид ажлын шаардлагыг хангахгүй байгаагаас
    - Албан хаагчдын мэргэжлийн бэлтгэл хангалтгүйгээс тэдний мэргэжлийн соёл нь стандартад таарахгүй байгаа.
    - Стандартыг хэрэглэхүйц хүн хүчиний нөөцгүй байгаа.

Дээр дурьдсан дүгнэлтийг ашиглан стандартыг гүйвуулахгүй хэрэглэхэд тохирсон нарийвчилсан практик зөвлөмж боловсруулж болно.

Асуудал ба тэдгээрийн шалтгааныг дараахь байдлаар нарийн тодорхойлно.

- Эмзэг хэсэг юмуу үндсэн асуудлыг тодорхойлох
- Зөвлөмждөө цаг хугацааны шалгуурыг оруулж өгөх /өөрөөр хэлбэл харьцангуй богино, дунд зэргийн болон урт хугацаанд тус тус юу хийж болохыг/
- Зарим асуудлын өвөрмөц шийдлийг санал болгох
- Стандартыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах

## I. ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ ОЧИХ БЭЛТГЭЛ АЖИЛ

---

Хорих, цагдан хорих газарт гүйцэтгэх ажлыг аль болох амжилттай гүйцэтгэхийн тулд нарийн төлөвлөх хэрэгтэй. ТББ-ууд дор дурдсан асуудалд хангалттай цаг зарцуулах нь зүйтэй. Үүнд:

Очиж ажиллах гэж буй хорих, цагдан хорих газрын талаар олж авсан мэдээллээ төвч тэмдэглэх.

- Урьд нь очихдоо олж авсан болон өөр эх үүсвэрээр олсон
  - Дарга нарын шууд захирамж буюу дээд шатны удирдамж
  - Хоригдогсдын тоо, эрх зүйн байдал
  - Байгаа болон байж болох асуудлууд.
- 

### **Хорих, цагдан хорих газарт очих зорилгоо тодорхойлох**

- Хорих нөхцөлд өгсөн ерөнхий үнэлгээ
  - Тулгарсан тодорхой хүчин зүйлийг дахин шалгах
  - Хувь хүмүүсийн зүгээс гаргасан гомдол саналыг дахин хэлэлцэх, үргэлжлүүлэн хүлээн авах
  - Бусад.
- 

### **Хорих, цагдан хорих газарт ажиллах багийн ажлыг зохион байгуулах**

- Хорих нөхцлийн стандартын дагуу хуримтлуулсан мэдээллийг баталгаажуулах, жагсаалт гаргах
  - Багийн ахлагчийг томилох. Багийн ахлагч нь тухайн ажлын хариуцлагыг хүлээнэ.
  - Багийн бүх гишүүдийг очих гэж буй Хорих, цагдан хорих газрын тухай, ажлын зорилго болон ажлыг зохион байгуулах журмын талаарх ижил мэдээллээр хангах
  - Багийн гишүүний дадлага туршлага, ажлын үргэлжлэх хугацаа зэргээс шалтгаалан гишүүдийн гүйцэтгэх ажлыг хуваарилах.
-

---

**Хорих, цагдан хорих газраас бусад байгууллагатай холбоо тогтоох. Үүнд:**

- Цагдаагийн болон захиргааны байгууллага
  - Шүүх эрх мэдлийн байгууллага
  - Хорих, цагдан хорих газартай хамтран ажилладаг төрийн байгууллагууд, жишээ нь эрүүл мэндийн байгууллага, нийгмийн халамжийн байгууллага гэх мэт.
  - Хорих, цагдан хорих газартай хамтран ажилладаг бусад байгууллагууд.
  - Бусад.
-

## II. ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ ОЧИЖ АЖИЛЛАХ АРГАЧЛАЛ

---

### 1. ТББ-ААС ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ АЖИЛЛАХДАА ЗААВАЛ БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

Хорих, цагдан хорих газарт шалгалт хийх хяналт нь нарийн хандлага шаарддаг. Ёс зүйн үүднээс авч үзэхэд илүү үр дүнтэй ажиллахын тулд тодорхой зарчим баримтлах ёстай.

#### 1.1. Хоёрдмөл санаагүй зан үйл /Үг, ажил хоёр зөрөх ёсгүй/

Хорих, цагдан хорих газрын нөхцөлд мониторинг хийх ажил “гэгээлэг” байх шаардлагатай. Иймд зөвхөн Хорих, цагдан хорих газрын удирдлага болон эрх бүхий дээд албан тушаалтанд хамарагдаад зогсохгүй мониторинг хийж буй багийнханд ч бас хамаарна.

Ажлынхаа онцлогоос шалтгаалан Хорих, цагдан хорих газрын бүх түвшний ажиллагсад ялангуяа цагдаагийн харьяа байгууллага хорих ял өдлүүлэх байгууллагуудад/ аюулгүй байдлыг хангахад үндэслэсэн мэргэжлийн соёлтой болсон байх. Үүнээс шалтгаалж гадаад ертөнцийн аливаа төлөөлөгчид үл итгэх, итгэх асуудал хамаарна. ТББ-ын ажлын хэсгийг Хорих, цагдан хорих газарт байх бүх хугацаанд хорих, цагдан хорих газрын ажилтнууд анхааралтай ажиглаж байх болно. Иймд ажлын хэсгийн гишүүд ямар нэг алдаа гаргах ёсгүй.

---

Ажлын хэсэг дараахь үүрэгтэй. Үүнд:

- Ажлынхаа зорилго, арга барилыг маш нарийн тодорхойлж, түүнийхээ дагуу үйл ажиллагаа явуулах
  - Тухайн хорих, цагдан хорих газрын дотоод журмыг баримталж, шаардлагатай тохиолдолд тэдгээр газрын удирдлагаас зарим нэгэн хөнгөлөлт үзүүлэхийг хүсэж зөвшөөрөл авч болно.
  - Хоригдож буй этгээдийн гүйлтаар хууль буюу дотоод журамд харшилсан үйлдэл хийж болохгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих газрын даргаас зөвшөөрөл авна.
  - Хувийн бичиг баримт, таних тэмдэгийг ил авч явах шаардлагатай.
-

## **1.2. Хорих, цагдан хорих газрын ажилтнуудад хүндэтгэлтэй хандах**

Хорих газар ажиллахаар очсон ТББ болон хорих газрын ажилтнуудын хооронд харилцан хүндэтгэх нөхцөл үүсээгүй бол тухайн ТББ-ын ажил тун таагүй байдалд орно.

Хорих газар ажилладаг хүмүүс ихэвчилэн өөрийн сайн дураар, хүслийнхээ дагуу энэ ажлыг хийх нь ховор байдаг. Тэд янз бүрийн хүмүүстэй харьцааж талархал хүлээхээсээ илүү хийж буй ажил нь өөрийнх нь үзэл бодолтой зөрчилдөж байдаг. Нийгмийн талаасаа тэдний гүйцэтгэж байгаа ажил гүйцэд үнэлэгддэггүй ба оршин байгаа улс орны байдлаас шалтгаалан бага цалинтай байдаг.

Хэдийгээр ажилтнууд хоригдож буй хүмүүстэй зүй зохисгүй харьцааж, түүнийхээ төлөө зохих шийтгэл хүлээх ёстой боловч олон асуудлын уг язгуур нь: тодорхой хувь хүндээ бус хорих тогтолцооны буруугаас хууль тогтоомж, дүрэм, журам, зохион байгуулалт, ажилтнуудын мэргэжлийн түвшингээс шалтгаална.

Иймээс ТББ-ын гишүүд ямар нэг дүгнэлт гаргахаас зайлсхийх нь чухал.

ТББ нь хорих газрын ажилтнуудын эрх мэдэл, гүйцэтгэх үүргийн түвшинг тодорхойлох ёстой бөгөөд түүн дээрээ үндэслэн удирдлагуудтай ярилцлага хийж, зөвлөмж өгөхдөө албан тушаалтнуудын захирах, захирагдах шатлалыг сайн мэдсэн байх ёстой.

### 1.3. Хоригдож буй этгээдэд хүндэтгэлтэй хандах

Хоригдож буй этгээдтэй ганцаарчилан уулзаж, хэрхэн ярилцах тухай.

Хоригдогч ямар шалтгаанаар хоригдож байгаа болон энэ нь эрх зүйн хувьд үндэслэлтэй эсэхээс үл хамааран эрх чөлөөтэй хүмүүсийн адилаар тэдэнд хүндэтгэлтэй хандаж эелдэг харьцах шаардлагатай.

---

Ярилцаж буй ТББ-ын гишүүн нь:

- Хувь хүн болон бүлэг хүмүүсийг аюулд өртүүлж болохоор тийм үйлдэл хийхээс зайлсхийх ёстой.
  - Ирсэн зорилгоо маш тодорхой, тэгэхдээ хоёрдмол санаагүйгээр хэлж, түүнчлэн үйл ажиллагаатай нь холбогдуулан ТББ-д тавьсан хориг, хязгаарлалтыг тайлбарлах ёстой.
  - Хийж чадахааргүй, хийсэн ч үр дүн багатай ямар нэгэн асуудлаар арга хэмжээ авч өгнө гэж худлаа амлаж, итгэл найдвар төрүүлэх ёсгүй.
  - Тодорхой асуудал буюу эрсдэлтэй асуудлын тухай хоригдогчид мэдээлсний дараа тэд зөвшөөрсөн тохиолдолд тэдний эрх ашгийг төлөөлөх
- 

### 1.4. Мэдээллийг шалгах

ТББ-ын үйл ажиллагааны хууль ёсны зарчим нь шат дараалалтай, байнга шинэлэг, ач холбогдол, үр нөлөөтэй байхыг шаардана. Хорих газар ажиллаад олж авсан мэдээллийг үнэн эсэхийг нь нарийвчлан тогтоох боломжгүй байсан ч янз бүрийн өөр эх үүсвэрээр хоригдогсад, ажилтнууд, гадаад хүчин зүйл бага боловч тодруулахыг хичээх нь зүйтэй.

Эрүү шүүлт хэрэглэсэн ба хүнлэг бус харьцсан тухай аливаа өргөдөл, гомдол үнэн эсэхэд тодорхой хариулт олж авахын тулд өргөдөл гомдол гаргагчид аюул занал учруулахгүй ажиллаж чадах эрх мэдэлтэнд шилжүүлэх ёстой. Тухайн гомдлын дагуу мөрдөн байцаалт явуулах буюу илүү нарийн судалж мэдэх, ийм байдалд хүргэсэн шалтгааныг олж тогтоох ажлыг хорих, цагдан хорих газрын удирдлага гүйцэтгэнэ.

## 2. ХОРИХ БОЛОН ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН ДАРГАТАЙ УРЬДЧИЛАН УУЛЗАХ

Хорих газар анх удаа очиходо ажлын хэсгийнхэн хорих, цагдан хорих газрын даргатай эсхүл түүний орлогч даргатай уулзаж ярилцана. Тэдгээрийн захиргаатай тогтоож байгаа энэ холбоо нь үйл ажиллагааны эхлэл бөгөөд ярилцлагын үед ТББ болон ажлын бүлгийн гишүүдийг танилцуулаад дараах зүйлсийг тайлбарлаж өгнө. Үүнд:

- 
- Хорих газар ирэх болсон зорилго, зорилт
  - Ажлыг гүйцэтгэх аргачлал: хоригдож байгаа этгээдтэй нүүр тулан уулзах зайлшгүй шаардлага
  - Олж авсан мэдээллээ хэрхэн ашиглах
  - Ажил гүйцэтгэх үедээ ажлын бүлгийн гишүүд хорих газрын дотоод журмыг дагаж мөрдөж, аюулгүй байдлыг хангах журмыг хэрэгжүүлнэ гэдгээ хорих газрын даргад батална.
  - Хоригдож буй этгээдтэй хэрхэн уулзах, уулзалтын үргэлжлэх хугацааг тайлбарлана.
  - Хорих газрын талаарх мэдээлэлтэй танилцах, сүүлчийн уулзалтаас хойш гарсан өөрчлөлтийг мэдэхийг эрмэлзэнэ.
  - Дараахь асуудлаар хорих, цагдан хорих газрын даргын санал бодлыг мэдэж авна. Үүнд:
    - Хоригдогчдын хоригдож байгаа нөхцөл ямар байгаа
    - Нөхцлийг сайжруулах талаар цаашид яаж ажиллас
    - Нөхцөл сайжруулах санал
  - Ярилцах цаг, уулзалтын товыг тогтооно.
- 

Хэрэв ТББ нэг буюу тодорхой хорих газруудад хэд хэдэн удаа ажилласны дараа ямар нэгэн зөрчил хоригдогсдыг хорих нөхцөлтэй холбоотой тохиолдоогүй буюу ноцтой асуудал мэдрэгдээгүй бол урьдчилсан уулзалт яриа ёс төдий ерөнхий буюу тогтмол бус гэж үзэх үндэстэй.

### 3. БҮРТГЭЛИЙН ТЭМДЭГЛЭГЭЭГ ШАЛГАХ

Бүртгэлийн дэвтэр бол хоригдогсод, тэдгээрийг хорих нөхцлийн тухай мэдээлэл авах гол эх сурвалж юм. Бүртгэлийн дэвтэрийг хамгаалалтын баримтжуулсан арга хэмжээ гэдэг утгаар нь авч үзэх ёстай.

Хорих газарт ажлаа эхлэхийн өмнө, ялангуяа нэг удаагийн ажиллагаа, хэд хоногоор үргэлжлэх тохиолдолд бүртгэлийн дэвтэртэй эхлээд танилцах нь зүйтэй. Бүртгэлийн дэвтрээс олж авсан мэдээллийг шаардлагатай бол ажиллах хугацаандаа дахин шалгана.

Тухайн хорих газрын төрлөөс хамааран бүртгэлийн дэвтрүүд янз бүр байдаг. Тэдгээрээс илүү сонирхол татахаар бүртгэлүүдийг 3 хэсэгт хувааж үзнэ.

---

#### 1.Хоригдогсдын бүртгэлийн дэвтэр

- Хоригдогсдын ялгаагаар (жир, чанга, насанд хүрээгүй гэх мэт)
  - Шинээр ирэгсдийн болон суллагдагсдын бүртгэлийн дэвтэр
  - Сахилгын арга хэмжээ бүртгэх дэвтэр
  - Эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэр
  - Бусад
- 

#### 2.Хоригдогсдод зориулсан материалын нөөцийн бүртгэлийн дэвтэр

- Хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл, хувцас, цагаан хэрэглэл зэрэг
  - Эм, эмнэлгийн материал
  - Биеийн тамир, чөлөөт цагийг өнгөрүүлэх хэрэгслүүд, сургалтын гарын авлага
  - Бусад
-

---

### **3. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр**

- Тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай
  - Цагийн хуваарьтай холбоотой бүртгэл: ашигтай хөдөлмөр, биеийн тамирын дасгал, боловсролын сургалт
  - Зөрчлийн тухай тэмдэглэл
- 

Хоригдогсодтой хэрцгий, хүнлэг бусаар харьцахад хүргэсэн үйл явдлыг тодруулах, хариуцлагын түвшинг тодорхойлоход хамгийн сүүлд дурдсан гурван бичиг баримт чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэвч хорих газрын захиргаа ихэвчлэн эдгээр баримтуудтай танилцахыг зөвшөөрдөггүй.

## **4. ХОРИГДОГСДЫН БАЙРААР ОРЖ ҮЗЭХ**

Хорих, цагдан хорих газар анх удаа очиходо хоригдогсдын ашигладаг, тэдэнд зориулагдсан бүх байрыг үзэх хэрэгтэй. Тухайн хорих газрын дарга, эсхүл хоригдогсдын байрыг танилцуулахаар томилогдсон албан хаагчтай хамт ТББ-ын бүлгийн бүх гишүүд хоригдогсдын байрыг хамт үзэх хэрэгтэй.

---

### **Хоригдогсдын байраар орж үзсэнээр дараахь боломж олгоно.**

Байрууд болон тэдгээрийн байршлын тухай мэдээлэлтэй болно. Шоронгийн архитектур ба аюулгүй байдлыг хангах системд хамгаалалтын хашаа, үндсэн ба туслах бус, тэдний амьдрах байрны хана, хорих өрөө, амралтын, хоолны газрууд, сургалтын болон чөлөөт цагийн байр, биеийн тамирын танхим, чөлөөт талбай, үйлдвэрлэл эрхэлдэг газрууд, гал зуух, сахилгын байр, бие засах газар, халуун үс, угаалгын газар эмнэлэг гэх зэрэг олон зүйл багтдаг. Энэ нь хоригдогсдын өдөр тутмын амьдралд маш их нөлөө үзүүлдэг учраас энэ асуудалд онцгой анхаарах ёстой.

Үүнээс сахилгын байр, тусгаарлах өрөө, бие засах газар, амьдрах байранд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. Учир нь эндээс хоригдож буй этгээдэд хэр зэрэг хүндэтгэлтэй ханддагийг олж харж болно.

---

## 5. ХОРИГДОГСОДТОЙ ЯРИЛЦАХ

Хоригдож байгаа этгээдтэй уулзаж ярилцах нь хорих газрын нөхцлийг баримтжуулах ажлын үндэс болно.

Ганцаарчлан болон нийт дунд нь ярилцлага бүрийн өмнө бүлгийн гишүүд өөрсдийгөө танилцуулж, ТББ-ынхаа үйл ажиллагааны талаар ярьж уулзалтын зорилгыг нарийн тодорхойлсон тайлбар хийнэ.

Ганцаарчлан болон нийт дунд нь хийх ярилцлага бол ТББ-аас заавал урьдчилан төлөвлөх ёстой ажил мөн.

Ярилцлагын үеэр тавих асуулт, хийх тайлбар нь авах хариултад ямар нэгэн байдлаар нөлөөлөх ёсгүй.

### 5.1. Нийт дунд нь хийх ярилцлага

Хорих, цагдан хорих газрууд нь сэжигтэн, яллагдагч, хоригдлыг тодорхой хугацаагаар хорьдог. Тэнд аюулгүйн журам хангагдсан нөхцөлд нийт дунд нь ярилцлага хийж болно.

Ярилцлага хийснээр хорих нөхцөлтэй холбоотой болон Хорих, цагдан хорих газарт хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэлтэй болно. Хоригдогсод ихэнхдээ нэгдмэл санаатай байж чаддаггүй учраас албан хаагч нартайгаа хэрхэн харилцдаг, сахилга бат ямар байна гэх зэрэг илүү мэдрэмжтэй асуудлыг нийт дунд нь ярилцаж болдоггүй.

Нийт дунд нь хийх ярилцлага ямар хугацаанд үргэлжлэх вэ? Гэдгээ урьдчилан тогтоосон байх нь зүйтэй. Ярилцлагыг нээлттэй асуудлуудыг хөндөж гаргах чиглэлээр эхлэх ёстой. Эндээс нээлттэй ярилцлагаар халуун яриа өрнүүлж болохыг зөвлөж байна. Оролцогчдоос авсан хариулт үүссэн шалтгаант асуудлын талаар тэдний үзэл бодлыг нээж илрүүлнэ.

Ярилцлагын хоёрдахь үе шат нь хорих, цагдан хорих үндсэн асуудлын талаар мэдээлэл авахад чиглэгдэнэ. Хоорондоо авцалдаагүй, эсхүл нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн мэдээлэл хуримтлагдсан бол цаашид хийх ажлынхаа явцад ганцаарчилсан ярилцлага болон бусад эх үүсвэрээр тодруулж болно.

### 5.2. Ганцаарчилсан ярилцлага

Ганцаарчилсан ярилцлага нь юуны өмнө хэвийн бус буюу гадаад өртөнцийн хэм хэмжээнд зохицохгүй нөхцөлд байгаа хүнтэй хийх уулзалт юм. Өөрөөр хэлбэл эрхээ хасуулан хоригдож байгаа хүн гэсэн уг. Хүн болгон баривчлагдах болсон шалтгаанаар хязгаарлагдахгүй өөрийн түүхтэй байдаг. Хууль хяналтын бусад байгууллага болон хорих, цагдан хорих газрын албан хаагч нар энэ ойлгомжтой асуудлыг ихэвчлэн мартчихдаг учраас хэт нэгтгэж, өөрсдөдөө хялбар болгосон аргаар тэдэнтэй харьцдаг.

## Уулзалт хийх газрыг сонгох

Ганцаарчилсан ярилцлагад орох гэж байгаа хүний тайван, чөлөөтэй, итгэлтэй байхад уулзах газар маш чухал үүрэгтэй байдаг. Ажилтны нүднээс далдуур уулзалт хийх боломжгүй боловч сонсохооргүй газар ярилцах нь чухал. Захиргааны нэг өрөөнд ярилцлага хийхээс зайлсхийвэл зохино. Уулзалтыг нэг хүний буюу олон хүнтэй өрөөнд, түр ба удаан хугацааны уулзалтын байранд, хашаанд ил талбай дээр, номын санд гэх мэт газарт явуулж болно. Уулзалт хийх газрыг сонгоходо юуны түрүүнд уулзах гэж байгаа сэжигтэн, яллагдагч, хоригдлын санал, нөгөө талаас хорих газраас аюулгүй байдлыг хангах үүднээс тавьсан хориг, хязгаарлалт зэргийг харгалзан үзнэ.

Ихэнх тохиолдолд цөөн хэдэн хүнтэй уулзуулахаар нэрсийн жагсаалтыг гаргаж өгдөг. Тухайн хорих, цагдан хорих газар хоригдогсдын ангиллаас шалтгаалан аль болох олон талыг харгалзан үзэж, уулзах хүнээ сонгож авах нь чухал. Тиймээс зөвхөн уулзах санал ирүүлээд байгаа хүмүүстэй уулзахаар ажлаа хязгаарлаж болохгүй.

Уулзалтыг 1 - 2 хүний бүрэлдэхүүнтэй хийж нэг нь ярилцаж, нөгөө нь тэмдэглэл хөтөлж болох юм. Энэ нь уулзалтыг хөтөлж байгаа хүнд анхаарлаа төвлөрүүлэхэд нь тусалдаг сайн арга боловч хоригдогчид хэтрэхий хүндрэлтэй санагдаж болох учраас түүнтэй энэ талаар ярилцаж тохирох нь зүйтэй. Хоригдож буй этгээд хэд хэдэн шалтгааны улмаас тухайлбал, амьдралын туршлага, сэтгэл санааны байдал, урт удаан хугацаагаар хоригдож цаг хугацааны мэдрэмжээ алдсан, юмыг амархан мартдаг болсон, нэг юмыг хэт ихээр бодож санааширдаг болсон зэргээс шалтгаалан өөрийгөө шууд илэрхийлж чадахгүй, үгээ зөөдөг, удаан бодож хариулдаг болсон байdag.

Тийм учраас ганцаарчилсан ярилцлага хийхдээ оноогдсон богино хугацаанд шаардлагатай мэдээллээ авахын тулд ярилцагчийнхаа сэтгэл санааны байдлыг бас харгалзаж дор дурдсан тэнцвэрийг байнга хадгалах хэрэгтэй. Үүнд:

- Хоригдож буй нөхцөлийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай мэдээллэл олж авах, нөгөө талаас өөрийг нь зовоож байгаа асуудлыг илчлэхийг хүссэн хоригдогчийн хэрэгцээг анхаарч тэмдэглэх.
- Ярилцлагыг ямар ч тохиолдолд байцаалт мэт байдалд оруулахгүй байхыг бүх талаараа хичээх хэрэгтэй.
- Нэг талаас хоригдогчийг өрөвдөх зэрэг сэтгэл хөдлөлөө дарах, нөгөөтэйгүүр ярилцлагаа явуулахын тулд

ярилцагч, өөрийнхөө сэтгэл санааг тайван байлгаж тодорхой зай барих шаардлагатай. Тэнцвэрийг хадгалахдаа хоригдогчийн сэтгэл санааны байдалд илүү тохируулна.

- Ярилцлага бүрд оногдох хугацаанаас шалтгаалан цагийг зөв хуваарилан хоригдогчийн хүнтэй харилцах гэсэн хэрэгцээг ч хангаж, мэдээлэл авах гэсэн хэрэгцээгээ хангана.
  - Хорих нөхцөлд хяналт тавихад шаардлагатай мэдээллийг авахын тулд: Үндсэн зорилго болсон ярилцагыг хийхээс гадна сэжигтэн, яллагдагч, хоригдол болон ажилтнуудтай харилцаж болох боломжийг алдахгүй байхын төлөө чармайх хэрэгтэй болно. Ийм харьцаа нь дэмийн хоосон цаг нөхцөөх ёсгүй бөгөөд харин ч эдгээр ажил хэрэгч, бүтээлч харилцааг тогтооход тус дөхөм болох ёстой.
- 

## 6. ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ БАРИВЧЛАХ ГАЗРЫН АЖИЛТАНТАЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ

Ажилтнуудыг Хяналт тавьдаг харуул хамгаалалтын, үйлчилгээ хариуцдаг аж ахуйн, эрүүл мэндийн, нийгмийн туслалцааны, боловсрол сургалтын алба г.м. авч үзнэ. Үйлчилгээний албаны ажилтнуудтай хорих нөхчлийг судлах үедээ ярилцлага хийнэ.

Харуул хамгаалалтын ажилтнуудтай ярилцлага хийхэд хүндрэлтэй байдаг. Энэ нь тэдний ажлын зохион байгуулалт, шинж чанартай холбоотой хэд хэдэн шалтгаантай. Үүнд: харуул хамгаалалтын ажилтнуудтай нэг зэрэг нэг дор уулзах боломжгүй байдаг. Түүнчлэн хүнд суртал, тэдний дунд ёс юм шиг хөгжсөн, “бусдыгаа хамгаалах” сэтгэлгээ байдаг. Харуул хамгаалалтын ажилтнууд хоригдогчийн амьдралд хамгийн том үүрэг гүйцэтгэдэг учраас тэдэнтэй заавал ярилцахыг хичээх хэрэгтэй. Ярилцлагын явцад ТББ-аас ажилтнууд ажлынхаа зорилтыг танилцуулж, тэдний асуултанд хариулт өгч, санал бодлыг нь сонсоно.

## 7. УУЛЗАЛТЫГ ДУУСГАХ

Баримталсан стратеги ирсэн мэдээ сэлтээс шалтгаалан яриа янз, янзын зорилготой байж болно. Үүнд:

- 
- Олж авсан мэдээллээ уулзалтын үеэр дүгнэж үзсэн бол энэ үндсэн дүгнэлтүүдээ хорих, цагдан хорих газрын даргад танилцуулах
  - Олж авсан мэдээллээ уулзалтын үеэр дүгнэж үзээгүй бол даргатай хийх ярилцлага ёс төдийгөөр өндөрлөнө.
  - Харин дараа нь мэдээлэлдээ дун шинжилгээ хийж гаргасан дүгнэлтээ хорих, цагдан хорих газрын даргад амаар болон бичгээр мэдэгдэнэ.
  - Урвуулан ашигласан тохиолдол илэрвэл мэдээлэл өгсөн этгээдэд залхаан цээрлүүлэх арга хэмжээ авч болзошгүй байдлыг харгалзан үзэж, түүнээс зайлсхийхийн тулд ТББ энэ тухай дээд шатны даргад хандана. Энэ нь хорих газрын дарга, ТББ-ын гишүүний хооронд таагүй харьцаа үүсэхээс хамгаална.
- 

Сонгож авсан стратеги чинь ямар байхаас үл шалтгаалан тухайн даргатай ажил хэргийн холбоогоо бэхжүүлэхийн тулд уулзалтын үр дүнгийн талаар даруй мэдэгддэг байх нь чухал.

## 8. ХОРИГДСОН, АЛБАДАН СААТУУЛАГДСАН ХҮНИЙ ГЭР БҮЛИЙНХЭНТЭЙ УУЛЗАХ

ТББ хорих, цагдан хорих газарт хийх уулзалтынхаа үеэр юмуу эсхүл өөр цагт хоригдогсдын гэр бүлийнхэнтэй уулзаж болно. Хоригдогсдын гэр бүлийнхэнтэй дээр дурдсан зарчмуудыг баримтлан ярилцлага хийснээр хорих нөхцөлтэй холбоотой асуудлуудаар бүрэн дүүрэн ойлголтой болж болно. Ямар нэг зэрчил, будлиантай асуудал хорих, цагдан хорих газарт үүссэн нөхцөлд гэр бүлийн хүмүүс мэдээллийг ТББ-дад дамжуулбал хоригдож буй этгээдийг хамгаалахад тус болно.

### III. УУЛЗАЛТЫН ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

---

Очиж үзэх, уулзах нь гол зорилго биш, харин хоригдож байгаа этгээдийн нөхцөл байдлыг сайжруулах нь гол асуудал юм. Тиймээс уулзалтын дараах ажил нь уулзалтаас илүү чухал байж болох юм.

#### 1. УУЛЗАЛТЫН ЯВЦАД ОЛЖ АВСАН МЭДЭЭЛЭЛ ДЭЭР АЖИЛЛАХ

Очиж үзэх, уулзах явцад олж авсан мэдээлэл дээр тулгуурлан маш хурдан амаар болон бичгээр богино хэмжээний нэгдсэн тайлан гаргана. Нэгдсэн тайландаа хорих, цагдан хорих газарт хийсэн хэд хэдэн удаагийн уулзалтын дүнгийн талаар мэдээллийг багтаана.

ТББ байнга очиж ажиллаж байгаа хорих, цагдан хорих газрын нөхцөлд гарч байгаа өөрчлөлтүүдийг харуулж чадахуйц үзүүлэлтүүдийг олж тогтоон ашиглах чадвартай байх ёстой.

Хорих, цагдан хорих газар очоод хуримтлуулсан мэдээллээ шинжлэн судалж, ангилж, дүгнэлт хийгээд шууд ашиглах болохоор нөхцөлд хадгалах шаардлагатай. Шинжилж дүгнээгүй, зохих ёсоор хадгалаагүй мэдээллийг алдагдсанд тооцож болно.

Хорих, цагдан хорих газарт хийсэн уулзалтын тайланг нэгдсэн загвар, бүтцээр хийх нь зүйтэй. Энэ нь хэд хэдэн уулзалт хийсний дараа бүх тайланг нэгтгэн дүгнэх ажлыг хөнгөвчилж, дараагийн уулзалтын бэлтгэл ажлыг хангахад оршино.

#### 2. ЗАЙЛШГҮЙ ХИЙХ ЁСТОЙ АЛХАМ

##### 2.1. Хорих газарт олж авсан мэдээллийн баяжуулалт

---

Ихэнх тохиолдолд хорих газраас олж авсан мэдээллийг дор дурдсан байгууллага, иргэдтэй зөвлөлдсөний үр дүнд баяжуулж, шалгах боломжтой. Үүнд:

- Удирдах дээд байгууллага
  - Хорих, цагдан хорих газартай ажил төрлийн холбоотой бусад төрийн байгууллагууд, жишээ нь Эрүүл мэндийн яам гэх мэт.
  - Бусад этгээд
  - Хоригдогсдын гэр бүл.
-

## 2.2. Удирдлагад мэдээлэх

ТББ хорих, цагдан хорих газруудын дээд удирдлагад ажлынхаа үр дүнг байнга танилцуулж байх шаардлагатай. ТББ зөвхөн эрх баригчидтай холбоо тогтоох, уулзалтын цаг товлох зэрэг тохиолдолд л амаар холбоо тогтоож болно. Харин ажлын үр дүнгээ заавал бичгээр мэдээлэх шаардлагатай.

Хорих, цагдан хорих газарт хийсэн уулзалт бүрийнхээ дараа мэдээлэл хийх албагүй. Тодорхой хүнд зөрчил илрүүлсэн тохиолдолд аман болон бичгийн хэлбэрээр яаралтай тайлагнах шаардлагатай. Хорих, цагдан хорих газарт тодорхой хугацаанд нэг буюу хэд хэдэн удаа очсоны дараа тайлан гаргана.

## 3. ХОРИХ НӨХЦӨЛД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ

### 3.1. Тайлангийн агуулга

Тайлан нь уулзалтын нэгэн адил хоригдогсдыг хамгаалах хэрэгсэл юм. Тайлангийн зорилго нь мэдээлэх, итгэл үнэмшил бий болгох, зарим тохиолдолд буруутгахад оршино. Тайлан нь мониторингийн үйл ажиллагааны чиглүүлэгч юм. Тайлан цаг хугацааны явцад хорих нөхцөл хэрхэн өөрчлөгдж буйг тодорхойлоход тусалдаг. /Хавсралт 2-ыг үз/

#### **Тайланд дор дурдсан нийтлэг мэдээлэл агуулагдах ёстой. Үүнд:**

- ТББ-ын тухай, түүний зорилго, зорилтын тухай товч мэдээлэл
- Хорих, цагдан хорих газарт очиж уулзалт хийх албан ёсны зөвшөөрөл
- ТББ-ын ажлын арга барил
- Хорих, цагдан хорих газарт ажиллаж байгаа багийн бүтэц
- Мониторингийн үндсэн сэдэв болсон хорих нөхцөл: хэн хэн, хичнээн хүн, хорих, цагдан хорих, баривчлах байгууллага, хаана байдаг гэх мэт.
- Уулзалтуудын тодорхой зорилгууд
- Мэдээлэл хэрхэн цуглуулж, яаж шалгасан тухай.

### **Хорих нөхцлийн тодорхойлолт**

- Илтгэлд сайн талаас нь тэмдэглэсэн байлаа ч хорих нөхцлийн талаар дэлгэрэнгүй бичих шаардлагагүй. Гэвч илтгэлд дэвшилттэй сайн талуудыг тэмдэглэх шаардлагатай гэж үздэг.
- Асуудалтай байгаа зүйлсийг ач холбогдоор нь дараалуулан бичнэ.
  - Хамгийн хүндрэлтэй асуудлуудыг эхэнд нь ялгаж оруулна.
  - Бусад асуудлын шалтгаан, нөхцлийг бий болгож байгаа үндсэн суурь асуудлыг ялгаж оруулна.
- Асуудлын хор уршгийг нарийн тодорхойлох шаардлагатай.

### **Зөвлөмж:**

Зөвлөмж ба хэрэгжүүлэх арга хэмжээг богино, дунд, урт хугацаанд гэх мэтээр хугацаа тогтоон заана. Хугацааг асуудал шийдвэрлэх бодит нөхцөл, бололцоотой уялдуулан зөв тодорхойлно.

Зөвлөмж агуулсан илтгэл нь эрх бүхий этгээдтэй хийх харилцан ярианы үндсийг бүрдүүлнэ. Эрх бүхий этгээд тайланд таатай бус хандаж болох учраас гарсан шүүмжлэлийг хүлээн авч, байр сууриа олоход нь зориулж хугацаа өгөх шаардлагатай байдаг. Тэдний хариу, ерөнхий хандлага нь ТББ-ыг хөтөлберөө зохицуулахад тустай учраас дараагийн уулзалтын үед албан ёсны хариу бодит нөхцөл байдалд нийцэж буй эсэхийг тодруулж болно.

### **3.2. Тайлан хэнд зориулагдах вэ?**

Юуны өмнө тайланг хорих, цагдан хорих газрын удирдлага, ажиллах зөвшөөрөл олгосон байгууллагад зориулан гаргана. ТББ тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болгох, парламентын гишүүд, үндэсний болон олон улсын ТББ-д хүргүүлэх нь чухал ач холбогдолтой байдаг. ТББ-ын сонгож авсан стратегаас шалтгаалан тайлан буюу тайлангийн хураангуйг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хүргүүлж болно.

Ямар ч тохиолдолд ТББ-ын тайлан мэдээлэл нь ТББ-ын гишүүдтэй уулзсан хоригдогсодод аюул учруулахгүй гэдэгт бүрэн итгэлтэй байх ёстой.

Тэмдэглэж хэлэхэд: дээрхи тайлан нь ялангуяа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо зэрэг олон улсын байгууллагад тодорхой улс орны илтгэлийг үнэлэх явцад мэдээллийн чухал эх үүсвэр болоод зогсохгүй Эрүү шүүлтийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн ажилд ч чухал хэрэгтэй баримт бичиг болно.

#### **Тайлан бичихэд анхаарвал зохих асуудлууд:**

- Тайланг хэнд хүргүүлэх вэ?
  - Эрх бүхий тодорхой байгууллагад
  - Нэг яамны хэд хэдэн эрх бүхий этгээдэд
  - Эрх баригчдын тодорхой түвшинд
- Тайланг хүргүүлэх гэж буй байгууллага эрх баригч хир зэрэг нээлттэй ба мэдрэмжтэй гэдгийг
- Тэдгээр нь тайлантай танилцаад юуг ойлгосон байх ёстой вэ?
- Тэдний зүгээс ТББ-ыг ямар үйлдэл, ямар алхам хийгээсэй гэж хүсэх вэ?
- Асуудлуудыг хэр зэрэг баталгаажуулж, баримтжуулж, үндэслэлтэй болгосон бэ?
- ТББ нь хорих, цагдан хорих газрууд гаргаж болох элдэв эсэргүүцлийг няцаах чадвартай юу?

## **4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД БОЛОМЖ**

ТББ-ууд хорих, цагдан хорих газарт хийх ажлынхаа хөтөлбөрийг өргөжүүлэх өөр нэмэлт үйл ажиллагаа эрхэлж болно. Тодорхой асуудлуудыг даван туулахын тулд ТББ хорих, цагдан хорих газрын ажилтнуудад семинар зохион байгуулах, тодорхой асуудлуудаар албан бус байдлаар санал солилцох зэрэг ажлыг зохион байгуулж болно. Зайлшгүй тохиолдолд онцгой арга хэмжээ болгон шүүхэд хандаж болно.

## СУДЛАХ АСУУДЛУУД

ХАРИЛЦАА

- Хэрцгий, хүнлэг бусаар харьцсан тухай гомдол
- Ганцаарчлан хоригдсон тухай
- Тусгай хэрэгсэл хэрэглэх

ХАМГААЛАХ  
АРГА ХЭМЖЭЭ

- Байцаан шалгах
- Гомдол гаргах журам
- Сахилгын арга хэмжээ
- Хоригдогсдын бүртгэлийн дэвтрүүд
- Хоригдогсдын ангилал
- Хоол хүнс

МАТЕРИАЛЛАГ  
НӨХЦӨЛ

- Гэрэлтүүлэг ба агааржуулалт
- Хувийн ариун цэвэр
- Эрүүл ахуйн нөхцөл
- Хувцас ба цагаан хэрэглэл
- Хэт бөөгнөрөл

ДЭГЛЭМ БА  
АРГА ХЭМЖЭЭ

- Гадаад ертөнцтэй холбогдох
- Эрүүл агаарт гаргах арга хэмжээ
- Боловсрол
- Чөлөөт цаг
- Шашин шүтлэг
- Хөдөлмөр

ЭРҮҮЛ  
МЭНДИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ

- Эмнэлгийн үйлчилгээ авах боломж
- Эмэгтэйчүүдийн эмнэлгийн үйлчилгээ
- Халдварлах өвчин
- Эмнэлгийн ажилтан

ШОРОНГИЙН  
АЖИЛТАН

- Ерөнхий байдал
- Ажилтны мэргэжлийн бэлтгэл

## IV бүлэг

### ХОРИХ НӨХЦӨЛД ХИЙХ ЁСТОЙ ШАЛГАЛТ

- 1** Хоригдогсодтой харилцах
- 2** Хамгаалах арга хэмжээ
- 3** Материаллаг нөхцөл
- 4** Дэглэм ба арга хэмжээ
- 5** Эрүүл мэндийн үйлчилгээ
- 6** Ажилтан, албан хаагчид
- 7** Цагдаагийн байгууллагад saatuuлах



Хорих, цагдан хорих газруудад очих бүрдээ хорих нөхцлийн бүх хүчин зүйлүүдийг шалгаад байх шаардлагагүй. Уулзалтад бэлтгэх үедээ хуримтлуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр уулзалтын зорилго, нэн тэргүүний зорилтуудыг тодорхойлж, зохицуулалт хийнэ.

Анхны уулзалтын үеэр байр, байшин, хорих өрөө, нийтийн хэрэгцээний газрууд зэрэг материаллаг дэд бүтцэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Үүний дараа дор дурдсан хүчин зүйлүүдэд илүү нарийн анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:

- Хорих, цагдан хорих газрын дотооддоо гомдол гаргах журам
- Сахилгын арга хэмжээг хуульд нийцүүлсэн эсэх
- Гадаад ертөнцтэй тогтоосон холбоо
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Хорих газрын ажилтан, тэдний менежмент ба хоригдогсдын хоорондын харилцаа

Энэ бүлэгт уулзалтын үеэр шалгах ёстай зүйлүүдийг сэдвийн дарааллаар нь авч үзнэ. Эдгээр нь хорих нөхцөлд илүү тохирно. Төгсгөлд нь цагдаагийн газарт saatuuulagdsan хүмүүсийн хорих нөхцөлтэй холбоотой тодорхой хүчин зүйлүүдийг оруулсан болно. Энэ бүлэгт хорих нөхцөлтэй холбоотой олон улсын стандартыг танилцуулах, хорих, цагдан хорих газар очиж ажиллахдаа зайлшгүй анхаарч үзвэл зохих янз бүрийн хүчин зүйлүүдийг нээж харуулах зорилго тавина.

### List of abbreviations for standards:

ACHPR	African Charter on Human and Peoples' Rights – Adopted by the Organisation of African Unity on 27 June 1981
ACPR	African Charter on Prisoners' Rights – Draft adopted by the Fifth Conference of the Central, Eastern and Southern African Heads of Correctional Services (CESCA), meeting in Wind-hoek, Namibia, 4 to 7 September 2001 <sup>16</sup>
BPP	Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment - Adopted by the United Nations General Assembly resolution 43/173 of 9 December 1988
BPTD	Basic Principles for the Treatment of Detainees- Adopted by the United Nations General Assembly in its resolution 45/111 of 14 December 1990
CPT GR2	2nd General Report on the CPT's activities covering the period 1 January to 31 December 1991; CPT/Inf (92)3, 13 April 1992
CPT GR3	3rd General Report on the CPT's activities covering the period 1 January to 31 December 1992; CPT/Inf (93) 12, 4 June 1993
CPT GR10	10th General Report on the CPT's activities covering the period 1 January to 31 December 1999, CPT/Inf (2000) 13, 18 August 2000
CPT GR11	11th General Report on the CPT's activities covering the period 1 January to 31 December 2000, CPT/Inf (2001)16, 3 September 2001
CPT GR12	12th General Report on CPT's activities covering the period 1 January to 31 December 2001, CPT/Inf (2002) 15, 3 September 2002
EPR	European Prison Rules; Recommendation R(87)3, adopted by the Council of Europe Committee of Ministers on 12 February 1987
GC	General Comments of the Human Rights Committee on the implementation of ICCPR's provisions
ICCPR	United Nations International Covenant on Civil and Political Rights, 1966
ICPRT	Inter-American Convention to Prevent and Punish Torture – Adopted by the Organization of American States on 28 February 1987.
IDRCPD <sup>L</sup>	Draft Inter-American Declaration Governing the Rights and Care of Persons Deprived of Liberty. <sup>17</sup>
R(89)12	Recommendation of the Committee of Ministers to Member States on Education in Prison (adopted by the Council of Europe Committee of Ministers on 13 October 1989)
R(98) 7	Recommendation of the Committee of Ministers to Member States concerning the ethical and organisational aspects of health care in prison (adopted by the Committee of Ministers on 8 April 1998).
RIG	Guidelines and Measures for the Prohibition and Prevention of Torture, Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment in Africa (The Robben Island Guidelines), 2002.
RPJDL	United Nations Rules for the Protection of Juveniles Deprived of their Liberty, 1990.
SMR	Standard Minimum Rules for the Treatment of Prisoners approved by ECOSOC in its resolutions 633C (XXIV) of 31 July 1957 and 2076 (LXII) of 13 May 1977.

## ХОРИГДОГСОДТОЙ ХАРИЛЦАХ

1

Хоригдож буй этгээд эмзэг бүлэгт хамарагддаг. Иймд бүх төрлөөр хоригдож байгаа хүмүүстэй хүн гэдэг нэр төрийг нь хүндэтгэж хүнлэг энэрэнгүй харьцах учиртай.

Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон шийтгэхийг хориглосон арга хэмжээг заавал дагаж мөрдөх ёстой зүйл бөгөөд түүнийг зөрчсөн тохиолдлыг ямар ч нөхцөл байдлаар зөвтгөх аргагүй юм.

Бусад арга хэмжээг хууль бусаар авч хэрэглэснийг хэрцгий, хүнлэг бус харьцсантай адилтгаж үзнэ. Энд юуны өмнө ганцаарчлан хорих болон хуулинд заагаагүй хязгаарлалт тавьсан арга хэмжээнүүд орно.

### **Хоригдогсодтой харьцахад хориглосон харилцаа**

- Эрүү шүүлт ба хэрцгий, хүнлэг бус харьцаа
- Ганцаарчлан хорих
- Элдэв хориг, хязгаарлалт хийх арга хэрэгслүүд

## ЭРҮҮ ШҮҮЛТ БА ХҮНЛЭГ БУСААР ХАРЬЦАХ ХАНДЛАГА

### 1

#### Стандарт

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuulagdsan болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 6 дугаар зарчим:

Саатуулагдсан буюу хоригдсон нэг ч хүнийг эрүүдэж шүүх буюу хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцааж, шийтгэж болохгүй. Эрүүдэн шүүх, хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг ямар ч нөхцөл байдал зөвтгэж чадахгүй ...”

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 7 дугаар зүйл:

“Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэнтэй ч хэрцгий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хэн дээр ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийж болохгүй.”

Европын зөвлөлөөс 1950 онд баталсан Европын хүний эрхийн Конвенцийн 3 дугаар зүйл:

Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглоно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд батлан гаргасан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” Конвенцийн 1 дүгээр зүйл:

Энэхүү Конвенцийн зорилгоор эрүүдэн шүүх гэж төрийн албан тушаалтан буюу абан үүрэг гүйцэтгэж буй этгээд өөрөө, эсвэл түүний өдөөн хатгаснаар буюу ил, далд зөвшөөрлөөр хэн нэгэн этгээдийг өөрөөс нь буюу гурав дахь этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлган сурдуулэх, албадах, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие маход, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах аливаа үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолтод гагцхүү хуулийн цээрлэлийн үр дүнд болон түүнтэй салшгүй холбоотойгоор, эсвэл түүнээс тохиолдоор үүдсэн өвдөлт, шаналлыг хамааруулахгүй.

## Тайлбар

Эрүүдэн шүүсэн болон хүнлэг бусаар харьцсан тухай гомдлыг хорих, цагдан хорих газар очиж ажиллахаас өмнө, ажиллах үед авч болох бөгөөд зарим тохиолдолд өөрсдөө ч ийм тохиолдлын гэрч болж болох юм. Хэрвээ ийм тохиолдлын гэрч болсон бол энэ талаар нарийвчлан баримтжуулах шаардлагатай. Эрх бүхий байгууллагад мөрдөн байцаалгахаар шилжүүлэх шаардлагатай тохиолдлыг эмнэлгийн мэргэжилтнүүдээр бие махбодийн хувьд ч, сэтгэл санааны хувьд ч баримтжуулуулна. Гагцхүү энэ тохиолдолд хүнлэг бусаар харьцсан тухай өргөдлийг бүртгэх шаардлага тулгарах болно.

Эрүүдэн шүүсэн, эсхүл хүнлэг бусаар харьцсан тухай гомдлыг үнэн эсэхэд нь эргэлзэлгүйгээр мөрдөн байцаах эрх бүхий захиргааны ба эрүүгийн байгууллагад шилжүүлнэ. Ингэхдээ тодорхой бүлэг хүмүүсийн эрх ашгийг төлөөлөхтэй холбогдуулан дээр дурдсан болгоомжлуудыг баримтлан гомдолд дурдсан нэр бүхий хүмүүсийн аюулгүй байдлыг хангана. Гомдолд дурдсан тохиолдол үнэн эсэхийг тодруулах, нотлох зэрэг мөрдөн байцаалтын шаардлагатай арга хэмжээг эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

### **Хүнлэг бусаар харьцсан тухай гомдлыг бүртгэхэд шаардлагатай мэдээллийд:**

- Тухайн этгээдийн тухай холбогдох бүхий л мэдээ сэлт
- Гомдлын өргөдөл хүлээн авсан газар ба он, сар, өдөр Хорьж буй байгууллага
- Хүнлэг бусаар харьцсан газар ба он, сар, өдөр
- Хүнлэг бусаар харьцсаны төлөө хариуцлага хүлээн байгууллага, эрх бүхий субъект
- Хүнлэг бусаар харьцахад хүргэсэн нөхцөл байдал
- Хүнлэг бусаар харьцсан тохиолдлын гэрч нар
- Хүнлэг бусаар харьцсан үйл явдлын зураглал /хэн, юу, яаж, ямар хугацаанд г.м./

### **Холбогдох арга хэмжээ:**

- Ийм гомдол гарсан тухай өөр хэнд мэдээлсэн болон ямар үр дүн байгаа
- Гомдлыг захиргааны болон эрүүгийн журмаар гаргах боломж бий эсэх
- Гомдол гаргасан этгээд гомдлоо дамжуулах талаар зөвшөөрсөн эсэх

## 1

- Гомдол гаргасан эсэх, гомдол гаргагч, хохирогчийн хувьд ямар үр дагавар байгаа

**Эмчтэй бол:**

- Эмнэлгийн тодорхойлолт
  - Эмнэлгийн тусламж үзүүлэх зайлшгүй шаардлага
- 

Мониторингийн багийн гишүүдийн хувийн ажиглалт

Хорих, цагдан хорих газар ажиллаж байгаа багийн гишүүд эрүү шүүлттэй адилтган үзэж болохуйц, эцэстээ хоригдогсдын сэтгэл зүйн тэнцвэрийг алдагдуулахаар баримт байгаа эсэхийг мэдэх хэрэгтэй. Ийм харьцаа нь хоригдогсодод гэм хор учруулдаг. Учир нь ийм арга хэрэгсэлд өртсөн хохирогч нь түүнийгээ тодорхойлох чадваргүй байдалд ордог ба түүнийг тодорхой хэлж чаддаггүй. Ихэвчилэн хүнлэг бус харьцааг нэгтгэн дүгнэсэн тайлбарт гол төлөв дурьдаж болох жишээнүүд. Жишээ нь: “Тэд бидэнтэй мал шиг харьцааг” г.м.

- Хэд хэдэн удаа давтаж хэлэхгүй бол хоригдсон этгээдийн үгийг юман чинээ боддоггүй.
- Хоригдогч наарт дээрэнгүй хандаж харьцааг.
- Тэдний нүдрүү эгцлэн хардаггүй.
- Хорих өрөөнд нь шалтгаангүйгээр гэнэт дайран ордог.
- Тэднийг бие биедээ итгэхгүй байх тийм байдалд оруулдаг.
- Дотоод журмыг сахин хамгаалах нөхцөл байдлыг бий болгоогүй атлаа дотоод журам зөрчсөн хэмээн үзэж хоригдогч наарт арга хэмжээ авдаг.

Хоригдож байгаа этгээдүүдийн дунд гардаг дор дурьдсан хүчирхийлийн хэлбэрийг анхаарахгүй өнгөрч болохгүй. Үүнд: бие биенээ зodoх, гэмтэл учруулах, ёс бусаар хурьцал үйлдэх гэх мэт. Тэд гол төлөв хариу ёс авна гэдгээс айж мэдээлэхийг хүсдэггүй.

Хоригдож буй этгээдүүдийн дунд дээр дурьдсан хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлж дор дурьдсан арга хэмжээ авна. Үүнд:

Хоригдогсыг ангилж хорих

Нэг өрөөнд орох хүмүүсийг сонгож оруулах

Гомдол гаргах тохиромжтой журам тогтоох

Мэргэжлийн бэлтгэл хангагдсан хангалттай тооны албан хаагчидтай байх.

### Түлхүүр асуулт

- Ажилтнаас хамааран хоригдогч бие махбодийн хүчирхийлэлд өртсэн үү?
- Мэдэгдэхүйц ул мөр байна уу?
- Тэд сэтгэл санааны хүчирхийлэлд өртэж байсан уу?
- Одоо ч энэ төрлийн хүчирхийлэл үргэлжилж байгаа юу?
- Ажилтан болон хоригдогчдын хоорондын харьцаа ямар байна вэ?
- Хоригдогсод хоорондоо ямар харилцаатай вэ?

## ГАНЦААРЧЛАН ХОРИХ

1

### Стандарт

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 38 дахь дүрэм:

“1. Хоригдогчийг сахилгын байранд хорьж шийтгэх, түүнчлэн хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлөх бусад шийтгэл оногдуулахдаа зөвхөн эмч үзлэг хийж, ийм төрлийн шийтгэлийг давж гарна гэж бичгээр дүгнэлт хийсэн тохиолдолд хэрэгжүүлнэ”

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 56:

Хороо нь ямар нэг шалтгаанаар сахилгын шийтгэл ногдуулах журмаар хоригдогчийн тайван бус зан үйлийн улмаас, мөрдөн байцаалтын нөхцөл байдлаас ганцаарчлан хоригдож байгаа этгээдэд анхаарал тавих шаардлагатай.

Тэнцвэртэй байх зарчмын үүднээс ганцаарчилан хорих асуудлыг зөвтгэж болох боловч үр дагавар талаас нь авч үзвэл зарим тохиолдолд ийнхүү ганцаарчлан хорих нь хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах харьцаатай ижил болно. Ямар ч тохиолдолд ганцаарчлан хорих бүх хэлбэрийг хэрэглэхдээ хорих хугацаа хамгийн бага байхаар тооцох нь зүйтэй.

Хоригдогчийн өөрийнх нь хүсэлтээр ганцаарчилан хорих аргыг хэрэглэх тохиолдолд хоригдогч өөрөө буюу түүний нэрийн өмнөөс хорих, цагдан хорих газрын албан хаагч, эмч дуудвал эмч саадгүй ирж тухайн хоригдогчид эмнэлгийн үзлэг хийх шаардлагатай. Үзлэг хийсэн тухай тайланд хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл санааны байдал, шаардлагатай бол цаашид ганцаарчилан хорьsonoос үүдэн гарч болох үр дагаврын талаар бичиж эрх мэдэл бүхий байгууллага, албан тушаалтанд илгээнэ.”

## Тайлбар

Хорих, цагдан хорих газар ажиллаж байгаа ажлын хэсэг ямар нэгэн шалтгаанаар ганцаарчилан хоригдож байгаа этгээдэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. Энэхүү тусгаарлах арга хэмжээг хоригдогчийг хамгаалах үүднээс авч хэрэглэсэн бол түүнд тавих хязгаарлалтыг сахилгын арга хэмжээний нэгэн адил авч үзэх нь буруу.

Аль ч тохиолдолд ганцаарчлан хорих нь хүнд төрлийн шийтгэл бөгөөд түүнийг урт удаан хугацаанд юмуу эсхүл байнга давтан хэрэгжүүлбэл түүнийг хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, тэр ч бүү хэл эрүүдэн шүүх хэлбэр гэж үзэж болно. Тиймээс энэ аргыг маш онцгой, зайлшгүй тохиолдолд хэрэглэх бөгөөд үргэлжлэх хугацаа нь маш богино байх ёстой.

Насанд хүрээгүй хүмүүсийг ганцаарчилан хорьж болохгүйг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

### Түлхүүр асуулт

- Сахилгын байранд тусгаарлах хамгийн дээд хугацаа ямар байх ёстой вэ?
- Хэн ганцаарчилан хорих шийдвэр гаргах эрхтэй вэ?
- Сахилгын байранд тусгаарлагдсан хоригдогчийг өдөр бүр нэг цаг эрүүл агаарт байлгадаг уу?
- Ганцаарчилан хорихын өмнө эмнэлгийн үзлэг хийдэг үү? Хоригдох үед нь байнга хийж чаддаг уу?
- Ганцаарчилан хоригдож байгаа хоригдогчийг хүсэлт гаргасан тохиолдолд эмчийн үзлэгт хамруулдаг уу?

## ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

1

### Стандарт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаар хийсэн НҮБ-ын анхны Их хурал дээр 1955 онд баталсан “Хориглуутдтай харьцах наад захын жишиг дүрэм”, 33 дугаар дүрэм /34 дүгээр дүрмийг авч үз/:

Гав, дөнгө, номхруулах цамц болон гинжийг шийтгэлийн журмаар хэзээ ч хэрэглэж болохгүй. Үүнээс гадна дөнгө болон гинжийг номхруулах хэрэгсэл болгон хэрэглэж огт болохгүй. Зөвхөн дор дурдсан тохиолдолд тусгай хэрэгсэл ашиглаж болно. Үүнд:

- а/ хоригдогсдыг шүүхийн болон захиргааны байгууллагад тээвэрлэн хүргэх үеэр оргохоос урьдчилан сэргийлэх зорилгоор
- б/ эмчийн заавраар
- в/ хоригдогч өөртөө болон өрөөл бусдад хор уршиг учруулах гээд байгаа тохиолдолд хорих, цагдан хорих газрын дарга яаралтай эмчтэй зөвлөлдөж, удирдах дээд байгууллагад энэ тухай мэдэгдсэний дараа тушаал гаргаж хэрэглэж болох юм.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 39 дэх дүрэм:

“Гинж ба дөнгө хэрэглэхийг хориглоно. Гав, номхруулах цамц ба хүний хөдөлгөөнийг хориглосон бусад ийм төрлийн хэрэгслүүдийг ямар ч тохиолдолд шийтгэлийн журмаар хэрэглэхийг хориглоно. Зөвхөн дараах тохиолдуудад хэрэглэж болно. Үүнд:

- а/ хоригдогчийг захиргааны болон шүүхийн байгууллагад хүргэхээр тээвэрлэх үед тухайн байгууллагуудад очсон хойноо тайлах нэхцэлтэйгээр хэрэвээ тухайн байгууллагууд өөр журам тогтоогоогүй бол оргож болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор
- б/ эрүүл мэндийн шалтгаанаар эмчийн заавраар, эмчийн хяналтан дор
- в/ Хоригдогч өөртөө болон өрөөл бусдад бие махбодийн гэмтэл болон ноцтой хэмжээгээр эд материалын хохирол учруулах гээд байгаа тохиолдолд өөр арга хэмжээ үйлчлэхгүй бол хорих, цагдан хорих газрын дарга яаралтай эмчтэй зөвлөлдөж, удирдах дээд байгууллагад энэ тухай илтгэсний дараа тушаал гарган хэрэгжүүлж болох юм.”

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 40 дэх дүрэм:

“Өмнөх дурьдсан зүйл дээр зөвшөөрөгдсөн тусгай хэрэгслийг хэрэглэх аргыг хууль ба холбогдох эрх зүйн актаар тодорхойлно. Тэдгээрийг хэрэглэх хугацаа нь шаардлагатай хэмжээнээс хэрхэвч хэтэрч болохгүй”.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 53:

Шоронгийн ажилтнууд хүчирхийлэл үйлдэж байгаа хоригдогчид, хяналт тогтоох зорилгоор зарим тохиолдолд хүч хэрэглэхээс өөр аргагүйд хүрч болно. Онцгой тохиолдолд бие махбодийн арга хэрэглэх боломжтой. Гол нь ийм тохиолдолд хоригдогчид хэрцгий хандах эрсдэл бий болдог учраас хүний эрхийг зөрчихгүй байх онцгой баталгаа шаардагддаг байна.

Бие махбодийн хувьд хүч хэрэглүүлсэн хоригдогч богино хугацаанд эмчид үзүүлэх, шаардлагатай үед эмчилгээ хийлгэх эрх эдлэх ёстай. Эмчийн үзлэгийг эмнэлгийн бус бусад ажилтны нүднээс далд хийх ёстай. Үзлэгийн дүнгийн тухай албан ёсоор тэмдэглэл хөтөлж хоригдсон этгээдэд үзүүлнэ. Ийнхүү бие махбодид нөлөөлөх хэрэгсэл хэрэглэх шаардлага ховор тохиолдох бөгөөд энэ хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд тухайн хоригдогчийг зохих ёсны байнгын хяналтад байлгах хэрэгтэй. Үүнээс гадна хамгийн анхны боломж гарсан тохиолдолд албадлагын эдгээр хэрэгслийг хэрэглэхийг хориглох ёстай. Эдгээрийг хэзээ ч шийтгэлийн журмаар ашиглаж болохгүй. Эцэст нь хоригдогчид хүч хэрэглэсэн тохиолдол бүрийг тэмдэглэж байх шаардлагатай.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 63 дахь дүрэм:

“Хорих, цагдан хорих газрын ажилтан өөрийгөө хамгаалах аргагүй байдалд орсон, оргохыг завдсан тохиолдлыг таслан зогсоох, хоригдогсод хууль, дотоод журамд үндэслэсэн тушаалтыг идэвхтэй болон идэвхгүй аргаар эсэргүүцсэн зэрэг тохиолдолд хүч хэрэглэх болно. Хүч хэрэглэсэн албан хаагч зайлшгүй шаардлагатай хүрээнд, тийм цаг хугацаанд тусгай хэрэгсэл хэрэглээд зогсох ёстай бөгөөд энэ тухайгаа байгууллагын удирдлагад яаралтай танилцуулах ёстай.”

## Тайлбар

Тусгай хэрэгслийг зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэх бөгөөд сахилгын арга хэмжээ болгож хэрэглэх болохгүй. Түүгээр ч зогсохгүй тусгай хэрэгслийг хэрэглэхдээ дор дурдсан тодорхой баталгааг хангах шаардлагатай. Үүнд:

- Тусгай хэрэгсэл хэрэглэхээ аль болох богино хугацаанд зогсоох ёстай.
- Тусгай хэрэгсэл хэрэглэсэн хоригдогчийг эмчид үзүүлэх ёстай.
- Тусгай хэрэгсэл болон хүч хэрэглэсэн тохиолдлыг бүртгэх ёстай.
- Тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай хорих, цагдан хорих газрын даргад нэн даруй мэдэгдэх ёстай.

# 1

## Түлхүүр асуулт

- Тусгай хэрэгслийг ямар тохиолдолд хэрэглэхээр хуульчилсан бэ?
- Тусгай хэрэгсэл хэрэглэсэн бүх тохиолдлыг бүрэн бүртгэсэн байна уу?
- Тусгай хэрэгсэл хэрэглүүлсэн хоригдогч эмчид үзүүлэх боломж байна уу?
- Тусгай хэрэгслийг ямар хугацаагаар хэрэглэсэн байна вэ?

## ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

2

Энэ хэсэгт бид эрхээ хасуулсан хүмүүсийн хүний эрхийг сахиж “өө сэвгүй” хорих тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар авч үзнэ. Хорих, цагдан хорих газруудын дотоод журмыг яг таг биелүүлэх ёстой боловч сахилга батыг хангахдаа тодорхой журмаар, зөв аргаар хэрэгжүүлэх ёстой. Сахилгын арга хэмжээг авахад ч тодорхой баталгаагаар хангах ёстой. Энэ нь хоригдогсдоос хорих, цагдан хорих газрын дотоодод ч, гадаад орчны холбогдох албан байгууллагуудад ч чөлөөтэй гомдол гаргах, гомдол гаргаснаасаа болж аливаа аюулд өртөхгүй байх нөхцлөөр хангагдах явдал юм. Шалгалтын хараат бус арга хэрэгслүүд нь хоригдож байгаа этгээдийн хүний эрхийг хангах нөхцөлд хийх мониторингийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлнэ.

Өөр бусад арга хэмжээнүүд ч мөн адил хорих, цагдан хорих газарт дураараа дургих замбаараагүй байдал гаргахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл тухайн байгууллагад дотоодын хяналт хүчтэйн баталгаа болж өгдөг. Эдгээр арга хэмжээнүүд нь: хоригдогсдыг ангиллаар нь ялган зааглах, холбогдох бүртгэлүүдийг хөтлөх, байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зэрэг болно.

### **Хамгаалалтын арга хэмжээнүүд**

- Хоригдсон этгээдийн мэдээллийг хангах
- Тогтмол хяналт шалгалттай байх
- Сахилгын арга хэмжээнүүд
- Гомдол гаргах нөхцөл
- Бүртгэлийн дэвтрүүд
- Хоригдож буй этгээдүүдийг ангиллаар нь ялгах

## ХОРИГДОГСДЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

### Стандарт

2

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 13 дугаар зарчим:

Аливаа этгээдэд түүний эрхийг болон түүнийг хэрэгжүүлэх журмын талаар түүнийг баривчлах үед, saatuuлах болон хорихын өмнө эсхүл дараа нь нэн даруй уг баривчлах, saatuuлах, хорих ажиллагааг хариуцах байгууллага мэдэгдэж тайлбарлан ойлгуулах ёстой”

НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 35 дугаар дүрэм Европын широнгийн дүрмийн 41 дүгээр дүрмийг мөн үз:

1/ Хоригдол бүрийг хорих ангид хүлээж авахдаа тухай төрлийн хоригдуудтай харилцах журам, сахилгын шаардлага, түүнчлэн мэдээлэл авах, зөвшөөрөгдсөн эд зүйл, гомдол гаргах журам болон өөрийн эрх үүргээ мэдэх, амьдралын нөхцөлд дасахтай холбогдсон бусад асуудлаар мэдээллийг бичгээр өгнө.

2/ Бичиг үсэг мэддэггүй хоригдолд амаар танилцуулна.

### Тайлбар

Хоригдож байгаа этгээд анхнаасаа дүрэм журам, эрх, үүргийнхээ талаар мэдэж авах шаардлагатай. Үүнээс үүдэн шинээр ирсэн хоригдогчдод тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, журмын талаар энгийн, ойлгомжтой хэлээр бичиж хэвлэсэн гарын авлага өгөх хэрэгтэй. Гарын авлага нь хорих, цагдан хорих газарт хоригдогсдын дийлэнх нь мэддэг хэл дээр хэвлэгдсэн байвал зохино.

Хоригдогчийн гэр бүлийнхэн тухайн хорих, цагдан хорих газрын ажлын талаар, ялангуяа эргэлт уулзалт, захидал харилцаа, илгээмж ба утсаар харилцах асуудлаар мэдээлэлтэй байх ёстой.

---

### **Түлхүүр асуулт**

- Шинээр ирсэн хоригдогч ямар мэдээлэл авах ёстой вэ?
  - Мэдээлэл нь ямар хэлбэртэй байх ёстой вэ?
  - Ойлгомжтой хэл дээр байх уу? Бичиг мэддэггүй хүний ашиг сонирхлыг харгалзаж үзэх үү?
  - Хорих, цагдан хорих газрын дотоод журмыг нүдэнд ил харагдахаар газар бичиж байрлуулж уу? Түүнтэй дуртай цагтаа танилцах боломжтой юу?
  - Дотоод журмын агуулга нь хоригдогсодтой харьцах стандартад нийцэж байна уу?
  - Дотоод журмын агуулга нь ойлгомжтой, тодорхой юу?
-

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ

### Стандарт

2

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 29 дүгээр зарчим:

1/ Албадан saatuuлаах байранд холбогдох хууль, дүрмийг хатуу сахиулах зорилгоор уг байрыг шууд харьяалдаггүй байгууллагаас томилогдсон тэдгээрт ажлаа хариуцдаг өндөр мэргэжилтэй, ажлын зохих туршлага эзэмшсэн, эрх бүхий өөр хүмүүс байнга очиж ажиллах ёстай.

2/ Saatuuлагдсан буюу хоригдсон этгээд энэ зарчмын 1 дэх хэсэгт нийцсэн saatuuлаах буюу хорих газрын аюулгүй байдал, дэг журмыг хангах ухаалаг нөхцлийг сахин, saatuuлаах буюу хорих газарт очиж байгаа хүмүүстэй бусдыг байлцуулахгүйгээр чөлөөтэй харилцах эрхтэй.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 55 дугаар дүрэм:

Хорих байгууллага, албадыг эрх бүхий байгууллагын томилсон, мэргэшсэн туршлагатай хянан шалгагчид тогтмол шалгаж байх ёстай. Хянан шалгагчид тухайлбал хорих газрыг дагаж мөрдөж байгаа хууль, дүрмийн дагуу удирдаж, ажил нь хорих газар, засан хүмүүжүүлэх албадын өмнө тавьсан зорилгод нийцэж байгаа эсэхийг магадлаж байх ёстай.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 54:

Хоригдож буй этгээдээс гаргасан гомдолтой танилцаж, түүний дагуу шалгалт хийх хамгийн үр дүнтэй аргыг хэрэглэх нь хорих газарт хоригдгосодтой хэрцгий, хүнлэг бус харьцахын эсрэг баталгаа мөн. Хоригдгосод тухайн хорих, цагдан хорих газрын холбогдох удирдлага болон гадаад орчны холбогдох байгууллага, эрх баригчдад гомдол гаргах боломжоор хангагдсан байх ёстай. Хорих үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага бүрд хараат бус байгууллага жишээ нь, Уулзалт зохион байгуулагчдын зөвлөл, тухайн хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавихаар томилогдсон шүүгчид г.м хоригдогчийн гомдлыг хүлээн авч, түүний мөрөөр шалгах шаардлагатай бол холбогдох арга хэмжээ авах/, түүнчлэн тухайн байгууллагыг бүхэлд нь шалгах эрх бүхий, төлөөлөгчид тогтмол очиж ажиллаж байх шаардлагатай байдаг гэдэгт Хороо онцгой анхаарал хандуулж байна. Ийм байгууллагууд нь бусад арга

Хэмжээнүүдийн зэрэгцээ хорих, цагдан хорих газрын захиргаа болон хоригдогсдын хооронд үүсэх зөрчилдөөнийг арилгахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

2

## Тайлбар

Дээр дурдсанаас үзэхэд хараат бус байгууллага, сайн санаат иргэдийн зүгээс хийх хяналт шалгалт нь хэрцгий, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэрэгсэл төдийгүй хорих нөхцөлд хийх мониторингийн үр дүнтэй арга болно. Хорих, цагдан хорих газрын дотоодын хяналт, хяналт шалгалтын гадаад хүчин зүйлүүд сайжирна.

### Түлхүүр асуулт:

- Хяналт шалгалт хийх хараат бус арга хэрэгслүүд бий юу?
- Түүний бүтэц бүрэлдэхүүн ямар байдаг вэ?
- Хяналт шалгалт тогтмол хийгддэг үү?
- Хоригдосод эдгээр байгууллагад хандах боломж бий юу?
- Эдгээр байгууллагууд нь хоригдогсдын гомдлыг хүлээн авч, холбогдох арга хэмжээ авах эрх мэдэлтэй юу?

## САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ

### Стандарт

2

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 30 дугаар зарчим:

1/ Саатуулагдсан болон хоригдсон этгээдүүд saatuuлагдах буюу хоригдох үед гаргадаг сахилгын зөрчил гэж тооцогдох зан үйл шинж чанар, сахилгын арга хэмжээний төрөл, үргэлжлэх хугацаа, түүнийг оногдуулах эрх хэмжээ бүхий байгууллага зэргийг хуулиар болон хуульд нийцүүлэн гаргасан дүрмээр нарийвчлан тодорхойлох бөгөөд тэдгээр нь хэвлэгдсэн байх ёстой.

2/ Саатуулагдсан болон хоригдсон этгээд сахилгын шийтгэл ногдуулахаас өмнө тайлбар өгөх эрхтэй. Уг сахилгын арга хэмжээний талаар дээд шатны байгууллагад давж заалдах гомдол гаргах эрхтэй.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 27 дугаар дүрэм:

Сахилга дэг журмыг найдвартай хяналт, хамтын амьдралын зохих журмыг хангахад шаардлагатай хязгаарлалтыг л хэрэглэж хатуу сахиулбал зохино.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 29 дүгээр дүрэм:

Дараах зүйлийг хуулиар эсхүл эрх бүхий захиргааны байгууллагын шийдвэрээр тодорхойлох ёстой:

- а/ Сахилгын зөрчилд тооцогдох зан үйл
- б/ Хоригдолд оногдуулж болох шийтгэлийн төрөл, хугацаа
- в/ Шийтгэл оногдуулах эрх бүхий байгууллага

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 31 дүгээр дүрэм:

Шүүх, харанхуй гянданд хорих болон хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилсон шийтгэлийн төрлийг сахилгын зөрчил гаргасны төлөө хэрэглэхийг хоригловол зохино.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 55:

Түүнчлэн хоригдогсод болон хорих байрны ажиллагсдын эрх ашгийн үүднээс сахилгын арга хэмжээний тогтолцоог амьдрал дээр нарийвчлан тодорхойлж албан ёсоор тогтоож хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Аль нэгэн зүйл нь тодорхой бус байх нь албан ёсны бус (хянаадах боломжгүй) тогтолцоог бий болгох эрсдэлтэй байдаг. Сахилгын арга хэмжээ авах тухай журамд хоригдогсод тэдний үйлдсэн гэх эрх зүйн зөрчлийн талаар тайлбар хийх, оноогдож байгаа сахилгын арга хэмжээг хүлээн зөвөөрөхгүй байгаагаа холбогдох дээд байгууллагад илэрхийлэх эрхийг хангаж өгөх ёстой.

Сахилгын арга хэмжээ авах албан ёсны журмын зэрэгцээ аюулгүй байдлыг хангах сахилга батын арга хэмжээг (Жишээ нь, байгууллага дотроо “сайн дэг журам”-ыг хадгалахын тулд) хорих байр дотроо бий болгож түүний үрээр хоригдогсод өөрөө хүсээгүй байхад бусдаасаа тусгаарлагддаг. Ийм журам тогтоохдоо хорих байр мөн хоригдогсдын хүний эрхийг хангах баталгаатай байх ёстой. Хоригдогчид яагаад ийм арга хэмжээ авах болсныг мэдэгдэх ёстой бөгөөд аюулгүй байдлыг хангахад холбогдолтой өөр шаардлага гарваагүй бол түүнд тухайн асуудлаар саналаа хэлэх, дээд шатны байгууллагад гомдол гаргах боломжийг хангаж өгөх ёстой.

## Тайлбар

Сахилга батын арга хэмжээ авах тухай журмыг боловсруулахдаа нэг талаас хорих, цагдан хорих газарт дэг журам сахиулахтай холбоотой хэрэгцээ, нөгөө талаас хоригдогчийн хүний эрх, нэр төрийг хүндэтгэн харьцах хэрэгцээ хоёрыг зэрэгцүүлэн нийцүүлэх ёстой юм.

Зөрчилтэй холбогдуулан авах арга хэмжээнээс гадна зөрчилд оногдуулах шийтгэлийн талаар, шийтгэх эрх бүхий байгууллагын талаар, түүнчлэн шийтгэл хүлээсэн хоригдогчийн тайлбарыг сонсох, хэрвээ гомдолтой бол дээд шатны удирдлагад гомдлоо гаргах эрхийн талаар мөн тодорхой байх ёстой. Сахилга батын арга эмжээ авах тухай журмыг хоригдогчид амаар болон бичгээр, түүнд ойлгомжтой хэл дээр танилцуулах ёстой. Энэ журмыг бүх хоригдогсод үзэх боломжтой газар байрлуулах ёстой.

Сахилгын зөрчлийг авч хэлэлцэхдээ хуулиар тогтоосон баталгаанд аль болохоор нийцүүлэх ёстой. Жишээ нь, хоригдогчийн тайлбарыг сонсоходоо хуулинд зааснаар түүнийг төлөөлсөн өмгөөлөгчийг байлцуулах эрхтэй, ийм шийдлийг хөхүүлэн дэмжих нь зүйтэй.

Сахилгын арга хэмжээ нь хуульчлагдаагүй байх юмуу эсхүл гаргасан зөрчлөөс хатуудаж байвал эдгээр арга хэмжээ нь шударга бус байснаас хүнийг доромжилж, шаналгаж байвал хэрцгий, хүнлэг бус харьцаа гэж авч үзнэ.

## 2

### Түлхүүр асуулт:

- Сахилга батын ямар байдал ба ямар үйлдлийг хуульчилсан байна вэ?
- Хэн, ямар үндэслэлээр (амаар болон бичгээр гаргасан илтгэх хуудас) шийтгэлийг тогтоох вэ?
- Хоригдогч өөрийгөө хамгаалах боломжтой юу?
- Юунд буруутгаж байгаагаа хоригдогчдод мэдэгдсэн үү?
- Ямар арга хэмжээг, ямар хугацаагаар авах вэ?
- Давж заалдах гомдлыг яаж зохицуулдаг вэ?
- Давж заалдах гомдол хоригдогчийн талд шийдвэрлэгдэж байсан тохиолдол бий юу?
- Тодорхой нэг хугацаанд нийт хоригдогсодтой харьцуулбал хичнээн хоригдогч сахилга батын арга хэмжээ авагдсан бэ?

## ГОМДОЛ ГАРГАХ ЖУРАМ

### Стандарт

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 33 дугаар зарчмын:

1. Saatuuлагдсан болон хоригдсон этгээд, түүний өмгөөлөгч нь тухайн этгээдтэй хэрхэн харьцаж байгаа тухайлбал эрүүдэн шүүх, хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж байгаа талаар saatuuлах буюу хорих газрыг удирддаг буюу түүний дээд шатны байгууллагад шаардлагатай тохиолдолд гомдлыг хянан үзэх, хамгаалах арга хэмжээ авах бүрэн эрх бүхий бусад зохих байгууллагад гомдол хүсэлт гаргах эрхтэй

2. Хэрэв saatuuлагдсан болон хоригдсон этгээд түүний өмгөөлөгч энэ зарчмын 1 дэх хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд энэ эрхийг saatuuлагдсан болон хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн энэ тухай мэдсэн аливаа бусад хүнэдэлж болно.

3. Гомдол, хүсэлт гаргасан этгээд хүссэн бол уг гомдол, хүсэлтийг нууц байлгана.

4. Гомдол, хүсэлт нэг бүрийг яаралтай авч хэлэлцээд хариуг үндэслэлгүй удаашруулахгүйгээр өгөх ёстой. Хэрэв гомдол, хүсэлтийг хангахаас татгалзсан хийгээд, үндэслэлгүйгээр удаашруулсан тохиолдолд гомдол, хүсэлт гаргагч шүүхэд буюу бусад байгууллагад хандах эрхтэй. Saatuuлагдсан болон хоригдсон этгээд эсхүл гомдол, хүсэлт гаргасан хэнийг боловч энэ зарчмын 1 дэх хэсэгт зааснаар тэднийг гомдол, хүсэлт гаргасны нь төлөө хяхан хавчих ёсгүй.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хориглуутдай харьцах наад захын жишиг дүрэм”, 36 дугаар дүрэм:

1. Хоригдол бүр ажлын өдрүүдэд хорих ангийн дарга буюу бусад эрх бүхий ажилтанд өргөдөл, гомдол гаргах боломжтой байх ёстой.

2. Шалгалтын үед хориглууд хорих ангийн ажилтнуудад хүсэлт, гомдол гаргах бололцоотой байх ёстой. Тэд байцаагч, эсхүл шалгалтын бусад хүмүүстэй захирал, бусад ажилтнуудын эзгүйд ярилцах эрхтэй байх ёстой.

3. Хоригдол бүр хорих ангийн захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүсэлт өргөдлөө гаргах боломжтой байх ёстой бөгөөд тэдгээрийг агуулгын талаас хянахгүйгээр зохих хэлбэрийн дагуу бүрдүүлж тогтоосон журмаар широнгийн төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүргэж байвал зохино.

4. Тийм хүсэлт, гомдол, хэлбэрийн төдий, утгагүй шинжтэйгээс бусад тохиолдолд түүнийг яаралтай хянан шийдвэрлэж хэт удаашруулалгүй хариу өгөх ёстой.

## 2

### Тайлбар

Хоригдогсдод тухайн хорих, цагдан хорих газрын дотоод журмын тухай тодорхой танилцуулсан байх ёстoy бөгөөд тэдэнд хорих нөхцөлтэй холбоотой хэлэлцэх, эсэргүүцэх боломж байх ёстoy. Гомдол гаргах журамтай байх, үгүй нь тухайн хорих байранд хоригдогсдод үзүүлдэг хүндэтгэлийн хэлбэр ба агуулга ямар байгааг харуулна.

Гомдлын хэд хэдэн төрөл байх ёстoy. Дотооддоо, хорих, цагдан хорих газрын даргад хандаж гаргах гомдол, хоригдогч шаардлагатай гэж үзвэл дээд шатны удирдах байгууллагад гаргах гомдол (энэ тохиолдолд гомдлын агуулгыг хорих, цагдан хорих газрын захиргаа хянах ёсгүй) гэж ялгагдана. Харин давах шатны гомдол нь түүнийг хүлээж авах байгууллага болон энэ байгууллагын эрх мэдлийн хүрээнээс шатгаалан хоорондоо ялгаатай байдаг.

Энэ асуудлыг хяналт шалгалтын тухай асуудалтай хамтатган авч үзэж болох байсан. Учир нь хяналт шалгалт хийдэг байгууллага нь гомдол хүлээн авч, хянан үзэх боломжтой байж болно.

---

### **Түлхүүр асуулт**

- Хоригдогсод давж заалдах ямар боломжтой байдаг вэ?
  - Давж заалдах гомдол захиригааны болон шүүхийн ямар шинжтэй байдаг вэ?
  - Давж заалдах гомдлыг хэнд хандаж, ямар журмаар гаргадаг вэ?
  - Энэ журам хоригдогсодод бүгдэд нь боломж олгодог уу?
  - Хорих, цагдан хорих газрын захиригаанд давах шатны гомдол гаргах боломжтой юу?
  - Хяналт шалгалтын байгууллагад гомдол гаргах боломжтой юу?
  - Давах шатны гомдлыг авч үзэх хугацаа ямар вэ?
  - Сүүлийн 6 сард хичнээн гомдол гарсан бэ? (Тухайн хорих байранд байгаа нийт хоригдогсдын дундажтай харьцуулвал)
  - Хичнээн гомдлыг гомдол гаргагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэсэн бэ?
-

## ХОРИГДОЖ БАЙГАА ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ

### Стандарт

2

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 12 дугаар зарчим:

- 1/ Дараах зүйлийг зохих ёсоор тэмдэглэлд бичнэ.
  - а/ Баривчилсан шалтгаан
  - б/ Тухайн этгээдийг баривчилсан цаг, түүнийг saatuuлах газарт хүргэсэн цаг, түүнчлэн тэр анх удаа шүүхэд буюу бусад байгууллагад хүргэгдсэн цаг
  - в/ Хууль хэрэгжүүлэх байгууллагын зохих албан тушаалтнуудын овог нэр
  - г/ Хорих газартай холбогдолтой тодорхой мэдээлэл
- 2/ Хуульд заасан хэлбэрээр бичигдсэн тийм тэмдэглэлийг saatuuлагдсан этгээд өмгөөлөгчтэй бол түүнд танилцуулна.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдуудтай харьцах наад захиин жишиг дүрэм”, 7 дугаар дүрэм:

1.Хорих газар бүрт дугаарласан хуудастай хавтасласан дэвтрин хэлбэртэй бүртгэл байвал зохих бөгөөд түүнд хоригдогч бүрийн талаар дараахи зүйлийг бичих ёстой.

- а/ Хувийн байдалтай нь холбоотой мэдээлэл
- б/ Хоригдсон шалтгаан ба хорих шийдвэр гаргасан байгууллага
- в/ Хорих газарт ирсэн болон гарсан өдөр, цаг

2.Хэнийг ч хүчин төгөлдөр хорих тогтоолгүйгээр хорих, цагдан хорих газарт хүлээн авах ёсгүй бөгөөд тогтоолын дэлгэрэнгүй утгыг бүртгэлд урьдчилан тусгана.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 7 дахь дүрэм:

1. Хэнийг ч хуулийн хүчин төгөлдөр болсон шаардлагатай баримт бичиггүйгээр хорих, цагдан хорих газарт хүлээн авч хорихыг хориглоно.
2. Хоригдогчийг хүлээн авсан ба хорьсон тухай тэр даруй бүртгэнэ.

## Тайлбар

Хоригдогсдын албан ёсны бүртгэлийн хэлбэр нь бичгээр буюу цахим төхөөрөмж дээр хийгдсэн хэлбэрээсээ үл хамааран эрх бүхий ажилтнуудаас хоригдогчдыг хамгаалах үндсэн шинжийн нэг мөн.

Дараахь бүртгэлүүд хийгдэх ёстой. Үүнд:

- Хоригдогчийн овог, нэр
- Хоригдох болсон шалтгаан
- Баривчилсан цаг хугацаа, хорих буюу цагдан хорих газар хүргэгдэж ирсэн цаг, шүүх болон бусад байгууллагад ирсэн цаг
- Хууль хяналтын байгууллагын холбогдох албан тушаалтны овог, нэр
- Хүлээж авсан дээрхи газруудын мэдээлэл (эрх чөлөөгөө хасуулсан бүх этгээдийн хаана хоригдсоныг түргэн тодруулахад шаардлагатай)

Түүнчлэн хүч хэрэглэсэн, сахилгын арга хэмжээ авсан зэрэг асуудлуудыг бүртгэдэг дэвтэр байх ёстой.

### Түлхүүр асуулт

- Шинээр ирэгсэд, суллагдагсдын болон шилжүүлгийн бүртгэл бүрэн хөтлөгддөг үү?
- Болсон бүх асуудал бүртгэлд тусгагддаг уу?

## ХОРИГДОЖ БУЙ ЭТГЭЭДҮҮДИЙГ АНГИЛАХ

### Стандарт

2

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10.2 дугаар зүйл:

Онцгой нэхцэл байдлаас бусад тохиолдолд яллагдагчийг хоригдлуудаас тусад нь, яллагдаагүй хүний эрхэд нийцсэн тусгай дэглэмд байлгана.

6/ Насанд хүрээгүй яллагдагчийг насанд хүрэгсдээс тусад нь байлгаж, шүүхийн шийдвэр гаргуулахаар шүүхэд яаралтай хүргэнэ.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 8 дугаар дүрэм (түүнчлэн 85-ыг үз):

Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй хэрхэн харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад эсхүл нэг хорих газрын өөр өөр хэсэгт байлгана. Ингэснээр:

а/ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг боломжийн хэрээр тусдаа хорих газруудад байлгана.

б/ Хэрэв эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэд нэг хорих газарт байгаа бол эмэгтэйчүүдийг тусдаа өрөө тасалгаанд байрлуулбал зохино.

в/ Шүүхээр ял шийтгүүлээгүй хүмүүсийг хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс тусад нь байлгана.

г/ Θөрийн үүргээ биелүүлээгүй буюу иргэний бусад хэрэгт холбогдон хоридож байгаа хүмүүсийг эрүүгийн гэмт хэрэг үйлдэж хоригдож байгаа хүмүүсээс тусад нь байлгавал зохино.

д/ Эрх зүйн зөрчил үйлдсэн бага насны хүмүүсийг насанд хүрэгчдээс тусад нь хорино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 11 дэх дүрэм (түүнчлэн 12 ба 13-ыг үз):

1.Хоригдогдыг хорих, цагдан хорих газруудад хуваарилахдаа, эсхүл түүний хоригдох дэглэмийг сонгоходо шүүхээр буюу хуулиар тогтоосон эрх зүйн байдал, (сэжигтэн, яллагдагч, анхны ба давтан гэмт хэрэгтэн, богино хугацааны ба урт хугацааны ял авсан) засан хүмүүжүүлэхтэй холбоотой онцгой шаардлагууд, биеийн эрүүл мэндийн байдал, нас, хүйс зэргийг анхаарч үзнэ.

2.Эрэгтэй, эмэгтэй хүмүүс зохион байгуулалттай гэмт хэрэг хамтран үйлдэж, нэг хөтөлбөрөөр засан хүмүүжүүлэгдэх байсан ч тусад нь хорино.

3.Хоригдогсод өөрсдөө зөвшөөрсөн болон зохион байгуулалттай үйл ажиллагаанд хамтран оролцож байгаагаас бусад тохиолдолд сэжигтэн, яллагдагчийг тусад нь хорино.

4.Залуу хүмүүсийг, тэдэнд үзүүлэх муу нөлөөнөөс хамгаалсан, насны байдал тохирсон нөхцөлд хорино.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 24:

Хоригдогч эмэгтэйчүүдийг тухайн хорих, цагдан хорих газарт хоригдож байгаа эрэгтэйчүүдээс тусгаарлан хорих нь зарчмын чухал асуудал юм. Гэхдээ зарим улс оронд хоригдогч гэр бүлийн гишүүдийг хамтад нь хорих буюу тодорхой түвшинд холбоотой байх нөхцөл бүрдүүлэх зорилгоор эрэгтэй, эмэгтэй хоригдогсдыг хамт хорих явдал байдаг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо дэвшилттэй ийм хэлбэрийг зөвхөн тухайн хоригдогсод өөрсдөө зөвшөөрсөн болон тэднийг нарийвчлан сонгосон тохиолдолд, түүнчлэн зохих ёсны хяналттай нөхцөлд хөхүүлэн дэмжиж байна.

## Тайлбар

Хорих, цагдан хорих газрууд өөрт харьяалагдаж байгаа бүх хоригдогсдыг хамгаалах үүрэг хүлээнэ. Ялангуяа хоригдогсдыг, албан хаагчид болон бусад хоригдогсдоос хамгаалах үүрэгтэй. Хоригдок буй этгээдүүдийг ангилахдаа дараахь зарчмуудыг баримтална. Үүнд:

- Нас, хүйс: эрэгтэй, эмэгтэй, насанд хүрээгүйчүд
- Шүүхийн эрх зүйн үндэслэл: сэжигтэн, яллагдагч, анхны гэмт хэрэгтэн, давтан гэмт хэрэгтэн, эрх чөлөөтэй амьдралд байсан байдал болон баривчлагдсан шалтгаан.

Олон улсын стандартад хоригдогсдыг ангиллаар хориходоо боломжийн хорих анги буюу цагдан хорих ангид хорихыг зөвлөсөн байдаг.

Насанд хүрээгүй хоригдогсод тэдний онцгой хэрэгцээг хангахуйцаар нөхцөлд хоригдох ёстой.

## 2

### Түлхүүр асуулт:

- Насанд хүрээгүй хоригдогсдыг насанд хүрэгчдээс байнга тусад нь хорьдог уу?
- Энэ бүх төрлийн хорих газарт хамаатай.
- Эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс 24 цагийн турш тусад нь хорьдог уу?
- Ялангуяа эмэгтэйчүүдийг байнгын хяналтад байлгадаг уу?
- Эмзэг, өртөмтий бүлэгт хамарагдах хоригдогсдыг бусдаас нь тусад нь байлгадаг уу?
- Нийтээр нь хорих байранд:
- Хэнийг хаана байрлуулахыг хэн, ямар үндэслэлээр шийдвэрлэдэг вэ?
- Хоригдогч байраа солихыг хүсэх эрхтэй юу?
- Тийм бол ямар үндэслэлээр?
- Хоригдогсдын зүгээс гарч болох хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялангуяа ижил хүйсийн хүндээ бэлгийн хүчирхийлэл үйлдэх явдлыг хорих газрын ажилтнууд хэрхэн арилгадаг вэ? Эрх баригчид хүний эрхийг хязгаарлаад тухайн этгээдийн үндсэн хэрэгцээг хангах хариуцлага хүлээдэг үү? Хүний эрхийг хязгаарлах нь өөрөө шийтгэл учраас тэр нь хорих шаардлага хангаагүй нөхцөлд байлгах асуудлаар хүндрэх ёсгүй.

## МАТЕРИАЛЛАГ НӨХЦӨЛ

3

Хорих, цагдан хорих газарт боломжийн нөхцөл бүрдүүлэх нь хоригдогчийн хүний эрх, нэр төрийг хадгалахад чиглэгдсэн зайлшгүй шардлагатай нөхцөл юм. Амьдрах байр, хүнс, хувийн ариун цэвэр зэрэг нь хоригдогчийн эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах хүчин зүйлүүд юм.

Хорих, цагдан хорих газар хүнээр дүүрэх, хэт олшрох асуудал илүү ноцтой бөгөөд энэ нь юуны түрүүнд хорих нөхцлийн бусад хүчин зүйлүүдэд сөргөөр нөлөөлж, хорих, цагдан хорих газруудын ерөнхий орчин нөхцлийг доройтуулна. Дээрхи ноцтой асуудал тодорхой түвшинд хүрмэгц тэнд хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон гутаасан хэрэг болно.

---

### Материаллаг нөхцөлд:

- Хүнс
  - Гэрэлтүүлэг ба агааржуулалт
  - Эрүүл ахуйн нөхцөл
  - Хувийн ариун цэвэр
  - Хувцас, цагаан хэрэглэл
  - Хоригдогчийг байрлуулах
-

## ХООЛ ХҮНС

### Стандарт

3

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харьцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хориглуутдай харьцах наад захын жишиг дүрэм”, 20 дугаар дүрэм:

1. Шоронгийн захиригаа ердийн тогтсон цагт хоригдол бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалах хангалттай тэжээллэг, сайн чанарын сайтар бэлтгэж өгсөн хоол ундаар хангах ёстай.

2. Хоригдол бүр хэрэгцээтэй үедээ уух ундааны устай байх ёстай.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 25 дахь дүрэм:

1. Хорих, цагдан хорих газрын захиригаа эрүүлийг хамгаалах байгууллагаас тогтоосон шаардлагын дагуу сайтар бэлтгэгдсэн, хүнсний норм ба орчин үеийн ариун цэврийн шаардлагад нийцсэн, хоригдогчийн нас, эрүүл мэндийн байдал, хийж буй ажлын байдал, боломжтой бол шүтдэг шашин, ёс, зан заншил зэргийн онцлогийг харгалзсан хүнсээр тогтоосон цагт хоригдогчийг хоол, хүнсээр хангана.

2. Хоригдогч бүр ундны ус хэрэглэх боломжкоор хангагдсан байна.

### Тайлбар

Хоригдогсдын хоол амт чанар, хэмжээ, нэр төрлөөрөө хоригдогчийн эрүүл мэндийг хангахуйц байх ёстай.

Хоригдогчийг 48 цагаас илүү хугацаагаар саатуулсан бол түүний эрүүл мэндэд тохируулан хоолны бүтцийг эмчийн заавраар тодорхойлно.

Хоолыг энгийн нөхцөлд байгаа шиг ариун цэврийн шаардлагыг хангаж өгнө. Гал тогооны нөхцөл, ариун цэврийг хамгийн түрүүнд шалгана. Хоол өгөх үеэр нь байлцаж хоолны хуваарилалтад хяналт тавих нь зүйтэй.

Хоригдогсод ундны цэвэр усаар байнга хангагдах ёстай.

---

**Түлхүүр асуулт:**

- Хоолны чанар, хэмжээ, нэр төрөл ямар вэ? Цэсийг хэн тодорхойлдог вэ?
  - Нэг хоригдогчид нэг өдөр болон жилд оногддог хоолны төсөв?
  - Өвчтэй хүмүүс, өндөр настан, ээжтэйгээ байдаг бага наасны хүүхдэд тусгай хоол өгдөг үү?
  - Хэдэн цагт хооллодог вэ? Хоол өгөх хоорондын зайд тохиромжтой юу?
  - Цагийн хуваариас бусад цагт хоригдогч хүнс, ус авч болох уу?
  - Шашин шүтлэгийн үүднээс хоолны бүтэц өөрчлөгддөг үү?
  - Хоригдогсод өөрсдөө хоол хүнсний зүйл авах боломжтой юу?
  - Ар гэрийнхэн нь хүнсний зүйл өгөх боломжтой юу?
  - Хорих, цагдан хорих газрын эмч хоолны норм биелэгдэж байгаа эсэхэд байнга хяналт тавьдаг уу?
-

## ГЭРЭЛТҮҮЛЭГ БА АГААРЖУУЛАЛТ

### Стандарт

3

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 16 дахь дүрэм:

а. Хоригдогч хэвийн нөхцөлд байгалийн гэрэлд унших, ажиллах боломжтой байхаар том цонхтой байна. Агааржуулалтын тоног төхөөрөмж сууринуулаагүй тохиолдолд цонх нь цэвэр агаар оруулах боломжтой хийгдсэн байна. Үүний зэрэгцээ аюулгүй байдлын шаардлагыг хангасан нөхцөлд цонх нь хэмжээ, байрлал, бүтцээрээ хэвийн цонхонд дээд зэргээр ойртож очсон байх ёстой.

б. Хиймэл гэрэлтүүлэг нь нийтийн хэрэглээний гэрэлтүүлгийн техникийн нормд дүйцэх ёстой.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан "Хориглуудтай харьцах наад захын жишиг дүрэм", 11 дүгээр дүрэм:

Хориглуудын амьдарч ажиллаж байгаа өрөө тасалгаанд:

а/ Цонх нь байгалийн гэрэлд уншиж, ажиллаж болох хангалттай хэмжээтэй, агааржуулалтын хиймэл системтэй эсэхээс үл хамааран цэвэр агаар орохоор хийгдсэн байвал зохино.

б/ Хиймэл гэрэлтүүлэг нь хоригдлын хараанд аюулгүй, уншиж, ажиллаж болохоор хангалттай байвал зохино.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2000 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арваннэгдэх Ерөнхий Илтгэл, зүйл 30:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хороо хорих, цагдан хорих газрын цонхонд төмөр хаалт, хөндлөвч, хавтан зэргийг бөхөлж хоригдогсдын байранд нэвтрэх байгалийн гэрэл, цэвэр агаарыг боогдуулж байгаатай байнга тааралддаг. Ялангуяа урьдчилан хорих газарт ихэвчлэн ийм байна. Тэнд хоригдогсод нууцаар хэлэлцэх, гэмт үйлдэл хийхээс урьдчилан сэргийлж ийм арга хэмжээ авах нь зүйтэй гэдэгтэй Эрүү шүүлт урьдчилан сэргийлэх Европын Хороо санал нэгтгэй байгаа боловч энэ нь тодорхой бүлэг хоригдогсод хамааралтай асуудал байхад нийтээр хэрэгжүүлэх журам болгосон нь зохисгүй гэж үзэж байна. Тиймээс эрх бүхий байгууллагууд хоригдогч тус бүрийн байдлыг анхааран үзээд тухайн хоригдогчид ийм арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлдог байх нь зүйтэй. Цаашилбал, урьдчилан сэргийлэх ийм арга хэмжээ хэдийгээр байх ёстой ч хоригдогчийн байгалийн гэрэл, цэвэр агаарыг боогдуулах ёсгүй юм. Байгалийн гэрэл, цэвэр агаар нь хоригдогчийн амьдрах нөхцлийг хангах суурь үзүүлэлтүүд бөгөөд хоригдогч эдгээрийг ашиглах эрхтэй. Түүгээр ч зогсохгүй эдгээр

үзүүлэлтүүд хангалттай байхгүйгээс өвчин, ялангуяа сурьеэ өвчин халдвэрлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Хорих байранд амьдралын зохистой нөхцлийг бүрдүүлэхэд хэтэрхий өндөр үнэ шаардагдах ба зарим улс оронд хангалттай санхүүжилт хийгдэггүйгээс хүндрэл учирдаг гэдэгтэй Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хороо санал нэгтэй байна. Гэвч хоригдогсдын цонхонд бөхөлсөн зүйлсийг авч хаях (тэгээд шаардлагатай газарт нь зохих бутцийн дагуу урьдчилан сэргийлэх төхөөрөмж байрлуулах) нь нэг их зардал шаардах асуудал биш бөгөөд харин ч энэ асуудалтай холбоотой бүх хүнд ашигтай зүйл юм.

## Тайлбар

Хоригдогсод байгалийн гэрэл, цэвэр агаар ашигладаг байх нь чухал асуудал юм. Цонхны гэрлийг хаах ёсгүй бөгөөд бас цэвэр агаар оруулах зориулалттай байх ёстай. Хоригдогсод амьдрах байранд нь байрлуулсан хиймэл гэрэлтүүлгийг өөрсдөө асааж, унтраах боломжтой байх ёстай.

---

### Гол асуудлууд:

- Гэрэлтүүлэг нь уншихад хангалттай юу?
  - Хоригдогсод гэрэлтүүлэг болон агааржуулалтаа өөрсдөө тохируулах боломжтой юу?
  - Цонхыг нээх бололцоотой юу?
-

## АРИУН ЦЭВРИЙН НӨХЦЛҮҮД

### Стандарт

3

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлууттай харьцах наад захын жишиг дүрэм”, 12 дугаар дүрэм:

Ариун цэврийн төхөөрөмжүүд нь хоригдол бүр шаардлагатай үедээ, цэвэр, тохиромжтой нөхцөлд өөрийн байгалийн хэрэгцээгээ хангаж болохоор хангалттай байвал зохино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 17 дахь дүрэм:

Ариун цэврийн төхөөрөмжүүд ба түүнийг ашиглах боломж нь хоригдогсод шаардлагатай үедээ, цэвэр, тохиромжтой нөхцөлд байгалийн хэрэгцээгээ хангахуйц байх ёстой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 49:

Бие засах шаардлага хангасан төхөөрөмжийг шаардлагатай үедээ чөлөөтэй ашиглах боломж ба тэдгээрийг эрүүл ахуйн стандартад нийцэхээр байлгах нь хүмүүнлэг орчин бүрдүүлэх хинтэй хүчин зүйл юм.

Энэ үүднээс Хороо зарим орнуудад хоригдогсод бие махбодийн хэрэгцээгээ хоригдож байгаа өрөөндөө хувинд хангаж, дараа нь түүнийгээ тодорхой цагт гаргаж асгадаг практикийг дэмжихгүй байгаагаа илэрхийлэх ёстой. Эсхүл хоригдож байгаа өрөөнд нь эрүүл ахуйн шаардлага хангахуйц бие засах газартай байх ёстой, эсхүл шаардлагатай үедээ(шөнийн цагаар ч) бие засах ямар нэгэн боломжоор хангагдах ёстой.

### Тайлбар

Хоригдогсод бие махбодийн хэрэгцээгээ /бие засах/ тухайн цагт нь сааталгүйгээр, цагийн хуваарын баригдалгүйгээр хангах.

Бие засах газар нь амьдрах байрнаас тусдаа байгаа нөхцөлд сааталгүй ашиглах боломжтой байх нь чухал.

Олон хоригдогсод нэг дор байрладаг хорих байрны бие засах газар байнга ашиглагдаж байдаг. Захиргааны зүгээс бие засах газрын техникийн үйлчилгээг тогтмол хийдэг байх ёстой.

### Түлхүүр асуулт:

- Хоригдогсдын бие засах газар ба шүршүүр нийт хоригдогсдод хангалттай хүрэлцдэг үү?
- Бие засах газар нь амьдрах байрнаас тусдаа байдал бол:
  - Бие засах газарт орохын тулд хоригдогсдод хичнээн хугацаагаар хүлээх шаардлага гардаг вэ?
  - Амьдрах байрыг шөнө түгжсэн хойно хоригдогсод яаж бие засдаг вэ?
  - Хянагчийг дуудах уу?
  - Таглаатай хувин сав ашиглах уу?
- Бие засах газрын эрүүл ахуй – техникийн нөхцөл стандартад нийцэж байна уу?

## ХУВИЙН АРИУН ЦЭВЭР

### Стандарт

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 13 дугаар дүрэм:

Усанд орох төхөөрөмж, шүршүүрийн тоо нь хоригдол бүр тухайн цаг агаарын нөхцөлд тохирох халуун усанд жил, улирал, газар зүйн байрлал нь ариун цэврийн өрөнхий шаардлагад нийцэх, усанд орж болохоор өөрөөр хэлбэл ердийн цаг агаарын нөхцөлд байна. Ядахдаа 7 хоногт 1 удаа халуун усанд орох боломжтой байх ёстой.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харьцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 15 дугаар дүрэм:

Хоригдлуудад өөрийгөө цэвэр авч явахыг шаардах ёстой. Үүний тулд тэднийг ус болон ариун цэвэр, эрүүл мэндэд нь тодорхой шаардагдах ариун цэврийн хэрэгслээр хангах хэрэгтэй.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 18 дахь дүрэм:

Усанд орох онгоц ба шүршүүрийн тоо хангалттай байх ёстой. Хоригдогч бүр цаг уурын байдалд нийцсэн дулаан орчинд, тухайн орон нутгийн байдал болон тухайн улирлын байдлаас шалтгаалан эрүүл ахуйн хэрэгцээ шаардлагын дагуу усанд орох ёстой. Ямар ч тохиолдолд 7

хоногт нэгээс доошгүй удаа усанд орох ёстай. Боломжтой газар бурд хоригдогч бүр боломжтой цагт усанд орох боломжтой байх ёстай.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 49:

Үүнээс гадна хоригдогсод усанд орох газарт нэвтрэх боломжтой байх ёстай. Түүнчлэн хорих өрөөнд нь ус дамжуулагч байрлуулбал бүр зохицтой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 31:

Эмэгтэйчүүдийн ариун цэврийн онцгой хэрэгцээг холбогдох ёсоор шийдвэрлэх нь зүйтэй. Бие засах газар ба угаалгын өрөөг хориг саадгүй ашиглах, цус нэвтэрсэн материалыг айх аюулгүй хаях, түүнчлэн хувийн ариун цэврийн хэрэгслээр хангагдах зэрэг нь онцгой чухал асуудал юм. Энэ үндсэн хэрэгцээг хангахгүй байвал энэ асуудлыг хүний нэр төрийг гутаан доромжилсон харьцаа гэж үзнэ.

## Тайлбар

Хувийн ариун цэврийг сахихаас эрүүл мэндийн байдал шалтгаална. Хувийн ариун цэврийг сахих нь хамт байгаа бусад хүмүүс болон өөрийгөө хүндэтгэхийн илрэл юм.

Мөн хувийн ариун цэврийг сахиж, байгаа газраа цэвэрхэн суух зэргийг ажилтнуудын зүгээс хоригдогсодод хандах сайн хандлагын үүднээс авч үзэж болно. Зохисгүй нөхцөлд буюу бохир нөхцөлд хоригдогсдыг албадан байлагх явдлыг хүнлэг бус, хүний нэр төрийг доомжлон гутаасан гэж үзнэ.

Хорих, цагдан хорих газруудын захиргаа хоригдогсдыг хувийн ариун цэврээ сахих хэрэгслээр хангана.

Эмэгтэйчүүд хувийн ариун цэврийг сахих үүднээс хэвийн болон сарын тэмдэг үзэгдэх үед шаардлагатай хэрэгслээр тогтмол хангагдах ёстай. Хэрэв эмэгтэйчүүд хүүхдүүдтэйгээ хамт байгаа бол хүүхдийн ариун цэвэрт шаардлагатай хэрэгслээр хангагдана.

Хоригдогсдын хийж байгаа ажил, цаг уурын байдлаас хамааран усанд орох хугацааг тогтооно.

### Түлхүүр асуулт:

- Хорих, цагдан хорих газрын захиргаа хоригдогсдыг ариун цэврийн ямар хэрэгсээр хангадаг вэ? Хэр зэрэг тогтмол вэ?
- Хоригдогсод байнга шүршүүрт орох боломжтой юу?
- Ажил хийдэг болон хийдэггүй хүмүүсийн усанд орох нь ялгаатай юу?
- Эмэгтэйчүүд сарын тэмдэг үзэгдэх үеэр ариун цэврийн шаардлагатай хэрэгслээр хангагддаг уу?

## ХУВЦАС, ЦАГААН ХЭРЭГЛЭЛ

### Стандарт

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 17 дугаар дүрэм:

1. Энгийн хувцас өмсөх эрхгүй хоригдлуудад тухайн цаг агаарт тохирсон, эрүүл мэндээ хэвийн байлгах боломжтой иж бүрэн хувцас тавьж олгох нь зүйтэй. Энэ хувцас нь гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй.

2. Хувцас нь цэвэр, бүрэн бүтэн байх ёстой. Ариун цэврийн шаардлагыг хангахуйцаар угаасан дотуур хувцас тавьж олгож байвал зохино.

3. Хоригдол эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хорих газраас гарч явах онцгой тохиолдолд түүнд өөрийнхөө хувцсыг, эсвэл нүдэнд өртөхөөргүй бусад хувцас өмсөхийг зөвшөөрөх нь зүйтэй.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 18 дугаар дүрэм:

Хэрэв хоригдлууд энгийн хувцас өмсөхийг зөвшөөрдөг бол хоригдох үед хувцас нь цэвэр, өмсөхөд тохиромжтой байх арга хэмжээ авбал зохино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 22 дахь дүрэм:

1. Өөрийнхөө хувцсыг өмсөх эрхгүй хоригдол тухайн газар нутгийн цаг уурын байдалд тохирсон, тэдний эрүүл мэндийг хамгаалахуйц хувцсаар хангагдах ёстой. Энэ хувцас нь хэрхэвч гутаан доромжилсон, нэр төрийг нь унагаасан байж болохгүй.

2. Бүх хувцас нь цэвэр, бүрэн бүтэн байх ёстай. Дотуур хувцсыг ариун цэврийн шаардлагын дагуу тогтмол сольж, угааж байх ёстай.

3. Хорих, цагдан хорих газраас гадуур явах зөвшөөрөл авсан тохиолдолд хоригдогч өөрийнхөө хувцсыг өмсөх, эсвэл нүдэнд өртөхөөргүй өөр хувцас өмсөхийг зөвшөөрөх хэрэгтэй.

## 3

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын широнгийн дүрэм, 24 дахь дүрэм:

Хоридогч бүр тусдаа ор, цэвэр, бүрэн бүтэн цагаан хэрэгслээр хангадах ёстай бөгөөд тэдгээрийг шаардлага гарсан тохиолдол бүрд солих ёстай.

### Тайлбар

Хоригдогсодод өөрсдийнхөө хувцсыг өмсөхийг зөвшөөрдөггүй бол тэдэнд ижил хувцас өмсгөхөөс зайлсхийж жирийн хувцсаар хангах ёстай. Хорих, цагдан хорих газраас олгосон хувцас нь тухайн хоригдочийн хувийн өмчид тооцогдох ёстай.

Хоригдогч бүр унтах ор, цагаан хэрэглэлээр хангадах ёстай бөгөөд тэдгээр нь цэвэр, хэрэгцээ хангахуйц чанартай байх ёстай. Цагаан хэрэглэлийг 15 хоногт нэгээс доошгүй удаа сольж өгөх ёстай.

---

#### Түлхүүр асуулт:

- Цагаан хэрэглэлийг тогтмол сольдог уу?
  - Хоригдогсод өөрсдөө хувцсаа угаах боломжтой юу?
-

## ХОРИХ ГАЗАР ХҮНЭЭР ХЭТ ДҮҮРЭХ БА ХОРИГДОЖ БҮЙ ЭТГЭЭДИЙГ ЗОХИСТОЙ БАЙРШУУЛАХ

### Стандарт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 46:

Шорон дүүргэлтийн асуудал нь Хорооны эрх мэдэлтэй шууд холбоотой асуудал юм. Тухайн шоронд хоригдох ёстой хүнээс нь олон хүн хорьвол энэ нь тухайн хорих байрны дотоод үйл ажиллагаа, бүх талын үйлчилгээнд муугаар нөлөөлнө. Амьдралын ерөнхи түвшин магадгүй мэдэгдэхүйц буурна. Үүнээс гадна шорон болон түүний тодорхой нэг хэсгийн дүүргэлтийг хүний бие махбодь оршин тогтох үүднээс авч үзвэл энэ нь хүнлэг бус ба доромжилсон хэлбэртэй болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2000 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арваннэгдүгээр Ерөнхий Илтгэл, зүйл 28:

Шорон дүүргэлтийн үзэгдэл нийт Европын хэмжээнд засан хүмүүжүүлэх байгууллагын системд сөрөг нөлөө үзүүлсээр байгаа ба хорих нөхцлийг сайжруулах оролдлогод ноцтой саад болсоор байна. Шорон дүүргэлттэй холбоотой сөрөг нөлөөг өмнөх Ерөнхий Илтгэлүүдэд мөн авч үзсэн билээ. Эрүүдэн шүүхийн эсрэг Европын Хорооны үйл ажиллагаа Европ тив даяар өргөжин тэлэхийн хэрээр Хороо хүний эрхийг хасах явдлын түвшин улам өндөрсөж, үүний үр дүнд шоронгууд хэт дүүрч байгаатай байнга тулгарсаар байна. Тер өөрийн олон иргэнээ шоронд хорьсоор байгааг гэмт хэргийн түвшин итгэлтэй баталж чадахгүй байна. Энэ нь хууль хяналтын байгууллага, шүүх засаглалын нийтлэг хандлага хариуцлагагүй байгаатай зарим талаараа холбоотой

Ийм байдалд дахин шинэ шорон барих ажилд их хэмжээний мөнгө зарцуулах нь асуудлыг шийдвэрлэхгүй. Үүний оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шүүхийн мөрдэн байцаалт ба ял оноо шатанд хорих асуудал, түүнчлэн ял оноо боломжийн өөр төрлийн хэлбэр байж болох талаар нягталж үзэх нь чухал байна. Чухам ийм хандлага хэрэглэхийг Сайд нарын шорон дүүргэлт ба шоронгийн хүн ам өсөлтийн асуудал эрэлсэн Хорооны №R(99)22 тоот Зөвлөмжид уриалсан байгаа. Эрүү шүүлтийн эсрэг Европын Хороо энэ чухал баримт бичигт дурдагдсан зарчмуудыг гишүүн орнууд амьдралд хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна. Эдгээр Зөвлөмжийн хэрэгжилтэнд Европын Зөвлөл нягт хяналт тавих нь зүйтэй.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 14 дэх дүрэм:

1. Хоригдогсдыг шөнө бусадтай нь хамт байлгах шаардлага гараагүй тохиолдолд ихэвчлэн өрөөнүүдэд хуваарилан байрлуулна.

2. Нийтээр нь хамт байлгах тохиолдолд хоригдогсод энэ нөхцөлдөө бусадтайгаа харилцаж болно. Шөнийн цагаар тухайн хорих байрын тогтоосон журмаар хяналтад байна.

HYБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлууттай харьцах наад захын жишиг дүрэм”, 9 дүгээр дүрэм:

1. Хоригдлууд гяндан буюу тасалгаандаа хонодог бол хүн бүр тусдаа өөрийн гяндан юмуу тасалгаатай байх ёстой. Хэрэв түр хугацаанд широн дүүрсэн онцгой шалтгаанаар л биш бол широнгийн төв захирагаа энэ журмыг хэрэглэхээс татгалзахад хүрч нэг гяндан буюу тасалгаанд хоёр хоригдлыг байлгах нь зохимжгүй.

2. Нийтийн гяндантай газар хоригдлуудыг тэд тийм нөхцөлд хамтран амьдрах чадвартай гэдгийг магадалж онцгой нямбай сонговол зохино. Шөнийн цагт хорих газрын онцлогт тохирсон байнгын хяналт тавих хэрэгтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2000 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арваннэг дэх Ерөнхий Илтгэл, зүйл 29:

Эрүү шүүлтийн эсрэг Европын Хорооны айлчилсан зарим улс орон, ялангуяа Төв ба Дорнот Европын орнуудад хоригдогсдын амьдрах байр нь их том багтаамжтай, хоригдогсдын өдөр тутам хэрэглэдэг бүх зүйл, амрах байр, амьдралын бүс, ариун цэврийн бүх тоног төхөөрөмжийг бүхэлд нь багтаасан байдаг. Эрүү шүүлтийн эсрэг Европын Хороо хаалттай широнгуудыг ийм зарчмаар төлөвлөхийн эсрэг байгаа ба ялангуяа хоригдогсод ийм широнгуудад хэтэрхий шахагдсан, эрүүл бус нөхцөлд байгаа тохиолдолд энэ эсэргүүцэл бүүр ч ихсэж байна. Зарим улс орнуудад соёлын болон бусад төрөл бүрийн хүчин зүйлсийн нөлөөгөөр ганцаарчлан бус олноор нь хориыг илүүд үздэг болсон нь эргэлзээгүй. Гэхдээ үүнийг зөвтгэх шалтгаан нь бага бөгөөд хоригдогсод нэг байранд хэдэн арваараа хамт амьдарч, тэндээ унтаж амардаг нь эсэргүүцэл төрүүлж байна.

Олноор нь хорих өрөөнд хоригдогсод өдөр тутмын амьдралдаа ганцаараа байх боломжийг олгохгүй. Үүнээс гадна айлгах, хүчирхийлэх эрсдэл өндөртэй. Ийм зохион байгуулалттай байранд эрх зүйн зөрчил гарах, гэмт хэргийн бүлэглэл үүсэх орчин бий болж хөгжихэд түлхэц өгнө.

Нөгөө талаас албан хаагчдын зүгээс зохих ёсны хяналт тавих явдлыг хүндруулж, эсхүл ийм хяналт тавих боломжийг бүрмэсэн үгүй болгох, тэрчлэн гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр бүх хоригдогсдыг хамарсан үймээн сандраан болохоос урьдчилан сэргийлэх аргагүй байдалд оруулна. Мөн ийм байранд хоригдогсдыг тодорхой тохиолдолд эрсдэлийн түвшинг тогтоох үндэслэлээр байрлуулах боломж бараг үгүй болно. Энэ бүх асуудал хоригдогсдын тоо байж болох хэмжээнээс давсан тохиолдолд улам хүчтэй болж, түүгээр ч зогсохгүй угаалтуур, бие засах байранд нэмэлт ачаалал үүсч, хэтэрхий олон хүнд агааржуулалт хангалтгүй болж нөхцлийг улам дордуулна.

Гэхдээ Эрүүдэн шүүхийн эсрэг Европын Хороо олон хүний багтаамжтай хорих өрөөнөөс татгалзаж, цөөн хүнтэй жижиг байранд байлгахдаа хоригдогсдын зорилготой, ашигтай үйл ажиллагаа эрхлүүлэх замаар өдрийн ихэнх цагийг гадуур байлгах нь зүйтэй гэдгийг цохон тэмдэглэж байна.

## Тайлбар

Олон улсын стандартад хоригдогсдыг амьдрах байранд олноороо байснаас ганцаараа амьдрахыг нь илүүд үздэг. Гэвч олон шалтгаанаар хоригдгчийг ганцааранг нь амьдруулах боломж муу байдаг. Тэгсэн хэдий ч нэг өрөөнд хоригдогсдын тоо заавал хязгаартай байх ёстой.

Нэг өрөөнд нэгээс илүү хоригдогч амьдардаг газар хоригдогсдын дунд хүчирхийлэл үүсэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Хорих өрөөнүүдийн хэт дүүргэлт ноцтой асуудал юм. Энэ асуудал ашигтай талбай (кватрат метрээр) ба түүн дотор амьдарч байгаа хүмүүсийн тооны харьцаанаас үүсдэг.

### Түлхүүр асуулт:

- Дор дурдсан асуудлуудын хувьд хорих байрны амьдрах нөхцөл зохистой юу?
- Нэг хүнд ногдох талбайгаар (кв.м.)?
- Амьдрах байрандаа өнгөрүүлдэг хугацаагаар (цоожтой өрөөнд хоногт хэдэн цаг байдаг)?
- Амьдрах байр цоожтой үед агаарын хэмжээ ба агааржуулалт ямар вэ?
- Ямар хугацаагаар хорих төлөвтэй вэ?
- Ариун цэвэр сахихад шаардлагатай хэрэгслээр хангагддаг ўу?



## ДЭГЛЭМ БА АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Юуны өмнө энд авч үзэж буй хорих байрын дэглэм гэдэгт /ялын төрлөөс жишээ нь жир, чанга, насанд хүрээгүй гэх зэргээс гадна гадаад өртөнцтэй холбогдох харилцаа нэгэн адил хамаарна. Дэглэм нь нээлттэй байх тусмаа гадаад өртөнцтэй харилцах боломжоор илүү байна. Нийгмийн аюулгүй байдлыг хангах ба хоригдогсдыг нийгэмшүүлэхэд тэднийг гадаад өртөнцтэй холбох буюу гэр бүл, төрөл төрөгсөдтэй нь харилцаатай байлгах явдал чухал ач холбогдолтой.

Энэ бүлэгт бид хоригдогсдын дунд зохион байгуулдаг төрөл бүрийн арга хэмжээнүүдийн тухай авч үзнэ. Хоригдогсдын хувьд амьдрах байрнаасаа гадуур өнгөрүүлж байгаа цаг хугацаа, жишээ нь ажил, сургалт, түүнчлэн чөлөөт цагийг зохион байгуулалттай өнгөрүүлэх зэрэг нь чухал ач холбогдолтой байдаг.

4

### Дэглэм ба арга хэмжээ:

- Гадаад өртөнцтэй харилцаатай байх
- Боловсрол
- Эрүүл агаарт зохиогдох арга хэмжээ
- Чөлөөт цаг
- Шашин шүтлэг
- Хөдөлмөр

## ГАДААД ЕРТӨНЦТЭЙ ХАРИЛЦАХ

### Стандарт

4

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 15 дугаар зарчим:

Зарчмуудын 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар онцгойлсон боловч саатуулагдсан болон хоригдсон этгээдэд гадаад орчинтой тухайлбал гэр бүл, өмгөөлөгчтэй холбоо тогтоохыг хэдхэн хоногоос хэтрэхгүй хугацаагаар татгалзаж болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 19 дүгээр зарчим:

Саатуулагдсан болон хоригдсон этгээд тухайлбал гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах, тэдэнтэй захидаа харилцах, түүнчлэн хуулиар буюу хуульд нийцүүлж тогтоосон гадаад орчинтой харилцах эрхтэй.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 37 дугаар дүрэм:

Хоригдлуудад тогтмол цаг хугацаанд, зохих хяналтын дор гэр бүлийнхэнтэйгээ болон нэр төрдөө сэв суулгаагүй найз нөхөдтэйгээ захидаа харилцаж буюу биечлэн уулзаж харилцах боломж олгож байвал зохино.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 51:

Хоригдогод гадаад ертөнцтэй сайн харилцаатай байхыг дэмжих нь маш чухал. Юуны түрүүнд хоригдогсодод гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцаагаа таслахгүй байх боломж олгох нь зүйтэй. Гадаад ертөнцтэй холбоотой байхад нь дэмжлэг үзүүлэхийг удирдах зарчмаа болгох хэрэгтэй. Зөвхөн аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс болон материаллаг нөөцийн хангамж дутмаг байдлаас шалтгаалан ийм харилцаанд ямар нэг хязгаарлалт байж болох юм.

Үүнтэй холбогдуулан Хороо гэр бүл нь алс хол оршин суудгаас тэр бүр ирж уулзаад байж чаддаггүй хоригдогсодод утсаар холбоо тогтоох, эргэлт уулзалт авах журмыг ашиглахад нь зарим нэгэн уян хатан байдал байх хэрэгтэй гэж тэмдэглэхийг хүсч байна. Жишээ нь, ийм хоригдогчид

уулзалтын цагийг нь хадгалах, эсхүл гэр бүлийнхэнтэйгээ утсаар ярих сайжруулсан боломж олгож болох юм.

## Тайлбар

Хоригдож байгаа этгээдүүдийн дийлэнх нь хэзээ нэгэн цагт эрх чөлөөтэй болно. Тиймээс гадаад өртөнцтэй аль болох илүү холбоотой байхыг зөвшөөрч, хөхүүлэн дэмжих нь зүйтэй. Гадаад өртөнцтэй харьцах харилцаа нь гэр бүлээр хязгаарлах ёсгүй бөгөөд найз нөхөд, бусад танилууттайгаа ч харилцдаг байх нь чухал.

4

Гэр бүлийнхэнтэйгээ захидаар харилцаж, утсаар ярих боломжтой байх ёстой. Эргэлт, уулзалт бол хамгийн үр дүнтэй харилцаа юм. Эргэлт уулзалтын үеэр биечлэн уулзах боломжтой байх ёстой. Уулзалтын нөхцөл нь аюулгүй байдлын шаардлага ба хүний нэр төрийг хүндэтгэхд нийцсэн байх ёстой. Гэр бүлийнхэнтэйгээ тусдаа уулзах өрөө тасалгаа бий болгох асуудлыг урамшуулан дэмжих ёстой.

Хоригдож буй гадаадын иргэд нь ямар нэг дэмжлэггүй үлдчих магадлалтай тул байнгын анхаарлын төвд байх ёстой. Урт хугацааны уулзалтыг хол газраас ирсэн хоригдогчийн гэр бүлд боломж олгох нь зүйтэй. Хэрвээ гэр бүл нь алс байдаг бол утсаар харилцана.

### Түлхүүр асуулт:

#### Захидал харилцаа

- Хувийн захидлыг шалгадаг уу?
- Тийм бол шалгалт ямар шалгууртай ба энэ тухай хоригдогсод мэдэх үү?
- Илгээмж авах ямар нөхцөлтэй вэ?  
Гэр бүлийнхэнтэйгээ тогтоох харилцаа ба нийгэмтэйгээ холбогдох
- Гэр бүл нь уулзахыг тогтмол зөвшөөрдөг үү?
- Уулзалт ямар хугацаанд үргэлжилдэг вэ?
- Онцгой төрлийн хоригдогсдын эргэлт, уулзалтанд хязгаарлалт бий юу?
- Тийм бол ямар үндэслэлтэй вэ?
- Хоригдогсдын ар гэрийнхнийг хорих, цагдан хорих газрын ажилтнууд ямар байдлаар хүлээж авдаг вэ?
- Ийм уулзалтанд зориулагдсан материаллаг нөхцөл ямар вэ?

- Эргэлтгүй хоригдогсодод нийгмийн ямар нэгэн арга хэмжээ авдаг уу?

**Гадаад ертөнцөөс мэдээлэл авах боломж**

- Хоригдогсод мэдээллийн хэрэгсэл (сонин хэвлэл, телевиз) ашигладаг уу?
  - Аливаа хязгаарлалт бий юу? Мэдээллийн хэрэгсэл ашиглах ямар шалгуур байдаг вэ?
-

## БОЛОВСРОЛ

### Стандарт

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 28 дугаар зарчим:

Саатуулагдсан болон хоригдсон этгээд саатуулах буюу хорих газрын дэг, аюулгүй байдлын журмыг хангах нөхцлийг сахих нөхцөлд улсын эх үүсвэрээс бол ухаалаг хэмжээгээр суралцаж бичиг, уран зохиолын болон мэдээллийн материалыг авч хэрэглэх эрхтэй.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлууттай харьцах наад захын жишиг дүрэм”, 77 дугаар дүрэм:

1. Хоригдлыг шинээр боловсрол (жишээ нь шашны хүмүүжил) эзэмших нөхцөл бололцогоор хангана. Бичиг үсэггүй буюу залуу хоригдлуудыг сургалтад заавал хамруулах ба үүнд хорих газар онцгой анхаарал тавих ёстой.

2. Хоригдлыг тухайн орны боловсролын системийн дагуу сургана. Энэ нь хорих газраас суллагдсан хоригдлын цаашид суралцахад хүндрэл учруулахгүй байхад чиглэнэ.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлууттай харьцах наад захын жишиг дүрэм”, 78 дугаар дүрэм (түүнчлэн 82 дугаар дүрмийг бас үз):

Бүх хорих газарт хоригдлын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс соёл амралтын үйл ажиллагааг бололцогоор явуулах нөхцөлөөр хангавал зохино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 77 дахь дүрэм:

Хорих газар бүрд хоригдогсдын ядаж наад захын эрх ашиг, сонирхлоо хангахад чиглэгдсэн сургалтын олон талт хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн зорилго нь хоригдогсдыг нийгэмшүүлэх ажлыг цаашид улам сайжруулах, хоригдогсдыг сэтгэлийн тэнхээлэй байлгах, эргэн тойрны хүмүүстэйгээ сайн харилцах, өөрийгөө хүндэтгэх харилцааг дээшлүүлэхэд оршино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 78 дахь дүрэм (түүнчлэн 79-82 дахь дүрмийг үз):

Сургалтыг хорих тогтолцооны нэг үндсэн үйл ажиллагаа гэж үзэх бөгөөд сургалт нь бусад хөдөлмөрийн нэгэн адил эрх хэмжээнд тавигдаж, ажлын цагаар явагддаг бол төлбөртэй байна. Сургалт нь засан хүмүүжүүлэх батлагдсан хөтөлбөрт тооцогдоно.

Европын Зөвлөлийн гишүүн орнуудын Сайд нарын Хорооны 1989 оны 10 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Шоронд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай Зөвлөмж, зүйл 1:

## 4

Бүх хоригдогсод боловсрол эзэмших боломжоор хангагдах ёстай. Боловсролын хөтөлбөрт өрөнхий боловсролын хичээлүүд, мэргэжлийн сургалт, соёл олон түмний ажил, уран бүтээлийн сургалт, биеийн тамир, спортын сургалт, нийгмийн сургалтууд, номын сангийн хэрэгслүүд зэрэг багтана.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 47:

Ага хэмжээний сайн хөтөлбөр нь (ажил, боловсрол, спорт г.м) хоригдогсдын сэтгэл санааны байдалд шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Энэ нь сэжигтэн, яллагдагчийн алинд ч хамаатай. Гэтэл олон хорих, цагдан хорих газруудын үйл ажиллагаа хэтэрхий хязгаарлагдмал байгааг Хороо тэмдэглэж байна. Хоригдогч олон хонолгүй шилждэг хорих газарт үйл ажиллагаа зохион байгуулах нь амаргүй асуудал. Хоригдуудын дунд зохион байгуулдаг ажлын адилаар хүн бүхэнд хүртээлтэй байх боломжтүй нь тодорхой. Гэхдээ хоригдогсод хэдэн долоо хоногоор, хэдэн сараар хэдийгээр материаллаг нөхцлөөр сайн хангагдсан ч өрөөндөө юу ч хийхгүй түгжээтэй байж болохгүй. Тиймээс цагдан хорих байранд хоригдож байгаа сэжигтнүүд өдрийн ихэнх хэсгийг /8 цаг буюу түүнээс их/ хорих өрөөнөөсөө гадуур ямар нэг төрлийн ашигтай үйл ажиллагаа эрхэлж өнгөрөөх нь зүйтэй гэж Хороо үзэж байна. Үүний тулд хичээх хэрэгтэй юм. Хоригдлын хувьд эдгээр нөхцлүүд илүү таатай байх ёстай нь мэдээж.

## Тайлбар

Боловсрол бол хоригдогсдыг хувь хүнийх нь хувьд хөгжүүлдэг чухал хүчин зүйл бөгөөд хоригдогчийг богино хугацаанд нийгэмшүүлэхэд онцгой нөлөөтэй. Үүнээс гадна зайлшгүй хэл сурх, уншиж сурх, захидал бичиж сурх хэрэгцээг хангана.

---

**Түлхүүр асуулт:**

- Боловсролын ямар хэлбэрүүдийг санал болгодог вэ?
  - Боловсролын хөтөлбөрийг хорих, цагдан хорих газрын захиргаанаас хязгаарладаг уу?
  - Сургалтын хөтөлбөр нь хоригдогсдыг хүмүүжүүлэх зорилготой нийцдэг үү?
  - Хорих, цагдан хорих газрын захиргаа сургалтын хөтөлбөрийг бүрэн хангадаг уу?
  - Хоригдогсодод номын сан ашиглахад ямар болзолтой байдаг вэ?
  - Номын санд байгаа номнууд нь хоригдогсдын ярьдаг хэл дээр байж чаддаг уу?
-

## НАРЛУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### Стандарт

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 21 дүгээр дүрэм:

1. Эрүүл агаарт ажил хийхгүй байгаа бүх хоригдол цаг агаар тохиромжтой бол өдөр бүр дор хаяхад нэг удаа зохих биеийн тамирын дасгалыг хашаан дотор хийх эрхтэй.

2. Бага насны бөгөөд эрүүл мэндийн байдлаас шалтгаалсан хоригдлуудад биеийн дасгал хийх, тэр үедээ тоглох боломжийн дасгал хийх явдлыг хангавал зохино. Үүний тулд шаардлагатай талбай, тоноглол, төхөөрөмжтэй байвал зохино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 86 дахь дүрэм:

Гадуур гарч ажилладаггүй буюу нээлттэй биш хорих газарт байдаг хоригдогч бүр, эсхүл задгай талбайгүй хорих газрын хоригдогсодод цаг агаарын боломжтой нөхцөлд өдөрт нэг цаг эрүүл агаарт, цаг агаар таагүй нөхцөлд боломжтой бол дээвэртэй талбайд салхинд гарах, биеийн тамирын зохистой дасгал хийх боломж олгох хэрэгтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдах Ерөнхий Илтгэл, зүйл 56:

Эрүүл агаарт гарах ёстой тухай онцлон анхааруулж байна. Хоригдогсодод өдөрт ядаж нэг цаг эрүүл агаарт биеийн тамирын дасгал хийх шаардлага нь хүний эрхийг хангах үндсэн баталгаа болж байгааг нийтээр хүлээн зөвшөөрдөг болсон. Энэ шаардлага үйл ажиллагааны илүү өргөн хүрээтэй хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болбол сайнсан. Бүх хоригдогсод, тэр дундаа шийтгэл хүлээж тусгаарлагдсан хоригдогч ч ялгаагүй өдөр бүр эрүүл агаарт биеийн тамирын дасгал хийж байх нь зүйтэй гэдгийг Хороо онцлон тэмдэглэж байна. Эрүүл агаарт хичээллэх талбай нь хангальттай зйттай, цаг агаарын таагүй нөхцөлд боломжийн хирээр бүрхүүлтэй байх нь зүйтэй.

### Тайлбар

Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэмд өдөрт багаар бодоход 1 цаг биеийн тамирын дасгал хийх боломж олгохыг зөвлөдөг. Тогтоосон энэ доод хэмжээгээр дасгал хийх боломжийг бүх хоригдолд, тэр дундаа ганцаарчлан хоригдож байгаа, сахилгын байранд байгаа,

аюулгүй байдлын өндөржүүлсэн арга хэмжээ авагдаж байгаа зэрэг бүх хоригдлуудад тохиromжтой цагт нь заавал олгох ёстой. Гагчхүү эрүүл мэндийн шаардлагын дагуу тусгаарлагдсан хоригдогсодод энэ журам үйлчлэхгүй.

Бие засах, усанд орох зэргээр эрүүл ахуйн шаардлагаар өрөөндөө байхгүй байгаа цагийг тооцох ёсгүй. Хорих хугацаа хэд хоногоос илүү урт хугацаагаар үргэлжлэх тохиолдолд ганцаараа болон олуулаа хоригддог байрнаас гадна өнгөрүүлсэн хугацааг биеийн тамирын дасгалын цагт оруулж тооцохгүй.

Хоригдогсдын өрөө, байрнаасаа гадуур байх хугацааг нь тогтоохдоо өрөө, байрны дор дурдсан материаллаг нөхцөлд тулгуурлах ёстой. Үүнд:

- Ганцаарчлан болон олноор нь хорих өрөөний хэмжээ ба нэг хүнд ноогдох талбай
- Ганцаарчлан болон олноор нь хорих өрөөний байгалийн гэрэл нэвтрэх түвшин
- Ганцаарчлан болон олноор нь хорих өрөөнд биеийн тамирын дасгал хийх боломж.

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид зөвлөснөөр урьдчилан хорих байранд хоригдогсод өдөрт 8 цаг өрөөнөөсөө гадуур байна.

### **Түлхүүр асуулт:**

- Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмээр баталгаажсан наад зах нь өдөрт 1 цаг эрүүл агаарт биеийн тамирын дасгал хийх журам мөрдөгдж байна уу?
- Хорих өрөө, байрнаасаа гадуур ямар хугацаагаар байдаг вэ?
  - Ялангуяа хатуу дэглэмтэй хорих ангид
  - Аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, дэд бутцээр хязгаарлагдмал хорих, цагдан хорих газарт
  - Хяналт тавих үүрэгтэй албан хаагчдын тоо хангалттай бус хорих, цагдан хорих газарт
  - Хорих, цагдан хорих газрын барилга зохион байгуулалт нь чөлөөт талбайгүй үед
  - Онцгой байдал үүссэнтэй холбогдуулан түр хугацаагаар хязгаарлалтад орсон тохиолдолд
  - Бусад

## ЧӨЛӨӨТ ЦАГ

### Стандарт

4

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 83 дахь дүрэм:

Хоригдогсдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг зохицтой түвшинд байлгахад чиглэгдсэн биеийн хүчний болон спортоор хичээллэх, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх зэрэг зохион байгуулалтай үйл ажиллагаа чухал гэдгийг хорих үйл ажиллагаа эрхэлдэг бийгууллагууд хүлээн зөвшөөрч байна.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 84 дэх дүрэм /түүнчлэн 85 дахь дүрэм/:

Биеийн тамирын боловсрол олгох, спортоор хичээллэх, түүнчлэн чөлөөт цагийг өнгөрүүлэх бусад арга хэмжээг хорих дэглэмийн зөвшөөрөгдсөн хүрээнд зохион байгуулах ёстой. Ийм хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай талбай, төхөөрөмжүүд болон тоног төхөөрөмжийг хангах ёстой.

### Тайлбар

Хоригдож байгаа этгээд нийгмийн амьдралд байсантай адил чөлөөт цагтаа ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх, жишээ нь спортоор хичээллэх зэрэг боломжоор хангагдах ёстой. Спортоор хичээллэх нь биеийнхээ энергийг зарцуулах боломж олгож эрүүл мэндийн байдал сайжрахад нөлөөлдөг. Түүнчлэн хоригдогсод ажилтнуудтай нөхөрсөг харьцаа тогтооход нөлөөлдөг.

#### Түлхүүр асуулт:

- Хоригдогсод ямар төрлийн спортоор хичээллэх боломжтой вэ?
- Тэд өөр ямар төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжтой вэ? Энэ нь байнга байдаг уу?
- Аливаа хязгаарлалт бий юу? Тийм бол ямар шалгууртай вэ?
- Мэдээллийн хэрэгсэл (сонин хэвлэл, телевиз) ашиглах боломжтой юу?
- Хорих, цагдан хорих газрын захиргаа сонин, сэтгүүл, бусад тогтмол хэвлэлийг үнэгүй олгодог уу?

- Кино, концерт үзэх зэргээр соёлын арга хэмжээ зохиогддог уу?
  - Ялангуяа хоригдогсдын чөлөөт цагаар зохион байгуулдаг арга хэмжээний талаар энэ асуултыг бас тавих хэрэгтэй.
  - Хоригдогсод номын сан ашиглах боломжтой юу?
  - Сонин хэвлэл, телевиз ашиглах боломжтой юу?
  - Амралтын өрөө байдаг уу? Чөлөөт цагаа ямар төрлийн үйл ажиллагаа эрхэлж өнгөрүүлдэг вэ?
-

## ШАШИН ШҮТЛЭГ

### Стандарт

HYB-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан "Хориглуудтай харьцах наад захын жишиг дүрэм", 41 дүгээр дүрэм:

4

1. Хорих газарт аль нэг шашиг шүтдэг хангалттай тооны хоригдол байвал тухайн шашны мэргэжлийн ламыг томилох буюу хорих газарт зохих зан үйл явуулах зөвшөөрөл олговол зохино. Хэрэв ийм хоригдол их олон бөгөөд боломжтой бол ламыг байнга ажиллуулахаар томилно.

2. Нэгдүгээр заалтын дагуу томилогдсон буюу зөвшөөрөгдсөн мэргэжлийн лам нь шашны зан үйлийг тогтоосон цагт байнга явуулах, тухайн шашныг шүтдэг хоригдолтой ганцаарчлан уулзаж, шашны сэдвээр ярилцах боломжтой байх ёстой.

3. Аль ч шашны мэргэжлийн ламтай хоригдол уулзах боломжийг хязгаарлаж болохгүй. Нөгөө талаас хоригдол ламтай уулзахыг эсэргүүцвэл түүний хүсэлтэд бүрэн хүндэтгэлтэй хандах ёстой.

HYB-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан "Хориглуудтай харьцах наад захын жишиг дүрэм", 42 дугаар дүрэм:

Хоригдол бүр хэрэгжүүлж болох хүрээнд шашны зан үйл явуулахад оролцож, өөрийн шашны ном зохиолтой байж шашны хэрэгцээгээ хангах боломжтой байх ёстой.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 46 дахь дүрэм (туунчлэн 47 дахь дүрмийг бас ү):

Хоригдол бүрд боломжийн хирээр өөрийн шашиг шүтлэг, оюун санааны болон ёс суртахууны хэрэгцээгээ хангах, үүний тулд хорих байранд зохион байгуулагдах зан үйл, хурал цуглаанд оролцох, шаардлагатай ном, хэвлэлтэй байх зөвшөөрөл олгох ёстой.

### Тайлбар

Шашиг шүтэх, эс шүтэх эрхээ чөлөөтэй эдлэх нь хүний үндсэн суурь эрхүүдийн нэг бөгөөд хоригдогсод энэ эрхээ эдлэх боломжтой байх ёстой. Энэ эрх бол үүрэг биш. Харин хувь хүний хувьд өөрийн итгэл үнэмшлийн дагуу шүтдэг шашнаа шүтэх төдийгүй нийтээрээ шашны зан үйл үйлдэж болох эрх юм. Гэхдээ энэ эрх болон шашны байгууллагад очиж шашны

зан үйлээ үйлдэх эрхээ ашиглах боломж нь хоригдогсдын тооноос шалтгаална.

Шашны байгууллагад очих ба шашны байгууллага, түүний төлөөлөгчидтэй уулзах асуудал нь хоригдогчийн хувийн асуудал учраас ганцааарчлан уулзаж байх үед тэдний яриа ажилтанд сонсогохооргүй байх нь чухал.

## 4

### Түлхүүр асуулт:

- Шашин шүтдэг хоригдогсдын тоо ямар байвал тухайн шашны төлөөлөгчтэй уулзах зөвшөөрөл олгодог вэ?
- Тухайн хорих, цагдан хорих газарт ямар шашны байгууллага, төлөөлөгчид ирдэг вэ? Тэдгээр нь хоригдогсдын шүтдэг шашин мөн үү?
- Шашны байгууллага, төлөөлөгчид хорих, цагдан хорих газарт ажиллахын тулд ямар нөхцөл болзолыг хангаж зөвшөөрөл авдаг вэ?
- Шашны зан үйлийг хаана ба хэзээ үйлддэг вэ?

## АШИГТАЙ ХӨДӨЛМӨР

### Стандарт

4

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлууттай харьцах наад захиын жишиг дүрэм”, 71 дүгээр дүрэм (72-76 дугаар дүрмийг бас үз):

1. Хоригдлуудын хөдөлмөр нь тэднийг зовоох, шаналгах шинжтэй байх ёсгүй.
2. Бүх хоригдлууд нь эмчийн баталсан тэдний биеийн болон сэтгэл мэдрэлийн онцлогт таарсан хэмжээгээр хөдөлмөрлөх үүрэгтэй.
3. Хоригдлын жирийн ажлын өдрийг нийгэмд болон өөрт нь тустай ажлаар бүрэн хангах ёстай.
4. Хоригдлыг ажлаар хангах нь юуны өмнө тэднийг хорих газраас суллагдсаны дараа шударга хөдөлмөр эрхлэхэд нь туслах, ур чадварыг бий болгох, дээшлүүлэхэд оршино.
5. Иймд (ялангуяа насанд хүрээгүйчүүд) өөрсдөд нь тус болохуйц ажил хийхэд сургах ёстай.
6. Хэрэв хорих газрын удирдлага зохион байгуулалт дэглэм шаардлагад нийцэх бол хоригдлыг хүссэн ажлаа өөрөө сонгож хийх бололцоогоор хангах ёстай.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын широнгийн дүрэм, 38 дахь дүрэм:

1. Хорих байранд хөдөлмөр зохион байгуулалт ба арга ажиллагаа нь боломжийн хэрээр тухайн төрлийн хөдөлмөрт нийгэмд тавигддаг шаардлагатай ижил байх ёстай. Ингэснээр хоригдогсдыг нийгмийн амьдралд гарч чөлөөт хөдөлмөр эрхлэх хэвийн нөхцөлд бэлдэнэ. Тиймээс тухайн хөдөлмөр нь үйлчилж байгаа норм норматив, техникийн шаардлагад нийцэх байх ёстай бөгөөд орчин үеийн удирдлагын арга барил, үйлдвэрлэлийн процессын хүрээнд хэрэгжих ёстай.
2. Хоригдлын хөдөлмөрөөс санхүүгийн ашиг олохыг эрмэлзэх явдал нь чанаарын түвшинг дээшлүүлж, мэргэжлийн бэлтгэлийн зорилго, чиглэлийг чанаржуулахад сайн нөлөөтэй боловч хоригдогсдын эрх ашиг ба тэднийг засан хүмүүжүүлэх ажлыг энэ зорилгод хамаатуулж болохгүй.

### Тайлбар

Урьдчилан хорих газарт хоригдож буй этгээд албадан хөдөлмөр эрхлэх ёсгүй боловч хэрвээ тэд өөрсдөө хүсэлт гаргавал биеийн хүчний хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдах ёстай.

Зөвхөн хөдөлмөрийн чадвартай хоригдогсдоор ажил хийлгэж болно. Хоригдогч өвдөвөл эмнэлгийн үзлэгт оруулах ёстой. Өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдах нь ялангуяа хөдөлмөрийн хөлсийг хийснээр нь олгодог нөхцөлд түүний ажлын хөлсөнд нөлөөлж болзошгүй.

Хоригдогсдоор ашигтай хөдөлмөр эрхлүүлэх асуудал нь өргөн хүрээтэй, бас түвэгтэй сэдэв юм. Дараах хүчин зүйлүүдийг дагаж мөрдөх ёстой. Үүнд:

- Ашигтай хөдөлмөр нь шийтгэлийн шинжтэй байх ёсгүй.
- Хөдөлмөр үнэлэгдэж, шагнагдах ёстой.
- Ажлын цаг нь стандартаас илүү байх ёсгүй.
- Ажлын байранд эрүүл мэндийг хамгаалах ба аюулгүй ажиллагааг хангахдаа гадаад стандартыг хэрэгжүүлэх шаардлагатай.

4

### Түлхүүр асуулт:

- Хорих, цагдан хорих газарт ашигтай хөдөлмөр эрхлэх боломж хэр вэ?
- Хоригдогч гадуур ажил эрхлэх боломжтой юу?
- Ашигтай хөдөлмөр сайн дурын шинжтэй байдаг юу?
- Ажлын нөхцөл ба ажлын хөлс ямар вэ?
- Хөдөлмөрийн хөлсний түвшинг хэн тогтоодог вэ?
- Хөдөлмөрийн хөлсийг хоригдогсодод хаанаас хуваарилдаг вэ?
- Тийм бол хуваарилалт хэрхэн явагддаг вэ?



## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

Хорих, цагдан хорих асуудал нь хүмүүст өөрийн амьдралаар амьдрах боломж олгодоггүй учраас хоригдогсдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжиж байх нь чухал. Тиймээс хорих үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх баригчид хоригдогсдын эрүүл мэндийг хангалттай түвшинд байлгах нөхцөл, амьдрах ба хөдөлмөрлөх эрүүл нөхцөл болон холбогдох эмнэлгийн үйлчилгээгээр хангах ёстай. Түүнчлэн хоригдогсдын бие махбодийн болон сэтгэл зүйн үнэт зүйлсийг зөрчихөөр эмнэлгийн туршилт хийхийг хориглодог.

Эрүүл мэндийн үйлчилгээ нь эрх чөлөөт амьдралдаа авдаг үйлчилгээнээс ялгагдах ёсгүй.

Хорих явдал нь хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндэд нөлөөлдөг учраас эмнэлгийн үйлчилгээ нь чухал асуудал юм.

**5**

---

### **Эрүүл мэндийн үйлчилгээ:**

- Эмнэлгийн үйлчилгээ авах боломж
  - Эмэгтэйчүүд ба хүүхдийн эмнэлгийн үйлчилгээ
  - Эмнэлгийн боловсон хүчин
-

## ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БОЛОМЖ

### Стандарт

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 29 дэх дүрэм:

Хорих, цагдан хорих газар ирснээс нь хойш хамгийн богино хугацаанд, цаашдаа шаардлагатай үед нь хоригдогч бүрийг эмчийн үзлэгт хамруулж биे махбодийн болон сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тодруулж, түүний эмчлэхийн тулд шаардлагатай бүх хэрэгслийг ашиглаж, халдварт тээж байж болзошгүй хоригдогсдыг тусгаарлаж, суллагдаад нийгэмд гарахад нь саад болохуйц бие махбодийн болон сэтгэцийн гажилтыг тодорхойлж, түүнчлэн хоригдогч бүрийн хөдөлмөрлөх чадварыг тогтооно.

5

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 30 дахь дүрэм:

1. Хоригдогсдын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндэд эмнэлгийн нормонд заасны дагуу үе шаттайгаар үзлэг хийдэг, өвчилсөн, гэмтэл авсан, шархадсан болон онцгой анхаарах ёстой хоригдогсдыг үздэг эмч хяналт тавина.

2. Эмнэлгийн ажилтан хоригдогчийг цаашид хорих, эсхүл тодорхой нөхцөлд хорих нь түүний бие, сэтгэцийн эрүүл мэндэд хортой нөлөөлсөн болон нөлөөлөхөөр байгаа тохиолдол бурд энэ тухай хорих байрын даргад илтгэнэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuulagdsan болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 22 дугаар зарчим:

Саатуулагдсан болон хоригдсон этгээд өөрөө зөвшөөрсөн байсан ч эрүүл мэндийг нь муутгаж болох ямар нэг эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт явуулах ёсгүй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 33:

Шинээр ирсэн хоригдогчид хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтан тэр даруй үзлэг хийх ёстой. Хоригдогч бүрийг ирмэгц нь зохих ёсоор биеийн байцаалтыг авч, шаардлагатай бол бүтэн биений үзлэг хийх тухай Хороо тайлангууддаа зөвлөсөн. Зарим улс орнуудад шинээр ирсэн хоригдогчийг эрх бүхий сувилагч үзэж үзлэгийн дүнг эмчид танилцуулдаг журам байдгийг хэлэх нь зүйтэй. Энэ нь байгаа нөөц бололцоогоо үр дүнтэй ашиглаж байгаа хэрэг юм.

Түүнчлэн шинээр ирэгсдэд эмнэлгийн албаны үйл ажиллагаа болон хувийн ариун цэврийг сахих үндсэн арга хэмжээний тухай гарын авлага өгч байх нь зүйтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдах Ерөнхий Илтгэл, зүйл 34:

Хоригдогсод дэглэмээсээ үл шалтгаалан шаардлагатай үедээ эмчид үзүүлэх боломжтой байх ёстай. (Ганцаарчлан хоригдож байгаа хоригдогчийн эмнэлгийн үйлчилгээ авах боломжийн талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдах өрөнхий илтгэлийн зүйл 56-г үз). Эмнэлгийн үйлчилгээ нь эмчээс зөвлөгөө авах хүсэлт гаргасан тохиолдолд элдэв саадгүй гүйцэтгэгддэг байхаар зохион байгуулагдах нь зүйтэй.

Хоригдогсодод эмчид ганцаарчлан хандах, жишээ нь битүүмжилсэн дугтуйнд өргөдөл бичиж өгөх зэрэг боломж олгох ёстай. Түүгээр ч зогсохгүй тухайн хоригдогчийн эмчид үзүүлэх тухай хүсэлтийг хорих, цагдан хорих газрын ажилтнууд заавал шалгах гэж зүтгэх ёсгүй.

## Тайлбар

Хоригдогсодод үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний чанар нь хорих системийн бус нөхцөл дэх эмнэлгийн үйлчилгээний чанараас ялгагдах ёсгүй.

Хорих, цагдан хорих газруудад ажиллаж байгаа мониторингийн бүлгийн гишүүд дунд эмнэлгийн мэргэжлийн хүн байхгүй бол бүлгийн гишүүд хоригдогсдын эрүүл мэндийн байдлын талаар өрөнхий мэдээлэл буюу нийтлэг байгаа өвчлөл, халдварт болон контактын халдварт, үхлийн талаар мэдээлэл авна. Түүнчлэн эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах боломж ямар байдгийг мэдэх нь зүйтэй.

## 5

---

### Түлхүүр асуулт:

- Хоригдогсодод эмнэлгийн үйлчилгээ авах боломж ямар вэ?
  - Хэрэв тэд өөрсдөө хүсвэл ямар боломжтой вэ?
  - Эмнэлгийн ажилтнууд хоригдогсдыг тогтмол эргэдэг үү?
  - Ажилтны хүсэлтээр бол ямар шалгууртай вэ?
  - Эмнэлгийн ажилтан хоногоор жижүүрлэдэг үү?
  - Өдөр, шөнийн аль ч цагт эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтсон журам бий юу?
  - Сэтгэл зүйчид хандах нөхцөлд энэ асуудлыг хэрхэн зохицуулдаг вэ?
-

## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### Стандарт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 32:

Хоригдогч эмэгтэйчүүдийн хувьд эрүүл мэндийн тэгш эрхийн зарчмыг мөрдлөг болгон тэдний эрүүл мэндийг хамгаалах ажлыг эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч болон энэ талаар мэргэжлийн бэлтгэл хангасан эмч, сувилагч нараар гүйцэтгүүлнэ. Түүнээс гадна эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах тусгайлсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ буюу хөхний болон умайн хүзүүний хавдар зэргийг оношлох ажиллагааг эрх чөлөөтэй эмэгтэйчүүдийн эмнэлэгт үзүүлдэг эмнэлгийн үйлчилгээний адилаар гүйцэтгэнэ.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хориглуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 23 дугаар дүрэм:

1. Эмэгтэйчүүдийн хорих газар нь жирэмсэн болон төрсөн эхчүүдийг асрах тусгай өрөөтэй байх ёстай. Боломжтой газарт эмэгтэйчүүдийг хорих ангид нь бус ердийн эмнэлэгт төрүүлэхэд анхаарвал зохино. Хэрэв хүүхэд хорих ангийн доторхи эмнэлэгт төрсөн бол энэ тухай төрсний гэрчилгээнд тэмдэглэхгүй байх нь зүйтэй.

2. Хоригдол эхчүүдэд хүүхдээ өөртэйгээ байлгахыг зөвшөөрдөг бол тэдгээр хүүхдийг эхээс тусдаа байх үед нь асрах мэргэжлийн ажиллагсадтай ясли байгуулах хэрэгтэй.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 28 дахь дүрэм:

1. Боломжтой газар жирэмсэн эхийг ердийн эмнэлэгт төрүүлэх талаар арга хэмжээ авна. Гэхдээ ийм боломжгүй бол хорих ангийн эмнэлэгт хүүхэд төрүүлэх болон төрсний дараа эх, хүүхдийг асрах мэргэжлийн боловсон хүчин, зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх ёстай. Хэрвээ хүүхэд хорих газар төрсөн бол энэ тухай түүний төрсний гэрчилгээнд дурьдах ёсгүй.

2. Хэрвээ хүүхдийг эхтэйгээ үлдэхийг зөвшөөрвэл хорих байгууллага мэргэжлийн багш ажилладаг ясли байгуулж хүүхдийг эхээсээ тусдаа байгаа үед нь асарна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 27:

Хүүхэд хорих байранд болон хорих ангийн эмнэлэгт төрөх ёсгүй. Тиймээс Европын Зөвлөлийн гишүүн орнуудад жирэмсэн эхчүүдийг төрөх үед нь ердийн төрөх эмнэлэгт шилжүүлдэг тогтсон туршлагатай болжээ. Гэвч жирэмсэн эхчүүдэд эмэгтэйчүдийн үзлэг хийх, төрөх үед нь гарч нь гав хийж, эсхүл өөр аргаар ор болон тавилга хэрэгсэлд хүлэх явдалтай Эрүү шүүлтийн эсрэг Европын Хороо тулгарсаар байна. Ийм хандлага огт байх ёсгүй бөгөөд үүнийг хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон гутаасан харьцаа гэж шууд тодорхойлж болно. Ийм тохиолдолд аюулгүй байдлыг хангах өөр арга хэрэгсэл байж болно, байх ч ёстой.

## 5

### Тайлбар

Хорих, цагдан хорих газрууд эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээнд муу зохицсон байдаг бөгөөд энэ нь тэдний бие махбодийн ба сэтгэл зүйн байдалд нөлөөлдөг. Үүнээс гадна тэдэнд албан хаагчдын зүгээс урьд нь тохиолдож байгаагүй харилцаа, хүчиндүүлэх гэх зэрэг аюулд өртөх магадлалтай байдаг. Хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтнууд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулах ёстой.

Эмэгтэйчүүдийн эмчийн үйлчилгээг баталгаатай авдаг байх ёстой. Хорих байр нөхцөл, байдаа жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхэдтэй эхчүүдийн онцгой хэрэгцээг хангахад тохируулан зохицох ёстой.

#### Түлхүүр асуулт:

- Хорих, цагдан хорих газарт мэргэжлийн эмэгтэйчүүдийн эмч ажилладаг уу? Хэзээ, ямар цагт хүлээж авдаг вэ?
- Эмэгтэйчүүдийн эмчийн үйлчилгээг авахын тулд ямар болзول хангасан байх ёстой вэ?
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээ хангагддаг уу?
- Нярай хүүхэдтэй хөхүүгэл эхчүүдийн онцгой хэрэгцээ хангагддаг уу?

## ЭМНЭЛГИЙН БОЛОВСОН ХҮЧИН

### Стандарт

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 39 дэх дүрэм:

1. Хоригдогсдын бие, сэтгэлийн эрүүл мэндэд бүх хоригдогсдыг эмнэлгийн нормонд заасан үе шатлалтайгаар үздэг, мөн өвчилж, шархадсан, гэмтэл авсан хоригдогсдыг өөрсдийнх нь хүсэлтээр үздэг, түүнчлэн онцгой анхаарал шаарддаг хоригдогсдыг үздэг эмнэлгийн ажилтан хяналт тавина.

2. Хоригдогч цаашид хоригдох боломжгүй, эсхүл хорих ямар нэгэн нөхцөл эрүүл мэндэд нь хортойгоор нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байгаа тохиолдол гарах бүрд эмнэлгийн ажилтан хорих, цагдан хорих газрын даргад энэ тухай илтгэнэ.

НҮБ-ын гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хориглуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 22 дугаар дүрэм /23, 24, 25 дугаар дүрмийг бас үз/:

1. Бүх хорих байгууллага ёөрийн мэдэлд ядахдаа нэг сэтгэц судлалын зохих мэдлэгтэй эмнэлгийн мэргэжлийн ажилтантай байх ёстай. Эмнэлгийн үйлчилгээг орон нутгийн болон улсын эрүүлийг хамгаалах байгууллагуудтай нягт холбоотой зохион байгуулбал зохино. Энэ сэтгэц зүйн оношлогооны албыг шаардлагатай газарт байлагх ёстай бөгөөд сэтгэцийн гажигтай хориглуудын эмчилгээг хамрах ёстай.

2. Мэргэжлийн эмчилгээ шаардлагатай өвчтөн хоригдлыг тусгай, эсхүл ердийн эмнэлэгт хэвтүүлбэл зохино. Шоронгийн эмнэлгүүд өвчтөнийг зохих ёсоор сувилах эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмтэй байхаас гадна эмнэлгийн хангалттай мэргэшсэн ажилтнуудтай байвал зохино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 26 дахь дүрэм:

1. Хорих, цагдан хорих газар бүрд ядахдаа нэг дотрын эмч ажиллах ёстай. Эмнэлгийн үйлчилгээг тухайн орон нутгийн эрүүлийг хамгаалах байгууллагатай нягт хамтран зохион байгуулах ёстай.

2. Эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж хэрэгтэй байгаа өвчтэй хоригдогчийг нарийн мэргэжлийн эмнэлгийн байгууллага болон ердийн эмнэлэгт шилжүүлэх ёстай. Хорих, цагдан хорих газарт эмнэлэг ажилладаг тохиолдолд эмнэлэг нь байр, тоног төхөөрөмж, эм, эмийн бэлдмэл зэрэг өвчтэй хоригдогчид эмчилгээ хийх, асрахад шаардлагатай зүйлсээр болон мэргэжлийн ажилтнуудаар хангагдсан байх ёстай.

3. Хоригдогч бүр мэргэжлийн шүдний эмчийн үйлчилгээ авах боломжоо хангагдсан байх ёстай.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 35:

Хорих, цагдан хорих газрын эмнэлгийн алба нь ядахдаа амбулаториор зөвлөгөө өгөх, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх (түүнчлэн эмнэлгийн шинжтэй ортой тасагтай) чадвартай байх ёстай. Хоригдогч бүр мэргэжлийн шүдний эмчийн үйлчилгээ авах боломжтой байх ёстай. Үүнээс гадна хорих, цагдан хорих газарт ажиллаж байгаа эмч нарт мэргэжлийн эмч нарыг урьж ажиллуулах боломжийг хангасан байх ёстай.

Эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай болсон үед эмч дуудах боломж байнга байх ёстай. Үүнээс гадна хорих, цагдан хорих газарт анхны тусламж үзүүлэх чадвартай, боломжтой бол мэргэжлийн сувилагч байнга байх ёстай.

Эмчилгээ үргэлжлүүлэн хийх шаардлагатай тохиолдолд зөвхөн хоригдгчийн санаачилгад тулгуурлах нь ихэнх тохиолдолд хангалтгүй байдаг учраас эмнэлгийн ажилтнууд амбулаторийн эмчилгээнд байнга хяналт тавих ёстай.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 71:

Аль ч хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтан эрсдэлд өртөх магадлал өндөртэй байдаг. Эмнэлгийн ажилтан үйлчлүүлэгчээ (өвчтэй хоригдогч) асарч халамжлах үүрэгтэй байдгаас байнга байгууллагын захирагааны үзэл бодол болон аюулгүй ажиллагааны арга хэмжээтэй зөрчилдөх тохиолдол гардаг. Энэ нь ёс зүйн хүндрэлтэй асуудлуудыг үүсгэж, сонголт хийх шаардлага тулгадаг.

## Тайлбар

Эмнэлгийн үйлчилгээний талаар шийдвэр гаргахдаа эмнэлгийн ажилтнууд хорих, цагдан хорих газрын захирагаанаас бүрэн хараат бус байх ёстай.

Эмнэлгийн ажилтны эрх мэдлийн хэмжээ, тэдний хараат бус байдал ба мэргэжлийн ёс зүй, түүнчлэн тэдний үзүүлж байгаа эмнэлгийн үйлчилгээний чанар зэргийг зөвхөн эмнэлгийн мэргэжилтнүүд үнэлж болно.

---

**Түлхүүр асуулт:**

- Хэдэн эмч, сувилагч, сэтгэл зүйч, сэтгэцийн эмгэгийн эмч, эмнэлгийн өөр боловсон хүчинтэй вэ?
  - Тэдний үйлчилгээг авах боломжтой юу? Ямар цагаар үйлчилдэг вэ?
-



## ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИД

Хорих нөхцөлд мониторинг хийхдээ албан хаагчдын тухай мартаж болохгүй. Учир нь тэдний харьцаа болон үйл ажиллагаанаас хоригдогсод бүрэн хамааралтай байдаг.

- Харилцааны соёл ба хоригдогсдыг удирдах ажлын журмыг сайн мэдэхийн тулд:
- Албан хаагчид мэргэжлийн тусгай бэлтгэл хийсэн байх ёстой.
- Хангалттай цалинтай байх
- Хоригдогсдын тоонд шаардлагатай тооны боловсон хүчинтэй байх
- Ажлын хүнд нөхцөлд тохирсон ажлын цагтай, ажиллах нөхцөлтэй байх
- Албан хаагчдыг дараах байдлаар ангилна. Үүнд:
  - Удирдах албан тушаалтан
  - Харуул хамгаалалт эрхэлдэг албан хаагчид
  - Гадаад харуул хамгаалалт болон хяналт, аюулгүй байдлыг хангадаг албан хаагчид
  - Эмнэлгийн ажилтнууд
  - Нийгмийн ажилтнууд
  - Сургалт хариуцсан ажилтнууд /боловсрол эзэмшүүлэх, хичээллүүлэх, ажиллуулах/
  - Хяналт хариуцсан албан хаагчид

Мониторингийн багийн гишүүд хорих, цагдан хорих газарт ажиллах үедээ албан хаагчидтай харилцаж байх нь чухал. Харьцаа тогтоох нь хялбар биш боловч хорих нөхцөл нь өөрөө албан хаагчдын ажлын нөхцөл гэдгийг мартаж үл болно.

Тухайн байгууллагын үйл ажиллагаа, ажлын нөхцлийг сайжруулахын тулд хийх шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар тэдний санал, үзэл бодлыг сонсох нь илүү сонирхолтой байж болох юм.

---

### Хорих, цагдан хорих газрын албан хаагчид:

- Ерөнхий байдал
  - Мэргэжлийн бэлтгэл
-

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### Стандарт

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захишиг дүрэм”, 46 дугаар дүрэм /54 дүгээр дүрмийг бас үз/:

1. Хорих, цагдан хорих газрын удирдлага бүх төрлийн боловсон хүчинээ онцгой нягтлан сонгоход санаа тавих ёстой бөгөөд тэдний хариуцлага, хүнлэг чанар, мэдлэг, хувийн чанараас нь шоронгийн үйл ажиллагаа сайн байх эсэх ихээхэн хамаарна.

2. Хорих, цагдан хорих газрын захиргаа нь өөрийн ажилтнуудад болон олон нийтэд тэд нийгмийн онцгой ач холбогдолтой үүрэг гүйцэтгэж байгаагаа ухамсарлуулах талаар цуцалтгүй ажиллах ёстой. Энэхүү итгэлийг бэхжүүлэхэд шоронгийн захиргаа нийгмийн мэдээллийн боломжийг ашиглах ёстой.

3. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны ажилтнуудыг байнгын орон тоонд төрийн албан хаагчийн статустай шоронгийн захиргааны мэргэжлийн ажилтнуудын хувиар сайн үр дүнтэй ажиллаж, биеийн эрүүл мэндийн хувьд хүлээлгэсэн зорилгыг биелүүлж чадаж байгаа нөхцөлд албан тушаалыг нь хадгална гэдэгт итгэлтэй байлгахаар томилж байвал зохино. Тэдний ажлын хөлс нь энэ ажлыг хийж чадах чадварлаг эрэгтэй, эмэгтэй аль ч хүн татагдахаар тооцож тогтоосон байх ёстой. Энэ нь ажлын онцгой хүнд нөхцлийг нь харгалзан, эдгээр хүмүүст зохих хөнгөлөлт, ажлын нөхцлийг хангавал зохино.

Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм, 51 дэх дүрэм:

Ажилтан хорих, цагдан хорих газрын зохих ёсны удирдлагаар хангагдах, зохион байгуулалтын хувьд төлөвлөсөн зорилгоо хэрэгжүүлэх ба хоригдогсодтой харилцах харилцаанд онцгой чухал үүрэг гүйцэтгэдгийг анхааралдаа авч хорих, цагдан хорих газрын захиргаа боловсон хүчинийхээ хувьд дагаж мөрдөх журмаа нэн тэргүүний зорилт гэж авч үзэх ёстой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 23:

Хорих, цагдан хорих газарт боловсон хүчинээ аль ч хүйсийн хүмүүсээр холилдуулан бүрдүүлэх нь хэрцгий, хүнлэг бус харьцаанаас хамгаалах чухал хамгаалалт байдаг. Эдгээр боловсон хүчин эрэгтэй, эмэгтэй

Хүмүүсээс холилдон бүрдсэнээр сэтгэл зүйн уур амьсгалыг бэхжүүлэх, тодорхой түвшинд хэвийн байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2000 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арваннэг дэх Ерөнхий Илтгэл, зүйл 56:

Зохих ёсоор сонгогдож бэлтгэгдсэн, хоригдогсодтой яаж зөв харилцаа тогтоох болон өөрийн ажлаа зөвхөн ажлын байр төдийгөөр бус харин мэргэжлийн түвшинд тавьж чаддаг боловсон хүчинтэй байх нь шоронгийн хүмүүнлэг тогтолцооны тулгын чулуу гэсэн үг.

Харамсалтай нь албан хаагчид болон хоригдогсдын хооронд ёс төдий, алслагдсан шинжтэй харьцаа тогтох, хоригдогсодтой үгээр харилцахыг ёс бус зүйл мэт үздэг байдал Эрүүдэн шүүхийн эсрэг Европын Хороотой байнга тулгарсаар байна. Эрүүдэн шүүхийн эсрэг Европын Хорооны гэрчилж байгаа дараахь жишээнүүд ийм хандлагад орно. Үүнд: хоригдог албан хаагчийг дуудтал, эсхүл бусад хүмүүсийг явж өнгөртөл хана руу харж зогсоох, хорих байраар явахдаа нуруугаа ардаа үүрч, толгойгоо гудайлгах, албан хаагч бороохойгоо илт гайхуулсан шинжтэй барьж явах, эсхүл илт өдсөн шинжтэй барьж явах зэрэг болно. Аюулгүй байдлыг хангах үүднээс ингэх шаардлагагүй, албан хаагч, хоригдогсдын дунд эсрэг харьцаа үүсгэнэ.

Албан хаагчийн жинхэнэ мэргэжлийн шинж чанар гэдэг нь хоригдогсодтой харьцахдаа нэгэн зэрэг аюулгүй байдал, дэг журам анхаарал хандуулж хүнлэг энэрэнгүй, зохицтой харьцах чадвар юм. Иймд хорих, цагдан хорих газрын удирдлага боловсон хүчинээ хоригдогсод зохих ёсоор биен авч явахад бэлэн байгаа гэдэг зохих түвшний итгэлтэй байдалд чиглүүлэх ёстой. Албан хаагчид, хоригдогсдын хооронд зохион байгуулалттай, зэрэг харилцаа тогтоосноор хүчирхийллийн эрсдэл буурах төдийгүй хяналт болон аюулгүй байдлыг улам хүчтэй болгоно. Ингэснээр албан хаагчид ч ажлаасаа ихээхэн таашаал авах боломжтой болно.

Албан хаагчид ба хоригдогсдын дунд эерэг харилцаа тогтоох нь хорих бүс ба янз бүрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоригдогсдын байруудад аль ч цагт хангалттай тооны албан хаагчид байхаас ихээхэн шалтгаалдаг. Ингэж чадахгүй байгааг Европын Хорооны төлөөлөгчид байнга ажиглаж байна. Нийтдээ боловсон хүчин хүрэлцэхгүй, албан хаагчдын тодорхой тогтоосон ажлын хуваарь байхгүй байгаа нь хоригдогсодтой шууд харилцах боломжийг багасгаж, зэрэг харилцаа хөгжүүлэхэд илт саад болж, албан хаагчдын хувьд ч, хоригдогсдын хувьд ч таагүй орчныг бий болгож байна.

Боловсон хүчин хангалтгүй байгаа газарт аюулгүй ажиллагааны суурь түвшин ба байгууллагын хэвийн ажиллагааг хангахын тулд ихээхэн хэмжээгээр илүү цагаар ажиллах шаардлага тулгарч байна. Ийм байдал

нь албан хаагчдын стрессийг хэт өндөрсгөж, тэдний хүчийг барж байна. Энэ нь хорих, цагдан хорих аль ч газарт байдаг хүндрэлийг улам л ихэсгэж байна.

## Тайлбар

### 6

Хорих байгууллагын албан хаачид нь хорих газрын ерөнхий уур амьсгалыг бүрдүүлэхэд голлох үүргийг гүйцэтгэдэг. Тиймээс албан хаагчдыг ажилд авахдаа тэдний ажиллах дадал туршлага, ур чадвар, чанарыг тодорхойлох тодорхой шалгуурт үндэслэх нь зүйтэй. Тэдний цалин ажлынх нь нөхцөлд зохицсон байх ёстай. Ажилтнууд нь аюулгүй байдлыг хангах, хоригдогсодтой хүний ёсоор харьцахад хүрэлцэхүйц хангалттай тооны байх ёстай.

Эндээс үндэслэн хоригдогсод ба тэдний гэр бүл, албан хаагчдын хооронд үүссэн асуудлыг дүгнэн шинжлэх ёстай.

Хоригдогсодод хандах албан хаагчдын хандлага нь удирдах ажилтнуудаас тэдэнд өгч байгаа албан болон албан бус заавраас шалтгаална. Түүнчлэн удирдах ажилтны зүгээс албан хаагчиддаа хандах хандлага, харьцаа, мөн албан хаагчдын хүрээллийн хүмүүсийн хоригдогсодод хандах хандлага, харьцаа зэрэг нь албан хаагчдын хоригдогсодод хандах хандлага, харьцаанд нөлөөлнө.

---

### Түлхүүр асуулт:

Мониторинг хийж байгаа ТББ хорих, цагдан хорих газрын албан хаагчдын ангилаал тус бүрээс дараахъ асуудлуудад хариулт авахыг хичээх хэрэгтэй. Үүнд:

- Хоригдогсдын тоонд албан хаагчдын тоог харьцуулсан дүн
  - Эзэмшсэн боловсрол ба хувийн байдал зэрэг ажилд орох шалгуурууд
  - Ажилд орсноос хойшхи мэргэжлийн бэлтгэл
  - Дундаж цалин
-

## ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН МЭРГЭЖЛИЙН БЭЛТГЭЛ

### Стандарт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 59:

Хороо эцэст нь хууль хяналтын байгууллагын ажилтнуудын мэргэжлийн бэлтгэлд (тэр дундаа хүний эрхийн салбарын талаар мэдээлэл НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүnlэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах ба шийтгэхийн эсрэг конвенцийн 10 дугаар зүйлийг ү) чухал ач холбогдол өгч байгаагаа тэмдэглэж байна. Зохих ёсоор бэлтгэгдсэн цагдаа ба хорох байгууллагын ажилтан хоригдгосодтой хэрцгий, хүnlэг бусаар харьцахын эсрэг хамгийн сайн бэлтгэгдсэн байх ёстой. Өндөр мэргэжлийн, сайн бэлтгэгдсэн албан хаагч нь хэрцгий, хүnlэг бус харьцааг хэрэглэхгүйгээр, хоригдсон ба саатуулагдсан этгээдийн үндсэн баталгаат хүний эрхийг хангаж амжилттай харьцах чадвартай.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 60:

Энэ үүднээс Хороо, хууль хяналтын байгууллагын ажилтныг ажилд авах үндсэн шалгур нь хүнтэй харилцах чадвар хэмээн ойлгож байна. Тиймээс боловсон хүчинийг бэлтгэх сургалтын явцад хүний нэр хүндийг хүндэтгэсэн харилцааны дадлыг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. Ийм дадал эзэмшсэн цагдаа болон хорох байгууллагын ажилтан хүчирхийлэлд хүрч болзошгүй тохиолдолд ч байдлыг намжааж, харьяалагдаж байгаа байгууллагынхаа хүндрэлийг бууруулж, хэвийн ажлын түвшинг дээшлүүлж аль аль талдаа ашигтай байдлыг бий болгох чадвартай байдаг.

6

### Тайлбар

Хорих, цагдан хорох газрын албан хаагчид өндөр мэргэжилтэй, сайн бэлтгэгдсэн байх нь хорох тогтолцоог хүмүүнлэг байлгах суурь үндэс юм. Энэ бэлтгэлд хүмүүсийн хоорондын харилцаа, үүссэн асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, стрессээ удирдах зэрэг бэлтгэлүүд тодорхой байрыг эзэнэ.

---

### Түлхүүр асуулт:

- Хорих, цагдан хорих газрын албан хаагчид ямар, ямар чиглэлээр бэлтгэгдэг вэ?
  - Ажилд авах шалгуурууд (боловсрол ба хувийн байдал) ямар вэ?
  - Мэргэжлээ дээшлүүлэх ямар боломж байдаг вэ? Энэ боломжийг ашигладаг уу?
-

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД СААТУУЛАХ

Цагдаагийн байгууллагад saatuuulaх явдал богино хугацаатай, хоног өдрөөр гэхээсээ цагаар тооцогдох нь олонтаа. Saatuulagdsan хугацаа 24 цагаас хэтэрсэн тохиолдолд цагдаад баривчлагдсан этгээдийг цаашид хорих уу, эсхүл суллан тавих уу гэдэг асуудлыг шүүгч шийдвэрлэнэ. Тийм боловч баривчлагдсан эхний цагуудад хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөх аюул их байдаг. Ийм тохиолдолд хэрцгий, хүнлэг бус харьцах асуудал цагдаагийн байгууллагад saatulagdaahad хамаатай болдог.

Саатуулах хугацаа богино байдаг учраас цагдаагийн байгууллагад мониторинг хийх ажил хорих, цагдан хорих газруудад хийх мониторингоос ялгаатай. Цагдаагийн байгууллагад хүмүүс богино хугацаагаар хоригддог. Энд хорих нөхцөл материаллаг талаасаа бараг байхгүйтэй адил. Тиймээс saatulagdsan этгээд мониторингийн багийн гишүүдийг хүлээж аваахдаа их эмзэг байдаг.

Иймд цагдаагийн хэсэгт очиж тэнд хоригдогсодтой ярилцах нь маш чухал юм. Энд хүний эрхийг хангах баталгаа онцгой ач холбогдолтой болдог.

7

### Цагдаагийн байгууллагад saatuuulan хорих

- Аюулгүй байдлын үндсэн баталгаа
- Баримтжуулалт
- Байцаалт
- Мэдээлэл
- Материаллаг нөхцөл

## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН БАТАЛГАА

### Стандарт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 36:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо цагдаагийн байгууллагад saatuulagdsan этгээдийн хүний эрхийн гурван асуудалд онцгой чухал ач холбогдол өгдөг.

Энэ нь: Өөрийн сонголтоор гуравдагч этгээдэд (гэр бүл, найз нөхөд, элчин, консулын газар) баривчлагдсан тухайгаа мэдээлэх эрх, өмгөөлөгч дуудах эрх ба өөрийн үзэмжээр эмчид үзүүлэхийг шаардах эрхтэй. (урьд нь цагдаагийн байгууллагын дуудлагаар ирсэн эмчид үзүүлсэн эсэхээс үл хамаарна). Хорооны үзэж байгаагаар эдгээр эрхүүд нь тухайн эрх зүйн системд юу гэж нэрлэдгээс үл шалтгаалан хоригдож өхэлсэн мөчөөс эхлэн saatuulagdsan этгээдийг хэрцгий, хүнлэг бус харьцаанаас хамгаалах үндсэн гурван баталгаа болдог.

7

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 41:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо өөрийнхөө туршлагаар хүнийг дөнгөж хорьсны дараа айлан сүрдүүлэх, бие махбодийн хүчирхийлэл үйлдэх эрсдэл өндөртэй байдгийг нэг бус удаа тэмдэглэж байсан билээ. Тиймээс цагдаагийн байгууллагад saatuulagdsan этгээд энэ үедээ өмгөөлөгч авах боломжтой байх нь түүнийг хүчирхийллээс хамгаалах үндсэн баталгаа болно. Энэхүү боломж нь хоригдсон этгээдэд хүчирхийлэл үйлдэх хандлагатай цагдаа нарын үйлчлэлийг сааруулахаас гадна хүчирхийлэл нэгэнт үйлдэгдсэн болон үйлдэгдэж байвал өмгөөлөгч холбогдох арга хэмжээ авах бололцоотой. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо цагдаагийн мөрдөн байцаалтын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс saatuulagdsan этгээдийг түүний дуудсан өмгөөлөгчтэй уулзуулахыг тодорхой хугацаагаар хойшлуулж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ энэ нь мөрдөн байцаалтын явцад өмгөөлөгч авах эрхийг нь бүрмөсөн хязгаарлана гэсэн үг биш. Saatuulagdsan этгээдийн дуудсан өмгөөлөгчийг уулзуулах боломжгүй тохиолдолд өөр чөлөөт өмгөөлөгч авах эрх нь хангагдах ёстой.

Өмгөөлөгч авах эрх нь өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах эрхийг мөн ханагана. Зарчмын хувьд saatuulagdsan этгээд цагдаагийн ямар ч байцаалтын үед өмгөөлөгчтэй байх ёстой. Энэ нь мэдээж яаралтай асуудлаар saatuulagdsan этгээдийг байцаах шаардлага гарч, өмгөөлөгч

нь нэн даруй хүрэлцэн ирэх боломжгүй байх тохиолдолд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд саад болох ёсгүй. Эсхүл байцаалтын ажиллагаанд саад болж буй өмгөөлөгчийг сольж болохгүй гэсэн үг бас биш.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хороо зөвхөн сэжигтэн төдийгүй цагдаагийн байгууллагад очих шаардлага гарсан бусад этгээд, гэрч өмгөөлөгч авах эрхтэй гэдгийг тэмдэглэж байна.

Өмгөөлөгч авах эрхийг амьдралд бүрэн хэрэгжүүлэхийн тулд өмгөөлөгчид төлбөр төлөх чадваргүй этгээдэд ч энэ эрхээ эдлэх боломж олгох ёстай.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 42:

Хоригдож буй этгээд эмчид хандах албан ёсны боломжтой байх ёстай. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд эмчид үзүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эмч саадгүй ирэх ёстай. Цагдаагийн ажилтнууд ийм шаардлагыг хайхралгүй өнгөрөөж болохгүй. Хоригдогч хүсвэл өөрийн сонгосон эмчид үзүүлэх (урьд нь цагдаагийн газрын дуудсан эмчид үзүүлсэн байсан ч) эрхтэй.

Саатуулагдсан этгээдэд эмчийн үзлэг хийхдээ цагдаагийн ажилтнуудад сонсогодоогрүй газар, түүнчлэн эмч тодорхой тохиолдолд өөр шаардлага тавиагүй бол ажилтнуудын нүднээс далд газар хийнэ.

Мөн saatuulagdajsh baijgaad sulalagdsan etgэed shүүhэed очоогүй бол эмнэлгийн үзлэгийн (шүүх эмнэлгийн албан ёсны магадлагaa) тухай баримтыг шууд шаардаж авах эрхтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 43:

Саатуулагдсан этгээд баривчлагдсан даруйдаа энэ тухайгаа гуравдагч этгээд буюу гэр бүл, наиз нөхөд, бусад этгээдэд мэдэгдэх эрхтэй. Энэ эрх нь баталгаажсан байх ёстай. Энэ эрхийг цагдаагийн мөрдөн байцаалтын хууль ёсны эрх ашгийн үүднээс тодорхой хэмжээгээр хязгаарлаж болох юм гэдгийг Эрүүдэн шүүхийн эсрэг Европын хороо хүлээн зөвшөөрч байна. Гэвч ийм хязгаарлалт хийхдээ цаг хугацааг нарийвчлан тодорхой тогтоож, холбогдох баталгаагаар хангах ёстай. Жишээ нь: баривчлагдсан тухайгаа мэдээлэхийг татгалзаж хойшлуулахдаа энэ тухай бичгээр баримт үйлдэж шалтгааныг нь тодорхой дурьдах ба тухайн цагдаагийн байгууллагын энэ хэрэгт холбогдолгүй удирдах албан тушаалтан, эсхүл прокурор гарын үсэг зурж баталсан байна.

## Тайлбар

Саатуулагдсан этгээдийг баривчилсан эхний цагууд эрсдэл өндөртэй байдаг. Учир энэ үед цагдаагийн ажилтнууд эрхээ хэтрүүлэх магадлал их. Тиймээс түр хугацаагаар saatuuulagdsan эдгээдэд хандах цагдаагийн ажилтнуудын эрх мэдлийг тодорхой хязгаарлах шаардлагатай. Saatuuulagdsan этгээдийг баривчилсан даруйд дор дурьдсан баталгааг хангаж өгөх нь чухал гэж Европын хороо үзэж байна. Үүнд:

- Гуравдагч этгээдэд мэдээлэх
- Өмгөөлөгч авах
- Эмчид үзүүлэх боломжтой байх

## 7

### Түлхүүр асуулт:

- Саатуулагдсан этгээдэд гэр бүл болон гуравдагч этгээдэд баривчлагдсан тухайгаа мэдээлэх боломж байсан уу?
- Өмгөөлөгч авах боломж бий юу?
- Эмчийн үзлэгт орсон уу?
- Цагдаагийн байгууллагад saatuuulaх дээд хугацаа мөрдөгдсөн үү?
- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс тусдаа хоригддог уу? Насанд хүрээгүй хүмүүс насанд хүрэгсдээс тусдаа юу?
- Бусад хоригдогсдоос хамгаалагдах арга хэмжээ авагддаг уу?

## БАРИМТЖУУЛАЛТ

### Стандарт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 40:

Баривчлагдсан, saatuulagdsan, хоригдсон бүх этгээдийг бүртгэж тоолдог нэгдсэн тогтолцоотой байвал нэг талаас тухайн этгээдийн эрхийг хамгаалах найдвартай баталгаа бүрдэж, нөгөө талаас цагдаагийн ажилтны ажил тодорхой хэмжээгээр хөнгөлөгдх юм. Энэ бүртгэлд баривчлагдсан этгээд хэзээ хоригдсон, ямар шалтгаанаар ийм арга хэмжээ авагдсан, эрхийг нь хэзээ танилцуулсан, биедээ ямар нэгэн гэмтлийн шинжтэй эсэх, сэтгэцийн эмгэгийн ямар нэгэн шинж илэрсэн эсэх, төрөл садан, зөвлөх, өмгөөлөгчтэй хэзээ уулзсан, хэзээ эргэлт авсан, хэзээ хооллосон, хэзээ байцаасан, хэзээ шилжүүлсэн болон хэзээ сулласан гэх зэргээр тухайн этгээдтэй холбоотой бүх асуудлыг тусгасан байвал зохино. Saatuulagdsan этгээд ямар өмч эзэмшдэг, эсхүл эрхийнх нь тухай танилцуулсан эсэх болон эрхээ эдэлсэн, эдлэхээс татгалзсан зэрэг тодорхой асуудлуудаар тухайн этгээдийн гарын үсгийг авах бөгөөд гарын үсгээ зураагүй бол шалтгааныг заана. Үүнээс гадна saatuulagdsan этгээдийн өмгөөлөгч энэ бүртгэлийг үзэх боломжтой байх ёстай.

7

### Тайлбар

Бүртгэлд хоригдсон этгээдийн талаар чухал мэдээлэл бичгээр хийгдэж хадгалагддаг учраас чухал баталгаа байдаг. Бүртгэлд янз бүрийн мэдээллийд агуулагддаг учраас олон төрлийн дэвтэрт бичигддэг. Ийнхүү бүртгэл хийж мэдээлэл боловсруулах нь чухал боловч юуны өмнө баривчлагдсан цаг хугацаа, шалтгаан, байцаалт, шилжүүлэг, гуравдагч этгээдэд мэдээлэх гэх зэргээр баривчлан saatuulah үйл ажиллагааны бүх мэдээллийг зайлшгүй шалгах шаардлагатай. Түүнчлэн saatuulagdsan этгээд хоригдож байх хугацаандаа баривчлагдсанаа эргэцүүлэн бодож чадах уу, үгүй юу гэдгийг тодорхойлох шаардлагатай бөгөөд энэ тухай бүртгэдэг үү? Тийм бол бүртгэл хөтөлдөг вэ гэдгийг мэдэх нь чухал.

---

### Түлхүүр асуулт:

- Дараах мэдээллүүд бүртгэлд орсон уу? Үүнд: хэзээ баривчлагдсан, хэзээ байцаагдсан, хэзээ шилжүүлсэн болон сулласан, гуравдагч этгээдэд хэзээ мэдэгдсэн, тухайн этгээдэд эрхийг нь танилцуулсан уу? Хэзээ эмчийн үзлэгт орсон, хэзээ өмгөөлөгч уулзсан, хэзээ гуравдагч этгээдтэй уулзсан, хоол хүнсний хангамж ямар вэ? Хэзээ ямар хоол хүнс өгдөг вэ?
  - Тэмдэглэлийг тогтмол, нарийн тодорхой хөтөлдөг үү?  
Саатуулах дээд хугацаа мөрдөгдсөн үү?
-

## БАЙЦААЛТ

### Стандарт

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 23 дугаар зарчмын:

1. Saatuuлагдсан болон хоригдсон этгээдийг байцаах, байцаалтын хоорондох завсралагааны үргэлжлэх хугацаа түүнчлэн байцаалт авч байгаа албан тушаалтан, түүнд оролцож байгаа бусад хүмүүсийн овог нэрийг хуульд заасан хэлбэрээр тусгаж баталгаажуулна.

2. Хуульд заасан тохиолдолд saatuuлагдсан болон хоригдсон этгээд, түүний өмгөөлөгч энэ зарчмын 1 дүгээр хэсэгт заасан мэдээлэл авах эрх эдэлнэ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 39:

Байцаалт хийх тухай цагдаагийн ажилтанд зориулсан маш тодорхой журам буюу удирдамж байх нь зүйтэй гэдгийг Эрүүдэн шүүхийн эсрэг Европын хороо үзэж байна. Журам буюу удирдамжид дараах асуудлуудыг тусгах ёстой. Үүнд: байцаалтад оролцож байгаа хүний тухай (нэр, хувийн дугаар г.м.) мэдээлэх, байцаалт явуулах зөвшөөрөгдсөн хугацаа, байцаалтын хооронд амрах хугацаа, байцаалт дундуур завсралага хийх хугацаа, байцаалт хийхээр зөвшөөрөгдсөн газар, saatuuлагдсан этгээдийг зогсож байцаалт өгөхийг шаардах боломж, согтуу болон хар тамхинд мансуурсан этгээдийг байцаах г.м. Байцаалт эхэлсэн болон дууссан хугацаа, байцаалтын үед saatuuлагдсан этгээдийн гаргасан бүх хүсэлт, байцаалтын үеэр байлицсан бүх хүмүүсийн тухай тэмдэглэлийг заавал хөтлөхийг шаардах нь зүйтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 36:

Цагдаагийн байцаалтын тухай аудио, видео бичлэг хийх нь saatuuлагдсан этгээдэд хэрцгий хандахгүй байх баталгаа болно. Ийм систем нэвтрүүлж байгаа улс орны тоо олон болж байгааг Хороо тэмдэглэхдээ таатай байна. Бичлэг хийх нь байцаалтын явцыг бүрэн дүүрэн буулгаж авах, хэрцгий, хүнлэг бус харьцсан тухай гомдлыг мөрдөн шалгах ажлыг ихээхэн хөнгөрүүлнэ. Түүнчлэн бичлэг нь цагдаагийн ажилтан: Хэрцгий, хүнлэг бус харьцсан, баривчлагдсан сэжигтэн

яллагдагчид хүч хэрэглэсэн, сэтгэл зүйн дарамтанд оруулсан хэмээн гүтгэгдсэн тохиолдолд цагдаагийн ажилтны буруугүйг нотлоход ашигтай.

Нөгөөтэйгүүр ийм бичлэг нь түрүүчийн байцаалтанд мэдүүлснээсээ буцсан яллагдагчид боломж олгохгүй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 34:

Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг мэргэжлийн бэлтгэл хангасан ажилтан байцаана. Юуны өмнө байцаалтынхаа зорилгыг маш тодорхой тогтооно. Байцаалтын зорилго нь мөрдөн байцаагчийн хүсэж байгаа зүйлийг сэжигтнээр хэлүүлэхэд бус гагцхүү мөрдөгдөж байгаа гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход шаардлагатай мэдээлэл авахад оршино. Үүний тулд мөрдөн байцаагч мэргэжлийн зохих бэлтгэлтэй байхаас гадна сэжигтнийг байцаах байцаалтын кодексоо зөв хийж чаддаг байх нь чухал.

## 7

### Тайлбар

Байцаалт авах нь байцаалт өгч байгаа хүний хувьд өртөмтгий байдал үүсгэдэг байж болох онцгой эмзэг үе юм. Тиймээс мониторингийн багийн гишүүд байцаалтыг хэрхэн явуулдаг, ялангуяа үргэлжлэх хугацаа, хүч хэрэглэсэн эсэх болон хэл амаар сүрдүүлж, доромжилсон талаар тодорхой мэдээлэл авах шаардлагатай.

#### Түлхүүр асуулт:

- Тухайн этгээдэд хүч хэрэглэсэн үү?
- Тийм бол баривчлах үед үү? Байцаалт явуулахдаа юу?
- Доромжлох, айлган сүрдүүлэх зэргээр сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байсан үү? Одоо үргэлжилсээр байгаа юу?
- Байцаалтыг ямар нөхцөлд явуулдаг вэ?
- Байцаагдаж байгаа этгээдэд ажилтан өөрийгөө хэн болох тайлбар хийсэн үү? Байцаалт ямар хугацаагаар үргэлжилдэг вэ? Байцаалт явуулах үеэр завсарлаж байна үү?

## МЭДЭЭЛЭЛ

### Стандарт

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр saatuuлагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 10 дугаар зарчим:

Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтгааныг баривчлах үед мэдээлж аливаа сонгосон ялыг түүнд нэн даруй мэдэгдэх ёстой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 44:

Хоригдсон этгээд өөрийн эдлэх ёстой эрхээ мэдэхгүй бол эрх нь үнэ цэнээ алддаг. Тиймээс цагдаагийн газар saatuuлагдсан этгээдэд түүнд ойлгогдох хэлээр эрхийг нь нэн даруй танилцуулах шаардлагатай. Энэ эрхийг хангахын тулд цагдаагийн байгууллага saatuuлагдсан этгээдэд түүний эрхийг баталгаажуулсан гарын авлага өгөх нь зүйтэй. Саатuuлагдсан этгээд эрхтэйгээ танилцсан тухайгаа баталгаажуулж гарын үсэг зурсан байвал зохино.

7

### Тайлбар

Баривчлагдсан этгээд хоёр төрлийн мэдээлэл авах эрхтэй байдаг. Нэгдүгээрт: түүнд баривчилсан шалтгааныг мэдэгдэх ёстой. Хоёрдугаарт, түүнд эрхийг нь танилцуулсан байх шаардлагатай. Эдгээр мэдээллийг өгөхдөө баривчлагдсан этгээдэд ойлгомжтой хэлээр танилцуулна. Баривчлагдсан этгээд бичиг мэддэггүй бол амаар танилцуулна.

---

#### Түлхүүр асуулт:

- Ямар шалтгаанаар баривчилснаа нэн даруй мэдэгдсэн үү?
  - Эрхийг нь танилцуулсан уу? Амаар уу, бичгээр үү?
  - Ойлгомжтой хэл дээр байсан уу?
-

## МАТЕРИАЛЛАГ НӨХЦӨЛ

### Стандарт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 47:

Цагдаагийн хэсэгт хорих өрөөнүүд нь цэвэрхэн, хоригдож байгаа хүмүүст хангалттай зйтай, шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй (байгалийн гэрлийг илүүд үзнэ) байвал зохино. Амрах боломж олгосон сандал, ширээтэй (сандал, ширээний хөлийг нь шаланд бэхэлсэн байна), хонох хүнд зориулагдсан цэвэр гудас, хөнжилтэй байна. Цагдаагийн байгууллагад saatuuulagdsan этгээд боломжийн нөхцөлд бие засах, нүүр гарваа угаах боломжоор хангагдана. Үндны цэвэр усаар саадгүй хангагдах ба хоол хүнсийг тогтоосон цагт нь өгнө. Халуун хоолыг өдөрт ядаж нэг удаа өгөх ёстой. 24 цаг болон түүнээс урт хугацаагаар saatuuulagdsan этгээдийг өдөр бүр нарлагаанд гаргах ёстой.

7

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 43:

Цагдаагийн газар хорих өрөө ямар хэмжээтэй байвал зохистойг тогтоох нь түвэгтэй асуудал юм. Учир нь энэ асуудал их олон хүчин зүйлээс шалтгаална. Гэхдээ Хорооны төлөөлөгчид үлгэрчилсэн зөвлөмж шаардлагатай гэж үзээд дараах шалгуурыг тогтоожээ. Энэ шалгуурыг стандарт гэж үзэх хэрэгтэй. Энэ нь: ойролцоогоор 7 метр квадрат. Нэг хананаас нөгөө хана хүртэл 2 метр, түүнээс их байсан ч болно. Тааз хүртэл 2.5 метр байна.

### Тайлбар

Саатуулах хугацаа богино байдаг учраас материаллаг нөхцөл нь ч хязгаартай байна. Жишээ нь saatuuulaah байр нь хоногоор хорих байрнаас хэмжээгээрээ бага байж болно. Байрны хэмжээ бага байх тусам saatuuulaah хугацаа богино байна. Хороо saatuuulaah өрөөний хэмжээг ойролцоогоор 7 метр квадрат, нэг хананаас нөгөө хана хүртэл 2 метр, тааз хүртэл 2.5 метр байхаар шалгуур тогтоожээ.

Саатуулах байр нь байгалийн гэрэлтүүлэгтэй, агааржуулалттай, дулаан нь тухайн улирлын байдал болон цаг агаарын байдалд зохицсон байх ёстой. Saatuuulagdsan этгээд тэнд хоноглохоор бол гудас, хөнжил өгнө.

Саатуулах байранд бие засах газар байх нь ховор үзэгдэл учраас бие засах асуудлыг шийдвэрлэх нь онцгой чухал асуудал.

---

### Түлхүүр асуулт:

- Саатуулах байранд хэдэн хүн хоригддог вэ? Хэт дүүрэх хандлага бий юу?
  - Байгалийн гэрэлтүүлэгтэй юу?
  - Дулаан нь тохирч байна уу?
  - Сандал, ширээ, гудас байна уу?
  - Хоол хүнс, халуун хоол өгсөн үү?
  - Үндны цэвэр ус уух боломж байна уу?
  - Бие засах газар ашиглаж болох уу?
-



## ХАВСРАЛТ

- 1** Асуултуудын жагсаалт
- 2** Хорих, цагдан хорих газарт ажилласан тухай тайлан гаргах загвар
- 3** Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт Протокол
- 4** Хэрэгцээтэй хаягууд
- 5** Нэмж үнших материалууд
- 6** Олон улсын хэм хэмжээний жагсаалт



## Хавсралт 1. Асуултуудын жагсаалт

### ХАНДЛАГА

- Эрүүдэн шүүсэн ба хэрцгий, хүнлэг бус харьцсандаа буруутгах
- Хүч хэрэглэсэн болон бусад хэлбэрээр хүнлэг бус харьцсан
- Ганцаарчлан хорьсон

### ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

#### Хоригдогсдын тухай мэдээлэл

- Шинээр ирсэн хоригдогчийг хүлээн авсан тухай мэдээлэл
- Гуравдагч этгээдэд мэдэгдэх боломж
- Процессын гадаад хэм хэмжээг хэрэглэх боломж

#### Сахилгын арга хэмжээ болон шийтгэл

- Сахилгын арга хэмжээ болон шийтгэл оноох явцын талаар товч дурьдах
- Сахилгын арга хэмжээ авах эрх бүхий байгууллагын бүтэц
- Давж заалдах өргөдөл гаргах боломж
- Шийтгэлийн төрөл ба түүнийг хэрэглэх давтамж (хувиар тооцно)
- Баривчлах үед хийх эмчийн үзлэг
- Шийтэлийн төрөл, түүний статистик бүртгэл, шийтгэл оноох шалтгаан
- Сахилгын байр

#### Гомдол гаргах, шалгуулах журам

- Гомдол гаргах, шалгуулах журам
- Шалгалтыг бусдаас хараат бусаар хийх боломж
- Шалгалт хийх боломж (чөлөөтэй ба үр дүнтэй байх)

#### Хоригдогсдыг дэглэмээр ялгах

#### Бүртгэлүүд

## МАТЕРИАЛЛАГ НӨХЦӨЛ

### Хоригдогсдын тоо (мониторинг хийх үеийн)

- Хоригдогсдын тоо дэглэмээр
- Гадаадын иргэдийн эзлэх хувь
- Нас, хүйсээр нь ялгах

### Хорих өрөөнүүд

- Өрөө дүүргэлтийн хэмжээ ба түвшин, нэг өрөөнд байрлах хоригдогсдын дундаж тоо
- Материаллаг нөхцөл: гэрэлтүүлэг, агааржуулалт, тавилга, эд хэрэгсэл, эрүүл ахуй нөхцөл
- Ариун цэвэр – эрүүл ахуйн нөхцөл

### Хоол хүнс

- Хоол (чанар, хэмжээ, нэр төрөл, хооллох хугацаа)
- Тусгай хоол (эмнэлгийн, соёлын болон шашны шалгуураар)

### Хувийн ариун цэвэр

- Усанд орох газар (цэвэр байдал, хоригдогсдын усанд орох хугацаа, ажил хийж байгаа хоригдогсод усанд орох хугацаа)
- Эрүүл ахуйн нөхцөл (хорих өрөөнд, хорих өрөөнөөс гадна)
- Цагаан хэрэглэл (чанар, эдэлгээ, цагаан хэрэглэл солих хугацаа)
- Угаалгын газартай эсэх

## ДЭГЛЭМ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Цагийн хугацаар

- Хорих өрөөнд өдөрт нь өнгөрүүлдэг хугацаа
- Өдөр бүрийн дасгалд зориулсан хугацаа
- Ашигтай хөдөлмөр эрхлэхэд зориулсан хугацаа
- Хорих өрөөнөөс гадуур өнгөрүүлдэг хугацаа
- Спортоор хичээллэх хугацаа
- Бусад арга хэмжээнд зориулсан хугацаа

### Хорих ангиас зохион байгуулдаг ажлууд

- Ашигтай хөдөлмөр: ажлын төрөл, түүнийг гүйцэтгэдэг хоригдлын хувь, заавал гүйцэтгэх ажил, шагнал урамшуулал, нийгмийн даатгал, ажлын байрны зураглал
- Боловсрол: боловсрол эзэмших боломж, хорих ангиас зохион байгуулдаг сургалтууд (бичиг үсэг шинээр сурагсдад өдөр бүр зарцуулдаг хугацаа, ерөнхий боловсролын болон дээд боловсролын сургалт), хичээлийн давтамж, хичээлийг зохион

байгуулагсад, сургалт явуулдаг хүмүүс, боловсрол эзэмшиж байгаа хоригдлын хувь, сургалтын байрын зураглал

Чөлөөт цаг: чөлөөт цагийн төрөл, чөлөөт цагтай байх боломж, чөлөөт цагаа өнгөрүүлэх байрны зураглал, спортоор хичээлэх газрын нөхцөл, зураглал, номын сан.

Шашны зан үйл: шашны байгууллагын төлөөлөгчид (шүтдэг шашны төрөл, хүрэлцэн ирдэг шашны байгууллагын төрөл, шашны зан үйл үйлдэх боломж, түүний давтамж, шашны зан үйлийн үргэлжлэх хугацаа), шашны зан үйл үйлддэг байрны боломж

#### **Гадаад өртөнцтэй холбоо тогтоох**

- Эргэлт уулзалт: давтамж, эргэлт уулзалт хийх эрх авах нөхцөл, үргэлжлэх хугацаа ба явц, эргэлтээр төрөл төрөгсөд, хүүхдүүд, ивээн тэтгэгчид ирэх боломж
- Захидал харилцаа ба илгээмж: давтамж болон тавигдах шаардлага
- Утсаар ярих: давтамж ба нөхцөл

#### **ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

##### **Эмнэлгийн үйлчилгээ авах боломж**

- Шинээр ирэгсдийг эмчийн үзлэгт оруулах
- Эмнэлгийн үйлчилгээ авах боломж ба эмчид үзүүлэх журам
- Тусгаарлах байр: орны тоо, тоног төхөөрөмж
- Курс эмчилгээнд хамрагдсан хоригдогчдын тоо

##### **Эмнэлгийн ажилтнууд**

- Эмч, сувилагч, сэтгэц судлаач, сэтгэл зүйч болон эмнэлгийн бусад мэргэжилтүүдийн тоо

#### **ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИД**

- Нийт тоо (албан тушаалын зэрэглэл тус бүрээр)
- Харуул хамгаалалтын ажилтнууд ба хоригдогсдын харьцаа  
Удирдах албан тушаалтнууд ба хоригдогсдын харьцаа
- Ажилтны мэргэжлийн бэлтгэл (анхан шатны, мэргэжил дээшлүүлэх)



## Хавсралт 2. Хорих, цагдан хорих газарт ажилласан тухай тайлан гаргах загвар

---

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### Байгууллагын тухай ерөнхий тойм

- Байгууллагын нэр
- Байгууллагын төрөл
- Хаяг

#### Байгууллагын удирдах албан тушаалтнууд

- Байгууллагын даргын овог нэр
- Орлогч даргын овог нэр

#### Уулзалтын явцын талаар ерөнхий тойм

- Уулзалт хийх огноо
- Түрүүчийн уулзалтын огноо
- Уулзалтын багийн гишүүдийн овог нэр

### БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

#### Тухайн байгууллага дахь хүний тоо

- Захиргааны ажилтнуудын тоо
  - Хүний дундаж тоо
  - Уулзалт хийх анхны өдөр байсан хоригдогсдын тоо (дэглэм, хүйс, яс үндэс)
  - Гадаадын иргэдийн эзлэх хувь
  - Гадаадын иргэдийн хоригдсон шалтгаан
  - Хүйсээр нь ялгах
  - Насанд хүрээгүй хоригдогсод
  - Өндөр настай хоригдогсод
- Байгууллагын бүтэц
- Байгууллагын зураглал (барилга байшингийн тоо, барилга байшингийн нас, барилгын байдал, засвар үйлчилгээ, аюулгүй байдлын тогтолцоо)
  - Хорих өрөөнүүд ба нийтийн зориулалттай байрны зураглал

## УУЛЗАЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

**Уулзалтын өмнөх ярилцлага – хэлэлцсэн асуудал:**

**Хорих нөхцөл ба зөвлөмж**

- Хоригдогсдын хувьд
- Байгууллагын дарга, албан хаагчдын хувьд
- Уулзалтын үеэр илрүүлсэн зөрчлийн хувьд

**Уулзалтын дараахъ ярилцлага**

- Хэлэлцсэн асуудлууд
- Олсон хариултууд

**Шаардлагатай арга хэмжээнүүд**

- Ойрын хугацаанд
- Урт хугацаанд

**Холбоо харилцаа**

**Уулзалтын давтамж**

**Дараагийн уулзалтын үеэр тодруулах шаардлагатай асуултууд**

## Хавсралт 3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн нэмэлт протокол

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тавиндолдугаар чуулганы 2002 оны арван хоёрдугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор баталсан.

Протоколд НҮБ-ын Нью-Йорк дахь Төв байранд 2003 оны хоёрдугаар сарын 4-нөөс (Протоколын эх бичвэрийг үйлдсэн огноо) эхлэн гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн ороход нээлттэй.

### ОРШИЛ

Энэхүү Протоколд оролцогч улсууд,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх нь хүний эрхийг ноцтой зөрчих бөгөөд хориглох ёстой гэдгийг дахин нотолж,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц (цаашид “Конвенц” гэж нэрлэнэ)-ийн зорилгод хүрэхэд болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйл ажиллагааг зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авахыг үүрэг болгосныг дахин нотолж,

Конвенцийн 2, 6 дугаар зүйл нь оролцогч улс бүрт шүүн таслах харьяалалдаа байгаа аливаа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйл ажиллагааг зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авахыг үүрэг болгосныг дахин нотолж,

Эдгээр зүйлийг хэрэгжүүлэх нь оролцогч улсын үндсэн үүрэг болохыг болон эрх чөлөөгөө хасуулсан этгээдийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх, тэдгээрийн хүний эрхийг сахих нь бух нийтийн үүрэг бөгөөд олон улсын байгууллага үндэсний арга хэмжээг бэхжүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрч,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэхэд боловсролыг дээшлүүлэх болон хууль тогтоох, захирагааны болон шүүхийн буюу бусад арга хэмжээг хослуулан авах шаардлагатайг эргэн санаж,

Хүний эрхийн Дэлхийн Бага хурлаас эрүү шүүлтийг устгах арга хэмжээ, юуны түрүүнд түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэх ёстой гэж шийдвэртэй мэдэгдсэн болон Конвенцийн хорих байрыг тогтмол эргэж байх хамгаалалтын тогтолцоог бий болгох зорилготой нэмэлт протоколыг батлахыг уриалсныг эргэн санаж,

Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалахын тулд хорих байранд нь тогтмол эргэх замаар шүүхийн бус арга хэмжээг илүү эрчимжүүлж болно гэдэгт итгэл төгс байж

Дараах зүйлийн талаар хэлэлцэн тохиролцов:

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### НИЙТЛЭГ ЗАРЧИМ

#### 1 дүгээр зүйл

Энэхүү протоколын зорилго нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын болон үндэсний хараат бус байгууллагаас эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг саатуулгадж байгаа байранд нь тогтмол эргэж байх тогтолцоог бий болгоход оршино.

#### 2 дугаар зүйл

1. Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дэргэд энэхүү протоколын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс Урьдчилан сэргийлэх дэд хороо (цаашид “Урьдчилан сэргийлэх дэд хороо” гэнэ)-г үүгээр байгуулж байна.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо ажлаа НҮБ-ын Дүрмийн хүрээнд явуулж, түүний зорилго, зарчмыг болон хоригдож байгаа этгээдтэй харьцах талаар НҮБ-аас тогтоосон хэм хэмжээг удирдлага болгоно.

3. Урьдчилан сэргийлэх дэд хороо нь нууцлалыг хадгалах, шудрага ёсыг эрхэмлэх, сонгож харьцахгүй байх, нийтлэг болон бодит байдлаар хандах зарчмыг мэн удирдлага болгоно.

4. Урьдчилан сэргийлэх хороо болон Оролцогч улсууд энэхүү протоколыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллана.

### **3 дугаар зүйл**

Оролцогч улс тус бүр үндэсний төвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх /цаашид үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага гэнэ/ зорилгоор хорих байгууллагад тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

### **4 дүгээр зүйл**

1. Оролцогч улс тус бүр нь энэхүү протоколын дагуу 2, 3 дугаар зүйлд заасан тогтолцоонд өөрийн хэрэг шүүн таслах харьялал, эсхүл хяналтад байгаа бөгөөд төрийн байгууллага захиран тушааснаар, эсхүл зааснаар, эсхүл илд далд зөвшөөснөөр хүн хоригдож байгаа /цаашид хоригдож байгаа газар гэнэ/ аливаа газар очих зөвшөөрөл олгоно. Ийнхүү очих нь дээрх хүмүүсийг эрүү шүүлт, бусад хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байна.

2. Энэ протоколд “хорих” гэдэгт бүх хэлбэрээр цагдан хорих болон шоронд хорих, эсхүл хувь хүнийг шүүхийн, захиргааны болон бусад эрх бүхий байгууллагын тушаалаар төрийн болон хувийн газар харуул хамгаалалтанд байлгах болон тухайн этгээд йирийн хүсэлтээр түүнээс гарч явах боломжгүй байхыг хэлнэ.

## **ХОЁРДУГААР ХЭСЭГ**

### **Урьдчилан сэргийлэх дэд хороо**

### **5 дугаар зүйл**

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо 10 гишүүнтэй байна. Протоколыг соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон 50 дахь бичиг баримтыг хадгалуулсаны дараа дэд хорооны гишүүдийн тоо 25 болно.

2. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд ёс суртахууны өндөр төвшинтэй, шүүн таслах ажиллагааны дадлага туршлагатай, ялангуяа эрүүгийн хууль, хорох болон цагдаагийн байгууллагын, эсхүл хороидж байгаа хүмүүстэй харьцдаг салбарт мэргэшсэн хүмүүс байна.

3. Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүтцэд оролцогч улсууд газар зүйн байршил, соёл иргэншлийн болон эрх зүйн тогтолцооны хувьд тэнцвэртэй төлөөлөлөөр хангагдах ёстой.

4. Энэ бүтцэд мөн жендерийн төлөөлөлийг эрх тэгш, үл ялгаварлан гадуурхах үндсэн дээр тэнцвэртэй хангах ёстой.

5. Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүрэлдэхүүнд нэг оролцогч улсыг төлөөлсөн 2 гишүүн байж болохгүй.

6. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн нь хувь хүнийхээ хувьд хороонд ажиллах бөгөөд тэдгээр нь хараат бус, шудрагаар болон үр ашигтайгаар үүргээ гүйцэтгэнэ.

## 6 дугаар зүйл

1. Оролцогч улс тус бүр энэ зүйлийн 2 дахь заалтын дагуу Протоколын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан болон зохих мэргэшлийн 2-оос илүүгүй нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлж, тэдгээрийн мэргэшлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлнэ.

2. а/ Нэр дэвшигч нь энэ протоколын оролцогч улсын харьят байна.

б/ Хоёр нэр дэвшигчийн аль нэг нь нэр дэвшүүлж байгаа оролцогч улсын харьят байна.

в/ Нэг оролцогч улсын 2-оос илүүгүй иргэний нэрийг дэвшүүлж болно.

г/ Аль нэг оролцогч улс өөр оролцогч улсын харьятын нэрийг дэвшүүлсэн нөхцөлд тухайн улсын зөвшөөрлийг авсан байна.

3. Сонгууль явагдах хурал болохоос 5-аас доошгүй сарын өмнө НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсуудад 3 сарын дотор дэд хорооны гишүүнд нэр дэвшүүлэхийг санал болгосон захидал илгээнэ.

Ерөнхий нарийн бичгийн дарга нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийг цагаан толгойн дэс дарааллаар байрлуулж, нэр дэвшүүлсэн улсыг нь зааж хуралд оролцуулна.

## 7 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг дараах журмаар сонгоно:

а/ Энэхүү протоколын 5 дугаар зүйлийн шаардлага хангагдсан эсэхийг нэн тэргүүнд авч үзнэ.

б/ Анхны сонгуулийг энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор явуулна.

в/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг оролцогч улсууд нууцаар санал хураах журмаар сонгоно.

г/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн 2 жил тутам зарлан хуралдуулдаг оролцогч улсуудын хурлаас сонгоно. Энэ хуралдаанд оролцогч улсуудын 2/3 оролцсон нөхцөлд хүчин төгөлдөр байна. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнээр хамгийн өндөр санал авсан нэр дэвшигч сонгогдох бөгөөд хуралд оролцогчдын үнэмлэхүй олны санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

2. Сонгуулийн явцад нэг оролцогч улсын 2 харьяат нэгэн зэрэг Урьдчилан сэргийлэх дэд хороонд сонгогдох боломжтой болвол илүү олон тооны санал авсан нь Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн болно. Хоёр нэр дэвшигч нь тэнцүү тооны санал авсан нөхцөлд дараах журам үйлчилнэ.

а/ Хоёр нэр дэвшигчийн аль нэгийх нь харьяалах оролцогч улс дэвшүүлсэн бол тухайн этгээд Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн болно.

б/ Хоёр нэр дэвшигчийн хоёулангийн нэрийг харьяалах оролцогч улс дэвшүүлсэн бол нэр дэвшигч тус бүр дээр нууцаар санал хураана.

в/ Хоёр нэр дэвшигчийн нэгийх нь ч нэрийг харьяалах оролцогч улс дэвшүүлээгүй бол нэр дэвшигч тус бүр дээр нууцаар санал хураана.

## 8 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн нас барсан, огцорсон, эсхүл аливаа шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол тухайн гишүүний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс энэ хуулийн 5 дугаар зүйлийн

шаардлагыг хангасан, зохих мэргэшилтэй, энэ албан тушаалд тохирох өөр хүний нэрийг дараагийн хурал хуралдах хүртэл хугацаагаар зохих эрх мэдлийн тэнцвэрийг хадгалах шаардлагыг харгалзан дийлэнхи оролцогч улсууд баталсан нөхцөлд ажиллуулахаар дэвшүүлнэ. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нэр дэвшүүлсэн тухай мэдэгдсэнээс хойш 6 долоо хоногийн дотор оролцогч улсуудын тал болон түүнээс дээш хувь нь нэр дэвшигчийг эсэргүүцээгүй тохиолдолд нэр дэвшигчийг баталсанд тооцно.

### **9 дүгээр зүйл**

